



Антараах үхэр

2
1983

АНАГААХ УХААН

ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ ЯАМ

13 дахь жилдээ

№ 2 (46)

1983 он

Эрдэм шинжилгээ практикийн улирал тутмын сэтгүүл

АГУУЛГА

ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

| | | |
|-------------------------------|---|----|
| Мо. Шагдарсүрэн, Б. Баатархүү | Хүүхдэд гэрээр үзүүлэх эмнэлгийн тусламжийг боловсронгуй болгох асуудалд | 3 |
| Д. Намжил | —Ажиллах хүчиний нөхөн үйлдвэрлэлд эрүүлийг хамгаалах салбарын роль | 5 |
| В. И. Промтов, Л. Ролзодмаа | —Аймгийн нэгдсэн эмнэлэг нь хөдөөний хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламжийг боловсронгуй болгох зохион байгуулалт арга зүйн төв мөн | 9 |
| Г. Зуунай | —Эрүүлийг хамгаалах салбар дахь хөдөлмөрийн нөөцийн ашиглалт, эмч мэргэжилтний өгөөжийг сайжруулах арга зам | 11 |
| Т. Самбуудолгор | —Жирэмсэн эх, эмэгтэйчүүдийн диспансерийн хяналтыг боловсронгуй болгох арга зам | 16 |

СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

| | | |
|--------------------------------------|--|----|
| Б. Дэмбэрэл | —БНМАУ-д эмнэлгийн боловсон хүчин бэлтгэсэн түүх, их эмч нарын бүрэлдхүүнд хийсэн зарим судалгааны дүнгээс | 23 |
| Н. Жамбалдорж, Д. Мангаа | —Зүрх судасны өвчний анагаах зарим эмийн хэрэглээний статистик судалгаа | 31 |
| Д. Батмөнх | —Хүн амын ерөнхий өвчлөлний судлахад түүвэр судалгааны аргыг хэрэглэх нь | 34 |
| А. Ламжав, Б. Нямжав, А. Ойдовсамбуу | —Урал чихэр өвс тарималжуулсан судалгааны зарим дүнгээс | 37 |
| Б. Доржготов | —Гол байралын өмөн үүсэхэд нөлөөлөх үндсэн хүчин зүйлүүд | 40 |
| Б. Гоош, Ч. Пунцаг | —Ясны архаг үрэвслийг эмчлэх асуудалд | 46 |
| Г. Зориг. | —Алтайн хойлгийн булчингийн эдэд агуулагдах макро ба микроэлементийн улирлын хөдлөл зүй | 49 |

МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛГӨӨЛЛӨВЛӨЛ, ТОЙМ

| | | |
|--|---|----|
| Ц. Цэрэгмаа, Г. Сүхбат, Ш. Жигжидсүрэн | —Бөөрний дээд булчирхайн эмгэгийн гаралтай артерийн дараалт ихсэлт | 54 |
| Л. Баяр | —Нярай ба хөхүүл хүүхдийн тархины төрөлхийн гэмтэл түүний оношилгоо, эмчилгээ | 57 |
| Д. Мөнхчулуун | —Цусны эргэлтийн цочмог дутмагшлийн үеийн сэхээн амьдруулах эрчимт эмчилгээ | 61 |
| Д. Дариймаа | —Үр аяндаа зулбасан эмэгтэйн хоногийн шээсний прегнандиолын хэмжээ | 64 |
| Д. Цэвээндорж | —Хайрст улдийг Тосон нуурын үс шавраар эмчилж байгаа нь | 67 |
| Р. Даваасүрэн | —Бөөрний архаг дутагдалтай хүмүүсийн хоолны эмчилгээ | 68 |
| Г. В. Алфимов а, | С. Цэцэгмаа—Эмийн сангийн жоронд тохиолдож буй зарим шингэн эмийн хэлбэрт химийн шинжилгээ хийх тухай | 74 |
| Ё. Очирсүх | —Гялтангийн гадуурх кесар зүслэг хийх аргачлал | 76 |

ТУРШЛАГА СОЛИЛЦЬЁ

| | | |
|--|---|----|
| Л. Н. Гирля, Ш. Жигжидсүрэн, П. Банзрагч, Х. Рагчаасүрэн | —Бета рецептор саатуулах эмийг зүрх судалын практикт хэрэглэх нь | 79 |
|--|---|----|

МЕДИЦИНА

МИНИСТЕРСТВО ЗДРАВООХРАНЕНИЯ

Выходит с 1970 г

№ 2 (46)

1983 г

Научно-практический ежеквартальный журнал

СОДЕРЖАНИЕ

ОРГАНИЗАЦИЯ ЗДРАВООХРАНЕНИЯ

| | |
|---|----|
| Мө Шагдареурен, Б. Баторху —Пути совершенствования оказания медицинской помощи детям на дому | 3 |
| Д. Намжил —Роль здравоохранения в воспроизводстве рабочей силы | 6 |
| В. И. Промтov, Л. Ролзодма —Аймачная объединенная больница-как организационно-методический центр по совершенствованию медицинской помощи сельскому населению | 9 |
| F. Зунай —Пути улучшения эффективности использования врачебных кадров и трудовых ресурсов в области здравоохранения | 11 |
| Д. Самбудолгор —Пути усовершенствования диспансерного наблюдения беременных женщин и матерей | 16 |

ИССЛЕДОВАНИЯ

| | |
|---|----|
| В. Дэмбэрэл — Некоторые результаты изучения истории медицинского образования и подготовка медицинских кадров в МНР | 23 |
| Н. Жамбалдорж Д. Манга —Статистические данные употребления сердечно-сосудистых средств | 31 |
| Д. Батмух — Применение выборочного метода для изучения общей заболеваемости населения | 34 |
| A. Намжав, Б. Нямжав, А. Ойдовсамбу —Некоторые результаты изучения культивирования солодки | 37 |
| Б. Доржготов —Главные факторы, способствующие возникновению рака основных пяти локализации в условиях МНР | 40 |
| Б. Гем, Ч. Пунцаг —К вопросу лечения хронического гематогенного остеомиелита | 46 |
| Г. Зориг —Сезонная динамика содержания макро и микроэлементов в мышечной ткани алтайского улара | 49 |

ОБЗОРЫ, ЛЕКЦИИ, КОНСУЛЬТАЦИИ

| | |
|--|----|
| Ц. Цорегма, Г. Сухбат, Ш. Жигжидсурэн Артериальная гипертония при заболеваниях недостаточности надпочечной железы | 54 |
| Л. Баар Диагностика и лечение врожденной родовой травмы новорожденного и грудного ребенка | 57 |
| Д. Менхчулүн —Реанимация при внезапной недостаточности кровообращения | 61 |
| Д. Дарима —Содержание прогнандиола в суточной моче при спонтанном аборте | 64 |
| Д. Цөвөндорж —Лечение псoriasis грязями из озера Тосон | 67 |
| Р. Давасурэн —Диета при хронической почечной недостаточности | 68 |
| Р. В. Алфимова, С. Цэцэгма —Методика химического анализа некоторых жидких лекарственных форм, встречающихся в рецептуре аптек | 74 |
| Э. Очирсүх —Методы кесарева сечения на наружной слизистой оболочке | 76 |

ОБМЕН ОПЫТОМ

| | |
|---|----|
| Д. Н. Гирая, Ш. Жигжидсурэн, П. Банзрагч, Х. Рагчасурэн —Применение блокаторов бета-рецепторов в кардиологической практике | 79 |
|---|----|

ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

МО. ШАГДАРСҮРЭН, Б. БААТАРХҮҮ

ХҮҮХДЭД ГЭРЭЭР ҮЗҮҮЛЭХ ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛД

ЭХ НЯЛХСЫГ ХАМГААЛАХ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН

Гэрээр үзүүлэх эмчлэн сэргийлэх тусlamж бол эмнэлэг үйлчилгээний чухал хэлбэр юм. Хүүхдэд гэрээр үзүүлэх эмнэлгийн тусlamжинд гэрийн тусlamж, яаралтай тусlamж, гэрийн эмчилгээ, гэрээр хийх арнуун цэвэр, урьдчилан сэргийлэх, халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээнүүд хамарагдана.

Гэрийн тусlamжийг дараах хүүхдэд үзүүлнэ. Үүнд:

1. Нярай хүүхэд
2. Шинээр өвчилсөн хүүхэд
3. Хурц халдварт өвчтэй болон халдварт өвчний сэжиг бүхий хүүхэд.
4. Биеийн байдал хүнд байгаа хүүхэд
5. Эмнэлгээс гэртээ гарсан хүүхэд
6. Хурц халдварт өвчтэй хүнтэй шууд хавьтсан хүүхэд зэрэг болно.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1971 оны 418 дугаар тогтоолд „Ор хүрэлцээгүй байдлыг харгалзан зарим аймгийн төв, хотод хүүхдийн гэрийн стационар зохион байгуулж, улс ардын аж ахуй соёлыг хөгжүүлэх жил бүрийн төлөвлөгөөний дагуу ажиллуулахаар“ заажээ. Тогтоолын заалтыг хэрэгжүүлэх үндсэн дээр БНМАУ-ын Эрүүлийг хамгаалах Яам, Сангийн Яамын сайдын 1972 оны 319/23 тоот тушаалаар „Хүүхдийн гэрийн стационарын эмчилгээ явуулах журмын тухай“ заавар батлагдан гарч мөрдөгдөж байна.

1980 онд Улаанбаатар хотод гэрийн эмчилгээнд хамрагдсан 765 хүүхдийн материалд судалгаа хийв.

Гэрийн эмчилгээнд хамрагдсан хүүхдийн насын байдлыг үзэхэд 0—3 сартай 7,4 хувь, 4—6 сартай 11,7, 7—12 сартай 23,3, 1—3 насын 45,9, 4—7 насын 8,9, 8—16 насын 2,8 хувь байв.

Гэрийн эмчилгээ шийдвэрлэсэн эмчийн ажлын байдлыг үзэхэд хүүхдийн хэсгийн эмч 96,5 хувь, хүүхдийн яаралтай тусlamжийн эмч 2,6 хувь, танил эмч 0,9 хувийг үзэж гэрийн эмчилгээнд хамруулжээ.

Хүүхдийн хүйсийг үзэхэд эрэгтэй 52,5 хувь, эмэгтэй нь 47,5 хувь байв. Өвчин эхэлснээс хойш эмчид үзүүлсэн хугацааг үзвэл эхний хоногт 14,3 хувь, 1—2 хоногт 35,4, 2—3 хоногт 26,6, 4—7 хоногт 14,1 ба түүнээс дээш хоногт 4,5, эмчид үзүүлээгүй нь 4,9 хувь байв.

Хүүхдийн өвчилсөн жилийг сараар авч үзвэл I сард 7,9 хувь, II сард 5,5, III сард 18,4, IV сард 9,6, V сард 11,4, VI сард 4,5, VII сард 2,1, VIII сард 2,2, IX сард 4,9, X сард 11,2, XI сард 13,7, XII сард 8,7 хувийг зээлж байв.

Хүүхдийн гэрээр эмчлүүлсэн шалтгааны байдлыг эмчийн тавьсан өвчний оношоор үзвэл уушгины үрэвсэл 81,5 хувь, өмсгалын дээд замын халдварт 10,9, энтероколит 2,8, бронхит 1,4, биж, үжил халдварт, тэжээлийн доройтол, чихний үрэвсэл өвчин 3,4 хувийг эзэлж байв.

Хийсэн шинжилгээнээс үзэхэд нийт эмчилгээнд хамрагдсан хүүхдийн дөнгөж 24,9 хувь, цусны 25,3 хувь, шээсний 24,9 хувь, рентгений 24,9 хувьд нь бактериологийн шинжилгээ хийсэн байна.

Эмчийн узлэгийн байдлыг үзэхэд 1—2 удаа 1,4 хувь, 3—4 удаа 15,4 хувь, 5—7 удаа 64,3 хувь, 8 ба түүнээс дээш удаа 18,9 хувьд нь узлэг хийсэн байна.

Гэрээр эмчилсэн хүүхдийн эмчилгээний дүнгээс үзэхэд 60,5 хувь нь эдгэрч, 38,3 хувь нь сайжирч, 1,2 хувьд мэдэгдэхүйц өөрчлөлт гаралаагүй байв.

Гэрийн эмчилгээний ор хоногийг авч үзэхэд 5 хүртэлх хоног 1,1 хувь, 5—10 хоног нь 54,1 хувь, 11—20 хоног 43,2 хувь, 21—30 хоног нь 1,3 хувь, 30 ба түүнээс дээш хоног эмчилсэн 0,3 хувь нь байв.

Гэрийн эмчилгээний хугацаанд заршуулсан эмийг үнээр үзэхэд 15 төгрөг хүртэлх 14,5 хувь, 15—25 төгрөг 30,6, 25—35 төгрөг 14,4, 35—45 төгрөг 13,8, 45—55 төгрөг 13,3, 55—65 төгрөг 6—5, 65—75 төгрөг 3,5, 75—85 төгрөг 1,7, 85—95 төгрөг 1,5, 95 ба түүнээс дээш төгрөг заршуулсан 0,2 хувь байв.

Гэрээр эмчилсэн хүүхдийн нэг хоногт хэрэглэсэн эмийн үнэ 5 төгрөг хүртэл 84,9 хувьд, 5,6 төгрөг 9,4, 6—7 төгрөг 2,3, 7—8 төгрөг 1,8,8 ба түүнээс дээш төгрөг зарцуулсан нь 1,6 хувийг эзэлж байна.

Хүүхдийн гэрийн эмчилгээнд хүүхдийг зөв сонгон гвах, шаардлагатай оношилгоо, эмчлэн сувилах тусламжийг наадууд нь үзүүлэх, хүүхдийн биеийн тухайн байдалд зөв дүгнэлт өгөх, хүүхдийг арчлан сувилах, эмчлэхэд эмч, сувилагч, эцэг эх, гэр бүлийн хүмүүсийн хамтын идэвх санаачилга, анхаарал халамжийг нэгтгэн чиглүүлэх, гэрийн эмчилгээний баримт бичгүүдийг зааврын дагуу бүрэн хөтлөх, үр ашигт судалгаа дүгнэлт хийх явдал шаардагдаж байна.

Хүүхдийн эмнэлгийн яаралтай тусламжийн дотор эрчимтэй эмчилгээ, сэхээтэн амьдроулах асуудал орчин үеийн хүүхдийн эмнэлэг үйлчилгээний нэг зангилаа асуудал болж байна. МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс „Эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах ажлыг цаашид сайжруулах арга хэмжээний тухай“ 1979 онд гарсан тогтооолоор хот, аймгийн хүүхдийн больници, тасгуудад 2—6 ортой сэхээн амьдроулах палат байгуулах болж, түүнд байвал зохих эмнэлгийн багаж төхөөрөмжийн жагсаалтыг баталсан юм.

Хүүхдийн эмнэлгийн яаралтай тусламжийг эмнэлэгт хэвтүүлэхийн өмнөх ба дараахь үе шатны (эмнэлэгт хэвтсэн үеийн) гэж ерөнхийд нь хоёр шаттай зохион байгуулна. Хүүхдийн эмнэлгийн тусламжийн үр ашиг нь эмнэлгийн яаралтай тусламжийг дээрх хоёр үе шатанд хэрхэн зохион байгуулнаас ихээхэн шалтгаалах учир хүүхдийн эмнэлэг үйлчилгээний шатлал, цэг салбарт эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх нөхцөл боломж бүх талын бэлтгэлийг хангасгын байх шаардлагатай.

Улаанбаатар хотын хүүхдийн нэгдсэн 2-р эмнэлгийн яаралтай тусламжийн салбарын 1979 оны үйл ажиллагаанд хамрагдсан хүүхдийн материалыд судалгаа хийв.

Судалгааны дунгээс үзэхэд хүүхдийг насны бүлэглэлээр бүх дуудлаганд эзлэх хувийн жин 0—3 сартайд 15,3 хувь, 4—6 сартайд 9,7, 7—12 сартайд 12,2, 1—3 настайд 35,1, 4—7 настайд 13,3, 8—16 настайд 14,4 хувь байв.

Дуудлага дуудсан шалтганыг бүх дуудлаганд эзлэх хувийн жингээр үзэхэд бөөлжсөн 4,9, халуурсан 82, татсан 2,0, ухаан алдсан 0,8, шалтган тодроогүй 1,6, эмнэлэгт хэвтүүлсэн 8,7 хувь байв.

Дуудсан шалтганыг эмчийн төвсэн өвчний сношоор бүх дуудлаганд эзлэх хувийн жингээр үзэхэд уушгины урэвсэл 21,1, амьсгалын дээд зөмын халдварт 44,1, интероколит 6,3, биж 2,6, нярайн өвчин 1,5, халдварт өвчин 3,7 бусад өвчин 20,7 хувь нь байв.

Дуудлагын эмчээс үзүүлсэн эмнэлгийн тусlamжийн байдлыг бүх дуудлаганд эзлэх хувийн жингээр үзэхэд зөвлөлгөөн өгсөн 2,7, эм бичиж өгсөн 74,5, эмнэлэгт хэвтүүлэх илгээлт өгсөн 22,8 байв.

Хүүхдэд эмнэлгийн тусlamж үзүүлсэн хугацааны байдлыг бүх дуудлаганд эзлэх хувийн жингээр үзэхэд 30 минутын дотор 41,1, нэг цагийн дотор 19,4, 1—2 цагийн дотор 33,2, 3—4 цагийн дотор 5,0, 5—6 цагийн дотор 0,3, 7 ба түүнээс дээш цагийн дотор 0,4 хувь байв.

Хүүхдийн яаралтай тусlamжийн зорим үзүүлэлтийг тодорхойлоход Улаанбаатар хотын Сүхбаатарын райсны үйлчлэх хүрээнд мянган хүүхэд тутамд ногдох яаралтэй тусlamжийн дуудлага нь 353,6 тохиолдол, нэг хоногт ногдох дундаж дуудлага 52,4, нэг цагт ногдох дундаж дуудлага 2,2, нэг дуудлаганд ногдох дундаж хугацаа ойрслцсогоор 32 минут байв.

Хүүхдийг эмнэлэгт хэвтүүлэхийн өмнө ба дараахь уе шатны эмнэлгийн ярглтай тусlamжийг зөв зохион байгуулж улсын Хүүхдийн клиникийн төв эмнэлгийн эрчимт эмчилгээний болон сэхээн амьдруулж төөнийг бэхжүүлж аймаг, хот, район, төвлөрсөн суурин газар, сум дундын эмнэлгүүдэд эрчимт эмчилгээний болсон сэхээн амьдруулах тасаг, цэг байгуулж тэдгээрийг мэргэжлийн боловсон хүчин, тоног төхөөрөмж, эм хэрэгслэлээр хангах шаардлагатай байна. Хүүхдийг эмнэлэгт хэвтүүлэхийн өмнөх уе шатны эмнэлгийн яаралтай тусlamжийг дараахь байдлаар зохион байгуулна. Үүнд:

1. Хүүхдийн ярглтай тусlamжийн сэлбарууд үйлчлэх хүрээний хүүхдэд эмнэлгийн яаралтай тусlamж үзүүлнэ.

2. Түргэн тусlamжийн (станцын) дуудлагын эмч нар тухайн тохиолдсон нөхцөлд эмнэлгийн яаралтай тусlamж үзүүлнэ.

3. Эмнэлгийн түргэн тусlamжийн төрөлжсөн мэргэжлийн бригад тухайн тохиолдсон нөхцөлд эмнэлгийн яаралтай тусlamж үзүүлнэ.

4. Хүүхдийн эмнэлгийн сэхээн амьдруулах бригад тухайн тохиолдсон нөхцөлд эмнэлгийн яаралтай тусlamж үзүүлнэ. Үүнтэй холбогдуулан Улаанбаатар хотын түргэн тусlamжийн станцын төрөлжсөн мэргэжлийн бригэдэг бэхжүүлэх, улсын хүүхдийн клиникийн төв эмнэлэгт хотын хэмжээнд үйлчлэх хүүхдийн сэхээн амьдруулах бригад зохион байгуулах, бусад хот, аймгийн төв, төвлөрсөн суурин газруудад эмнэлгийн түргэн тусlamжийн дуудлагыг төрөлжүүлэн хүүхдийн дуудлагыг тусгаарлан салгаж, хүүхдийн эмнэлгийн яаралтай тусlamжийн сэлбаруудыг зохион байгуулж хүүхдийн эмч нар, авто машинаар хангаж тухайн дээсгэр нутагт хүүхдийн эмч, эмнэлгийн яаралтай тусlamжийг дагнаж гүйцэтгүүлэх шаардлагатай байна. Аймгийн нэгдсэн ба сум дундын эмнэлэг, хүүхдийн эмнэлгийн байгууллага хүүхдэд яаралтай тусlamжийг цаг үед нь үзүүлэхийн тулд дараахь нөхцөл боломжийг хангавал зохино. Үүнд:

1. Бүх шатны эмнэлгийн байгууллагуудыг хүүхдэд эмнэлгийн тусlamж үзүүлэхэд шаардлагатай материал-техник, тоног, төхөөрөмж, эм хэрэглэлээр хангасан байх.

2. Эмчлэн сэргийлэх болон хүүхдийн эмнэлгийн байгууллагын бүх эмч, ажилтан нар хүүхдэд эмнэлгийн яаралтай тусlamж үзүүлэх талаар зохих мэдлэг, дадлага туршлагыг эзэмшсэн байх.

Хот, аймгийн төв, төвлөрсөн суурин газруудад эмнэлгийн түргэн тусlamж, хүүхдийн яаралтай тусlamж, хүүхдийн хэсгийн үйлчилгээг

зөв зохион байгуулах, уялдаа холбоог нарийн чанд тогтоох нь дуудлага давхардах явдлыг зохицуулахад шийдвэрлэх рольтой.

Эмнэлгийн түргэн тусламжийн дуудлага төрөлжсөн мэргэжлийн бригад, хүүхдийн эмнэлгийн сэхээн амьдруулах бригад, хүүхдийн эмнэлгийн яаралтай тусламж, хүүхдийн хэсгийн үйлчилгээ нь тухайн нөхцөлд хүүхдэд цаг үед нь эмнэлгийн яаралтай тусламжийг үзүүлэхэд давхардах, нэг нь нөгөөгийнхөө үйл ажиллагааг үргэлжлүүлэн хүч нэмэгдүүлж бэхжүүлэх явдал мэдээж юм.

Хүүхдийн эмнэлгийн яаралтай тусламжинд хүүхдийн эмч нар дагнан ажиллаж, хүүхдийн хэсэг ажиллаж байгаа (өдрийн цагт) үйлчлэх хүрээний дэвсгэрт хүүхдийн эмнэлгийн яаралтай тусламж үзүүлж, эмнэлэгт хэвтүүлэх шаардлагатай хүүхдийг хэсгийн эмчийн илгээлтийн бичгээр холбогдох эмнэлэгт хэвтүүлиэ. Хүүхдийн эмнэлгийн яаралтай тусламжийн салбар нь хүүхдийн хэсгийн үйлчилгээний дараах үед (17 цагаас хойш өглөө 8,9 цаг хүртэл) үйлчлэх хүрээний дэвсгэрт хүүхдийн эмнэлгийн гэрийн тусламж, хүүхдийн эмнэлгийн яаралтай тусламж, шаардлагатай хүүхдийг эмнэлэгт хэвтүүлэх ажлыг хариуцаж түйцэтгэнэ. Хүүхдийн эмнэлгийн яаралтай тусламжийн дуудлага хоногийн турши харилцаан адилгүй учир ачаалал ихсэх (17, 24 цаг хүртэл) үед хот район, аймгийн төвүүдэд эмч, авто машины тсог тодорхой цгацаар нэмэгдүүлэх шаардлагатай. Хүүхдийн хэсэг, хүүхдийн эмнэлгийн яаралтай тусламжийн салбарын хооронд хүүхдийн эмнэлэгт үйлчилгээний уялдаа холбоог нарийн чанд тогтоож мөрдүүлбэл зохино.

Хүүхдийн эмнэлгийн стационарын үе шатны эмнэлгийн яаралтай тусламж нь эмнэлгийн нөхцөлд шинээр хэвтсэн хүнд өвчтэй хүүхэд, хэвтэж байгаа үедээ хүндэrsэн хүүхдэд эмнэлгийн яаралтай тусламжийг цаг үед нь бүрэн дүүрэн үзүүлэхэд чиглэнэ.

Үүнтэй холбогдуулан хүүхдийн эмнэлэг, хүүхэд хэвтэж эмчлүүлдэг бүх шатны эмчлэн сэргийлэх байгууллагад хүүхдийн эмнэлгийн яаралтай тусламжийг үзүүлэх дээрх нөхцөл боломжийг бүрэн хангах ёстой.

Хот, аймгийн төв, төвлөрсөн суурин газруудад, хүүхдийн эмнэлтийн яаралтай тусламжинд хүүхдийн нэгдсэн эмнэлэг хүүхдийн эмнэлэг, томоохон тасгуудад оношилгооны хурдавчилсан арга нэвтрүүлэхийн тулд ажлын бус цагаар клиник, биохимийн лаборант, рентген техникийт зэлжийн жижүүрийн журмаар ажиллуулэх шаардлагатай. Хүүхдийн эмнэлгийн стационарын үе шатны яаралтай тусламж, эрчимт эмчилгээ, сэхээн амьдруулах ажиллагааг зөв зохион байгуулснаар эмнэлэгт хэвтээд хоног болоогүй эндэгдлийг бууруулах нэг бодитой арга хэмжээ болж чадна.

Д. НАМЖИЛ

АНГИЛЛАХ ХҮЧНИЙ НӨХӨН ҮЙЛДВЭРЛЭЛД ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ САЛБАРЫН РОЛЬ

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Социалист үйлдвэрлэлийн харилцаа нь ажилчдын бкейн болон оюуны хүчийг бүх талаар хөгжүүлэх тэдний соёл техникийн түвшин, материаллаг аж байдлыг хэлбэрэлтгүй дээшлүүлэх нөхцөлийг хангаж

байдаг. Иймд социалист нийгэм дэх ажилчдын болон тэдний гэр бүлийн биений ба оюуны хүчийг бүх талаар нөхөн сэргээх материаллаг аж байдал, соёлын хэмжээг байнга дээшлүүлэх нь ажиллах хүчний нөхөн үйлдвэрлэлийн үндсэн асуудал болдог. Ажиллах хүчний нөхөн үйлдвэрлэл нь нийгмийн нөхөн үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн хэсэг учраас үйлдвэрлэл, хуваарилалт, ашиглалтын шатуудыг хамарч явагддаг. Иймд ажиллах хүчний нөхөн үйлдвэрлэлийн процесст эруүлийг хамгаалах бусад салбарын нөлөөлөх нөлөөллийг нөхөн үйлдвэрлэлийн шат тус бурд нарийвчилан авч үзэх нь онцгой ач холбогдолтой юм.

Ажиллах хүчний нөхөн үйлдвэрлэлд үйлдвэрлэлийн шат онцгой байр эзэлдэг. Энэ шатанд нийт ажиллах хүчийг байнга нөхөх, түүнийг биений болон оюуны бүх талаар хөгжүүлэхтэй холбогдсон чухал асуудлуудыг тусгаж байдаг. Ажиллах хүчний үйлдвэрлэлийн шатанд хүн амыг эх нялхсын байгууллага, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, тусгай мэргэжлийн сургууль, техникум, дээд сургуулиар мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөдөлмөрийн насанд хүргэх үеийг хамарч явагддаг. Энэ утгаар ажиллах хүчний нөхөн үйлдвэрлэлийн үйлдвэрлэлийн шат нь дунджаар нэг ажилтанд 18—24 хүртэл жил хамрагдаж байна. ЗХУ болон социалист бусад оронд нэг ажилтны хөдөлмөрийн насанд шилжих боломжит дээд хугацааг багасгах талаар их анхаарч байна. Үүний тулд ерөнхий боловсролын сургуульд зургаан наснаас сургах, дунд сургуульд мэргэжлийн чиг баримжaa олгох, хөдөлмөр, техникийн боловсрол эзэмшүүлэх ажлуудыг явуулж байна.

Өнгөрөгч VI таван жилд улс ардын аж ахуйн салбарт ерөнхий боловсролын сургуулиас 35 мянган залуучуудыг шилжүүлж 12,2 мянган дээд, 20,6 мянган тусгай дунд боловсролтой мэргэжилтэн, 74,0 мянган мэргэжилтэй ажилчдыг техник мэргэжлийн сургуулиар бэлтгэн гаргасан байна.

Дээрх баримтаас үзэхэд нэг ажилтны хөдөлмөрийн насанд шилжих дундаж хугацаа 19,5 жилээр тооцогдож байна.

Шинэ таван жилд дээд тусгай дунд боловсролтой 44,0 мянган мэргэжилтэн, 55,0 мянган мэргэшилтэй ажилчин бэлтгэн гаргахаар төлөвлөж байна.

Ажиллах хүчний үйлдвэрлэлийн шатанд хөдөлмөрийн насны хүн амыг бүх талаар бэлтгэхтэй холбогдуулан улсын төсвөөс зориулах хөрөнгийг байнга нэмэгдүүлж байна. Энэ зориулалтаар мөнгөн хөрөнгийг хүн амыг бүх шатны сургуульд сургах тэдний эруул мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, биений тамир, спортын болон бусад томоохон арга хэмжээнд хуваарилж байна.

1979 онд манай оронд явуулсан тооллогын дүнгээс үзэхэд 16 нас хүртэлх хүүхэд залуучууд нийт хүн амын 47 хувийг эзэлж байв. Хүүхэд залуучуудын эзлэх хувь өндөр байгаа нь нэг талаар тэдгээрийн сурх, боловсрох, асрах, эмчлүүлэх зэрдалд ихээхэн хүч хөрөнгө зарцуулах, нөгөө талаар хөдөлмөрийн нөөцийг цаашид тогтвортой нэмэгдүүлэх үндсэн нөхцөлийг бүрдүүлж байна.

Ажиллах хүчний үйлдвэрлэлийн шатанд хөдөлмөрийн насанд шилжих хүүхэд залуучуудын эруул мэндийг сахин хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ажлыг байнга явуулах эцэг эх, эмнэлгийн байгууллагын холбоог бэхжүүлэхэд онцгой анхаарах хэрэгтэй юм. Хүүхэд залуучуудыг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх диспансерчлалыг газар нутаг, район, сургууль, цэцэрлэгийн хэмжээнд авч явуулах, ялангуяа өрх гэрийн диспансерчлал, эмнэлэг гэгээрлийн чанартай сурталчилгааг тогтолжуулах шаардлагага зайлшгүй тавигдаж байна.

Хүүхэд залуучуудын дунд өвчлөлтийн судалгааг системтэй явуулж хүн амыг эруулжүүлэх ойрын болон хэтийн төлөвлөгөөний уялдааг сайжруулах, социалист орнуудын туршлагаар хүүхэд, залуучуудын тө-

рөлжсөн амбулатори, поликлиникийн тоог нэмэгдүүлж хот суурин газарт байгуулах явдал чухал юм.

Ажиллах хүчний нөхөн үйлдвэрлэлийн үйлдвэрлэлийн шатнаас хувваарилалтын шатанд шилжих процесс явагдаж, аймаг, хот, сум, районы хэмжээнд улс ардын аж ахуйн аль нэг салбарт хуваарилалтыг хийж байдаг.

Ажиллах хүчний хуваарилалтын шат нь улс ардын аж ахуйн салбарууд, газар нутаг, тухайлбал аймаг хот, районы хэмжээгээр хөдөлмөрийн чадвартай хүн амыг хуваарилах, дахин хуваарилахтай холбогдсон нийгэм өдийн засгийн харилцааг хамарч байдаг.

Ажиллах хүчний хуваарилалт бол нийгмийн хөдөлмөрт оролцх хөдөлмөрийн чадвартай ажиллах хүчний тухай ойлголт юм. Иймд ажиллах хүчний хуваарилалтын шатанд хөдөлмөрийн насанд хурэх хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулахад эрүүлийг хамгаалах салбар шийдвэрлэгч үүрэг гүйцэтгэнэ.

Ажиллах хүчний нөхөн үйлдвэрлэлийн процесст хуваарилалтын шат нь ажиллах хүчний үйлдвэрлэл, ашиглалтын шатыг холбогч завсрлын шат бөгөөд хөдөлмөрийн насны хүн амын оновчтой хуваарилалт нь ажиллах хүчний ашиглалт, тогтворт суурьшилд шууд нөлөөлж байдаг.

Ажиллах хүчний нөхөн үйлдвэрлэлийн процесст ажиллах хүчний ашиглалтын шат нь эцсийн үр дүнг тодорхойлоход онцгой үүрэг гүйцэтгэнэ. Ажиллах хүчний ашиглалт нь улс ардын аж ахуйн салбарт ажиллагсдын хөдөлмөрийн үр дүнгээр өөрөөр хэлбэл улс ардын аж ахуйн салбарт ажиллагсдын хөдөлмөрийн бүтээмжтэй шууд голбоотой. Ажиллагсдын хөдөлмөрийн бүтээмжийг байнга дээшлүүлэх нь эцсийн дунд ажиллах хүчний ашиглалтыг сайжруулах юм. Нийгмийн хөдөлмөрийн бүтээмжийн бүрэлдэхүүн хэсэг болсон ажиллагсдын хөдөлмөрийн дээшлэлт нь нэмэгдэл ажиллах хүч шаардахгүйгээр үндэсний орлогын үйлдвэрлэлийг шууд нэмэгдүүлж байна. Энэ VII таван жилд нийгмийн хөдөлмөрийн бүтээмжийн дээшлэлтээр үндэсний орлогын үйлдвэрлэлийн гуравны хоёрыг хангахаар төлөвлөж байна. Хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхэд гол хүчин зүйл болсон ажиллах хүчний ашиглалтыг сайжруулах нь үйлдвэрлэл дэх хөдөлмөр зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хөдөлмөрчдийн мэдлэг, мэргэжлийг системтэй дээшлүүлэх, материалын болон ёс суртахууны урамшууллыг зөв хослон хэрэглэх зэрэг олон хучин зүйлстэй холбоостой. Нөгөө талаар ажиллах хүчний ашиглалтыг сайжруулж хөдөлмөрийн бүтээмж дээшлүүлэх нь ажиллагсдын хөдөлмөрийн чадвар өлдлэлтийг багасгах явдал юм. Улс ардын аж ахуйн салбарт өвчлөлөөс болж хөдөлмөрийн чадвар алдаж байгаа байдлыг нарийн судалж хөдөлмөрийн чадвар алдалтаас гарах эдийн засгийн (өргтийн) бодит алдагдлыг улс ардын аж ахуй, салбар, үйлдвэр, нутаг районы хэмжээгээр тооцох шаардлага гарч байна. Ажиллах хүчний ашиглалтын шатанд эрүүлийг хамгаалах салбараас үйлдвэр аж ахуйн газар, салбарын хэмжээнд ажиллагсдын хөдөлмөрийн чадвар алдалтанд судалгаа явуулах, ажлын цаг алдалтыг бууруулах арга замыг тодорхойлох, урьдчилан сэргийлэх өргөн хүрээтэй арга хэмжээнүүдийг авч явуулах нь чухал юм. Ажиллах хүчний ашиглалтын гол үзүүлэлт болсон хөдөлмөрийн бүтээмжийн дээшлэлт нь ажилчдын мэдлэг боловсролын түвшингийн ёсөлт, бүх нийтийн биеийн тамирын хөдөлгөөний явц, үр дүнгээс хамгардгийг ЗХУ-ын тооочох үйлдвэрийн газруудад явуулсан судалгааны дүн харуулж байна.

ЗХУ-ын туршлагаар ажиллагсдыг эмнэлгийн байгууллагаас бүх, нийтийн биеийн тамираар эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулж байгаа туршлагыг нэвтрүүлэх, түүний хөдөлмөрийн бүтээмжинд хэрхэн нөлөөлж байгааг судалж үзэх хэрэгтэй байна. Ажиллах хүчний ашиглалтын

шатанд амбулаторийн үйлчилгээтэй холбоотойгоор гарах ажлын цагийн алдагдлыг багасгах нь амбулатори, поликлиникийн хөдөлмөр зохион байгуулалтыг боловсронгуй болгохтой шууд холбоотой. Мөн амбулатори поликлиникийн тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах, түүнд мэргэжлийн болсны санхүүгийн байгууллагаас тавих дотоодын хяналт шалгалтыг хүчтэй болгох нь чухал ач холбогдолтой.

Эрүүлийг хамгаалах байгууллагаас үйлдвэр аж ахуй, яам, тусгай газрын эрүүл мэндийг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлтийн байдалд тогтмол хяналт тавьж, төлөвлөлтийн шинжлэх ухааны түвшинг дээшлүүлэх шаардлагатай байна. Эрүүл мэндийг хамгаалах төлөвлөгөөнд хөдөлмөрчдийн хөдөлмөр ахуйн нөхцөлийг сайжруулах, цайны газар байгуулах, тоос шорооноос хамгаалах агааржуулалт гэрэлтүүлгийн ажлыг зайлшгүй тусгаж байх хэрэгтэй.

Ажиллах хүчиний нөхөн үйлдвэрлэлийн шат бурд эрүүлийг хамгаалах салбарын нөлөөлөх нөлөөллийг тооцох замаар эрүүлийг хамгаалахын эдийн засгийн үр ашгийг тодорхойлох боломжтой юм. Эрүүлийг хамгаалах салбарын ажиллах хүчиний нөхөн үйлдвэрлэлд гүйцэтгэх үүргийг эмнэлгийн ажилтнуудад тайлбарлан таниулах, тэдний эдийн засгийн боловсролыг дээшлүүлэх замаар хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулж, эмнэлгийн байгууллагын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлнэ.

В. И. ПРОМТОВ, Л. РОЛЗОДМАА

АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛЭГ НЬ ХӨДӨӨНИЙ ХҮН АМД ҮЗҮҮЛЭХ ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ АРГА ЗҮЙН ТӨВ МӨН

УЛСЫН КЛИНИКИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

Анагаах ухааны болон эрүүлийг хамгаалах ажлыг хөгжүүлэх талаар гарсан нам засгийн тогтоол шийдвэрүүдийн нэг чухал хэсэг нь хөдөөний хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламжийг боловсронгуй болгох, түүнийг хотын хүн амд үзүүлж буй тусламжийн түвшинд ойртуулах асуудал юм.

Нийгэм эдийн засаг, газар зүйн онцлог байдал, хөдөө аж ахуйн ажилчдын хөдөлмөрийн нөхцөл зэрэг бодит хүчин зүйлээс эмнэлгийн тусламжийн хуртээмж, чанар шалтгаалж, ялангуяа эмч хүрэлцээгүйгээс бэрхшээл учирч байна.

Ийнхүү хөдөөний хүн амын эмнэлгийн тусламжийг зохион байгуулж хэрэгжүүлэхдээ дээрх хүчин зүйлийг анхаарах хэрэгтэй юм.

Аймгийн нэгдсэн эмнэлэг нь хөдөөний хүн амыг эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламж өөрийн нутаг дэвсгэр дэх эмнэлэг урьдчилан сэргийлэх байгууллагуудыг зохион байгуулалт арга зүйн удирдлагаар хангах төв, эмч, эмнэлгийн дунд мэргэжилтний мэргэжил эзэмших, дээшлүүлэх бааз байгууллага мөн.

Аймгуудын 1981 оны тайлангийн материалаар нэгдсэн эмнэлэгт эмчлүүлэгчдийн 25,3%, аймгийн нийт эмнэлгийн байгууллагад эмчлүүлэгчдийн 10,7% нь хөдөөний хүмүүс байгаагаас үзэхэд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл дээр ажиллагсдын эмнэлгийн үйлчилгээний хүртээмж анхан шатны мэдээ буртгэлийн зөв эсэхийг нарийвчлан судлах нь чухал байна. Аймгийн нэгдсэн эмнэлэгт хөдөөнөөс эмчлүүлэгчид 1976 онд 27,4% байсан бол 1981 онд 25,3%, Архангай аймагт 42,5%—11,9%, Баян-Өлгий аймагт 29,8%—25,7 Дорнот аймагт 18,1—14%, Завхан аймагт 30,2—20,9% гэх мэтчилэн тус тус буурчээ. Аймгуудад амбулаториор үзүүлэгчдийн дотор хөдөөний хүмүүс 1976 онд 6,5% байснаа 1981 онд 3,7% болж буурчээ. Энэ үзүүлэлт Баян-Өлгий аймагт 26,6% Сүхбаатар аймагт 19,7%, Булган аймагт 14,8%-иар тус тус буурсан байна. Нүүдлийн амбулаторийн үзлэг Говь-Алтай, Завхан, Увс зэрэг нилээд аймагт буурлаа. Энэ нь эмнэлгийн үйлчилгээг дүгнэлт судалгааны үндсэн дээр зохицуулаагүйгээс гол нь шалтгаалсан бөгөөд үүнийг дараагийн үзүүлэлт нотолж байна.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн оп хэт их ачаалалтай ажиллаж байхад сум дундын эмнэлгийн нарийн мэргэжлийн тусlamжийн орыг зохистой ашиглаж чадахгүй байна. 1981 онд сум дундын эмнэлгийн дотрын оп 304 хоног ажилласан байхад аймгийн нэгдсэн эмнэлэгт 366 хоног ажилласан байна. (Нормативаар 330—340)

Хүснэгг 1

1981 оны дотрын тасгийн орны ашиглалт

| № | Аймгийн нэрс | Архангай | Баян-Өлгий | Увс | Ховд |
|---|--|----------|------------|-----|------|
| 1 | Сум дундын эмнэлгийн дотрын тасаг | 206 | 193 | 270 | 223 |
| 2 | Аймгийн нэгдсэн эмнэлгийн дотрын тасаг | 368 | 353 | 377 | 348 |

Мэс засал, эх барих эмэгтэйчүүдийн орны ашиглалт мөн л ийм байна. Аймгийн нэгдсэн эмнэлэг зохион байгуулалт арга зүйн төв байх үүргээ бүрэн гүйцэтгэж энэ байдалд дүгнэлт хийж ажиллахгүй байна. Аймгийн нэгдсэн эмнэлгийн ерөнхий мэргэжилтнүүд эмчилгээний болон зохион байгуулалт арга зүйн талаар төлөвлөгөөт зөвлөх тусlamжийн ажлаар хөдөөний эмнэлгүүдэд явж ажиллах нь ховор байна.

Хөдөөний хүн амд үйлчлэхэд аймгийн нэгдсэн эмнэлгийн өмнө маш олон төрлийн зорилтууд байдгаас зохион байгуулалт арга зүйн ажил онцгой үүрэгтэй юм. Иймээс аймгийн нэгдсэн эмнэлгийн бүтцийн нэг чухал хэсэг нь зохион байгуулалт арга зүйн кабинет байх ёстой. Энэ кабинет нь хөдөөний хүн амд үзүүлэх эмнэлгийн тусlamжийн зохион байгуулалт арга зүйн удирдлагын төв болдог. Зохион байгуулалт арга зүйн кабинетын гүйцэтгэх үүрэгт хүн амын өвчлөл нас баралт, хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, аймгийн эрүүлийг хамгаалах байгууллагуудын үйл ажиллагааны үзүүлэлтийн судалгаа, боловсон хүчиний мэргэжил дээшлүүлэх ажлын зохион байгуулалт, семинар зөвлөлгөөн, онол практикийн бага хурал бэлтгэж явуулах зэрэг ажил орно.

Зохион байгуулалт арга зүйн кабинетад хүн амын эрүүл мэндийн болон эрүүлийг хамгаалах статистикийн бүх үзүүлэлт хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд ажиллагсдын хөдөлмөрийн чадвар түр алдагдах өвчлөлийн тухай тооцоо судалгаанууд төвлөрнө.

Зохион байгуулалт арга зүйн кабинет сүм, бригадад ажиллах эмч нарын нүүдлийн тусlamжийг удирдан түүний биелэлтэнд хяналт тавьж эмнэлгийн байгууллагын ажлыг шалгаж зааварчилна.

Аймгийн хүн амыг эмнэлгийн төрөлжсөн нарийн мэргэжлийн тусlamжаар хангах нь үндсэндээ аймгийн нэгдсэн эмнэлгийн тасгийн эрхлэгч нарын ажлын зохион байгуулалт арга зүйн удирдлагаас шалтгаална. Тэнд сумын болон сум дундын эмнэлгээс хүн амд үзүүлж буй тусlamжийг мэргэжлийн чиглэлээр зохион байгуулан тэдний ажилд эмнэлэг үйлчилгээний дэвшилтэй арга хэлбэр, оношилгоо эмчилгээний шинэ аргыг нэвтрүүлэх ажлыг хариуцаж ажиллана.

Зохион байгуулалт арга зүйн кабинетын ажлын үр дүн нь аймгийн эрүүлийг хамгаалах газар, нэгдсэн эмнэлгийн удирдлагаас энэ кабинетын үүрэг ач холбогдлыг хир зэрэг ойлгосноос шууд шалтгаална.

Г. ЗУУНАЙ

ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ САЛБАР ДАХЬ ХӨДӨЛМӨРИЙН НӨӨЦИЙН АШИГЛАЛТ, ЭМЧ МЭРГЭЖИЛТНИЙ ӨГӨӨЖИЙГ САЙНКРУУЛАХ АРГА ЗАМ

АНАГААХ УХААНЫ ХҮРЭЭЛЭН

Нам засгийн байнгын анхаарал халамжийн үр дүнд социалист эрүүлийг хамгаалах систем тогтвортой хөгжиж ард түмний эрүүл мэндийг сахин хамгаалах уйл хэрэгт үлэмж хүч хөрөнгө зарж байна.

Ардын эрүүлийг хамгаалахын хөгжлийн явцад авч явуулсан арга хэмжээнүүд, тухайлбал эмнэлгийн нэгж байгууллагуудыг үүсгэн бий болгох, тэдгээрийг өргөтгөж бэхжүүлэх, эмч эмнэлгийн ажилтны тоог нэмэгдүүлэх, улсаас эрүүлийг хамгаалахад зарцуулах төсвийг өсгөх зэрэг арга хэмжээ бол эдийн засгийн хөгжлийн экстенсив маягийн арга зам байв. Тэгвэл эмнэлгийн ажиллах боловсон хүчин, материал техникийн бааз өсч тэдний тодорхой нөөц чадамжтай болсон орчин үед тухайн салбарыг эдийн засгийн интенсив аргаар голчлон хөгжүүлэх бүрэн боломжтой болж ирлээ.

Эдийн засгийн интенсив арга буюу эрчимжүүлэлт нь нийгмийн үйлдвэрлэлд шууд нөлөөлөх хүчин зүйлд чанарын өөрчлөлт гаргаж хамгийн үр ашигтай багаж техникийг хэрэглэх, хөдөлмөр зохион байгуулалтын боловсронгуй арга хэлбэрийг ашиглах дэвшилттэй арга юм.

Эрүүлийг хамгаалах салбар дахь хөдөлмөрийн нөөцийн ашиглалт, өгөөжийг дээшлүүлэхэд эрчимжүүлэх аргыг хэрэглэх шаардлага нэг талаас тус орны хүн амын зүйн онцлогоос хамаарч, тухайлбал ажиллах боловсон хүчин дутагдалтайгаас, нөгөө талаар орчин үеийн шинжлэх ухаан техникийн хөгжлийн эрүүлийг хамгаалах салбарт тусч буй үр нөлөө, анагаах ухааны хөгжлийн онөөгийн онцлог, эмнэлгийн ажилчдын нарийн мэргэжлийн тоо, чанарын дэвшил, эрүүлийг хамгаалах салбарт оруулж буй хөрөнгө оруулалтын өсөлт зэргээс үүдэн гарч байгаа юм.

Эмнэлгийн ажилчдын хөдөлмөрийн онцлог бол хэдийгээр нийгмийн материалац баялгийг шууд үйлдвэрлэдэггүй боловч түүнийг бүтээлч хөдөлмөрлөх хүч-хүний, улмаар нийгмийн хөдөлмөрийн чадварт шууд нөлөөлдөг бөгөөд тэдний хөдөлмөрийн ихээхэн хэсэг нь эмнэлгийн ажилтнуудын биеийн шууд оролцоо буюу „амьд хөдөлмөр“ байдагт оршино.

Тийнхүү эмнэлгийн ажилчдын хөдөлмөрийн бүтцэнд „амьд хөдөлмөр“ их ордоос эрүүлийг хамгаалах систем дэх аливаа асуудлыг шийдвэрлэхэд тэнд ажиллаж байгаа боловсон хүчиний хангамж шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг. Гэвч социалист нийгмийн хөгжлийн өнөөгийн үе шатанд аливаа асуудлыг амжилттай шийдвэрлэхэд ажиллаж байгаа хүний тооны олноор биш, харин тэнд байгаа боловсон хүчиний зөв зохицтой ашиглах явдал тэргүүн ач холбогдолтой болж ирлээ. Тухайлбал эмч нарын мэдлэг мэргэжлийг системтэйгээр дээшлүүлэх, нарийн мэргэжлийн дагуу ажиллуулах, багаж аппарат болон мэргэжилтний зориулалт хоорондоо тохирч байх, тэдний хөдөлмөрийг зөв зохион байгуулж ажлын зохицтой нөхцөлийг хангах, удирдлагын дээшилттэй хэлбэрийг ашиглах зэрэг нь хөдөлмөрийг эрчимжүүлэн хөгжүүлэх шилдэг арга хэлбэр болно.

Орчин үед аль ч салбарын боловсон хүчиний нөөцийн ашиглалт өгөөжийг сайжруулах хүчин зүйлсийг үндсэн гурван чиглэлд хуваан үзэж байна. Үүнд:

1. Материал техникийн холбогдолтой хүчин зүйл
2. Нийгэм-эдийн засгийн хүчин зүйл
3. Удирдлагын хүчин зүйл

Тусгай зориулалт бүхий барилга байгууламж, эмнэлгийн тооног төхөөрөмж, онош-эмчилгээний өндөр өгөөжтэй машин техник, тэднийг эзэмших орчин үеийн арга хэрэгслэгүйгээр өнөөгийн анагаах ухаан, эрүүлийг хамгаалахын хөгжлийг түргэтгэх, эмнэлгийн ажилчдын хөдөлмөрийн үр дунг сайжруулах боломжгүй юм. Гэхдээ амьд хөдөлмөр их шаарддаг эрүүлийг хамгаалахын онцлогос болж техник нь материалыг үйлдвэрлэлийн салбарынх шиг хөдөлмөрийн бүтээмжийн эцсийн үр дүнд шууд нөлөөлдөггүй билээ. Учир нь нэг талаас социалист нийгэм дэх эмчийн хөдөлмөрийн гол шинж чанар нь эмч өвчтөний хоорондын хүнлэг харьцаа хэвээр байх (техникээр тусгагрлагдан өвчтөнд хайнга хөндий хандахыг цээрлэх) бөгөөд негөө талаар, эрүүлийг хамгаалах дахь хөдөлмөрийн эцсийн үр дунг гагцхуу эдийн засгийн өгөөжөөр тодорхойлж болдоггүй, түүний шууд бусад олон үзүүлэлт, тухайлбал хүн амын өвчлөл, нас баралтын байдал, хөдөлмөрийн чадвар түр алдалтын бууралт, идэвхтэй урт наслалт зэрэг олон хүчин зүйлсээр тодорхойлогддогт оршино. Иймээс эмнэлгийн ажилчдын ашиглалтыг дээшлүүлж тэдний хөдөлмөрийн өгөөжийг сайжруулах гол арга нь нийгэм эдийн засгийн хүчин зүйлүүдийг ашиглах явдал юм.

Эрүүлийг хамгаалах салбар дахь хөдөлмөрийн нөөцийн ашиглалтыг сайжруулахад эрчимжүүлэх аргыг хэрэглэх асуудал орчин үед хурцаар тавигдах болсон нэг шалтгаан нь эмчийн тоо урьд байгаагүй ихээр өсч ирэхийн хирээр эмчийн хэрэгцээ улам ихэсч эмчийн орон тоо, бие хүн-эмчийн тоо хоёрын хоорондын харьцааны зөрөө багасагчийг байгаад оршино. Нийгмийн хөгжлийн зүй тогтоос үүдэн гарч ирэх энэхүү үзэгдлийг шийдвэрлэхэд яңз бүрийн арга замыг хэрэглэх шаардлагатай байна.

ЗХУ болон ах дүү социалист бусад орны туршлага үүнийг батлан харуулж байна. Эмч, эмнэлгийн ажилчдын хүрэлцээгүй байдлыг арилгахад (хэрэгцээг хангах) чиглэсэн нэг гол арга хэмжээ бол эмнэлгийн ажилчдын орчин тооны есөөтийг төлөвлөх ажлыг боловсронгуй болгоход оршино. Үүний тулд ажиллуулжагр төлөвлөж байгаа эмчийн орчин тооны төлөвлөгөөг тухайн үед бэлэн байгаа эмчийн тоо, түүний

хорогдол, төлөвлөгөөт хугацаанд шинээр нэмэгдэх эмчийн есөлттэй нягт уялдуулан хийх ёстой,

Мөн энэхүү төлөвлөлтэнд тэтгэврийн насанд хүрсэн эмч нарыг ажиллуулах боломж, эмч нарыг нэмэгдэл цалингаар ажиллуулах, шаардлагатай нөхцөлд орон тоог янз бурийн хэлбэрээр хавсарч ажиллуулах явдлыг харгалзаж тооцох, тэдгээрийг ул үндэстэй боловсруулж хэтийн төлөвт тусгах нь чухал юм.

Бидний судалгаагаар манай улсад эмч нарын хавсран ажиллаж байгаа коэффициент 1,1 хүрч, тэтгэврийн насанд хүрснээс хойш эрэгтэй эмч нар 2,9 жил, эмэгтэй эмч нар 3,8 жил мэргэжлийн ажлаа үргэлжлүүлэн хийж байна. Гэвч эмч нар тэтгэвэрт гарах, тэхир дуттуугийн группт срок, нас барах зэрэг шалтгаанаас болж улсад ажиллах хугацаа нь дунджаар эрэгтэйчүүдэд 3,6 жил, эмэгтэйчүүдэд 2,5 жилээр хорогдож байна.

Хүн амын дундаж наслалт уртсаж зруул мэйд нь сайжирч байгаа орчин үед тэггэврийн насын хумуусийг тэдний зруул мэнд, гэрэх эрхийг хохироолгүйгээр ажиллах боломжоор хангах явдал нийгмийн үйлдвэрлэлийн ажиллах хүчиний нөөцийг нэмэгдүүлэх чухал хүчин зүйлийн нэг болно.

Эмч нарын хөдөлмөрийн ашиглалт өгөөжийг сайжруулахад тэдний мэргэжлийн түвшинг дээшлүүлэх явдал чухал үүрэг гүйцэтгэдэг билээ. Судалгаанаас үзэхэд 1980 оны байдлаар манай улсын их эмч нарын 78,4 хувь нь ямар нэг хэлбэрээр мэргэжлээ дээшлүүлсэн байна. Одоо манай эмч нар дервен жил тутамд мэргэжлээ дээшлүүлж байх журамтай болссы словч тэдний мэргэжил дээшлүүлэлтийн чанар болон өндөр мэргэжлийн эмч бэлтгэх сургалтын зарим хэлбэрийн хяналтын тso ханглгүй байна. Эмч нарын дөнгөж 1,1 хувь нь докторантур ба аспирантурт, 4,1 хувь нь ординатурт суралцсан, 2,5 хувь нь эмчийн зэрэгтэй байгаа явдал бол төдийлөн хангалтгай, үзүүлэлт биш юм.

Эмч нарын мэргэжлийн түвшинг сайжруулах хоёрдогч систем буюу мэргэжил олгох, дээшлүүлэх явдлыг орчин үеийн шаардлагын хэмжээнд хүргэх, шинэ эмч нараар нарийн мэргэжлийг зөв сонгуулах, нэгэнт нарийн мэргэжил олсон эмч нарыг тэр мэргэжлээр нь тогтвортой ажиллуулах явдал бол тэднийг зөв зохистой ашиглах үндсэн хэлбэр мөн. Судалганаас үзэхэд манай эмч нар янз бурийн онцгой бус шалтгаанаар мэргэжил солих, тухайн мэргэжлээр ажиллахгүй мөртлөө курс сургуульд ивах, удаан хугацааны нарийн мэргэжлийн курст явж ирээд өөр ажилд шилжих, эсвэл эруулийг хамгаалах системээс гарах, тэтгэвэрт гарах зэрэг зохисгүй үзэгдлүүд тийм чөөн бус гарч байна.

Монголын эмч нарын III их хурлаас эмч нарын мэргэжил дээшлүүлэх институт байгуулах асуудал дэвшиүүлсэн боловч одоо хиршийдээгүй байгааг анхаарах нь зүйтэй байна.

Эмч, эмнэлгийн ажилтны мэргэжлийн түвшинг дээшлүүлэхэд боловсон хүчин бэлтгэх анхдагч ба хоёрдогч системийн аль аль нь чухал нөлөөтэй юм. Тиймээс боловсон хүчиний мэргэжлийн түвшинг дээшлүүлэх асуудлыг авч үзэхдээ зөвхөн сургууль төгссөнөөс хойшихи хугацаны тухай бодох нь том алдаа болно.

Боловсон хүчинд мэргэжил олгох аихдагч систем буюу дээд, дунд сургуулийн босгоноос төгсгөн гаргах эмч нарын мэргэжлийн түвшингээс өнөөгийн эруулийг хамгаалах ажлын амжилт шууд хамаарах болсон байна. Шинэ төгсөх эмч нарын чанарт онцгой анхаарч өндөр шаардлага тавихыг орчин үе шаардаж байна. Энэ нь нэг талгар манай улс эмчийн хангамжийн асуудлыг тооны хувьд үндсэнд нь шийдвэрлэсэн гэж үзэж болох өнөөгийн нөхцөлд тэдний мэдлэг мэргэжил, хүн амд үзүүлж байгаа эмнэлгийн тусlamжийн чанарт онцгой

анхаарах болсон нийгмийн хөгжлийн шаардлагаас урган гарч байна. Нөгөө талаар эмнэлгийн дээд мэргэжилтэнг орчин үеийн шинжлэх ухаан-техникийн хөгжлийн шаардлагын түвшинд бэлтгэн гаргахгүй бол цагийн яс даахгүй „гологдол бүтээгдхүүн үйлдвэрлэхэд“ хүрч байна. Энэ шаардлагыг хангахын тулд анагаах ухааны дээд сургуулийн багшлах боловсон хүчний бүрэлдхүүнийг эрс сайжруулах, сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгож шинжлэх ухааны хөгжлийн өнөөгийн шаардлагад тэнцүүлэх, сургах баз, материал техникийн хангамжийг бэхжүүлж, оюутнуудыг эмчлэх ур зүйд сургах, эмчийн мэргэжилд суралцах үйл явцын дэс дарааллыг зөв зохистой зохион байгуулж мэргэжлийн дур сонирхлыг сайжруулах, сургалтыг эрүүлийг хамгаалахын практиктай шижмийн нарийн холбоотой явуулах хэрэгтэй байна. Мөн оюутны элсэлтийн чанарт онцгой анхшарал тавьж эмнэлгийн сургуульд элсэх хүмүүсийн мэргэжлийн баримжааг сайжруулах, тэдэнд мэргэжлээ зөв сонгоход нь туслах гжлыг зохиох шаардлагатай байна.

Судалгаанаас үзэхэд манай улсын их эмч нарын 55,3 хувь нь эмчийн мэргэжлийг хүслээрээ эзэмшиж, 23,9 хувь нь хуваарилалтын дагуу эмнэлгийн сургуульд орж, 8,7 хувь нь бусдын зөвлөлгөөнөөр буюу ойр дотны хүмүүсийн үгээр, 8,4 хувь нь тохиолдоор, 3,7 хувь нь бусад шалтгаанаар эмчийн мэргэжлийг сонгожээ.

Эмч нарын ашиглалт, өгөөжийг сайжруулах чухал хүчин зүйлийн нэг бол тэднийг орон нутаг ба эмчлэн сэргийлэх байгууллагад зөв хуваарилж тогтвортой ажиллуулах явдал юм. Манай эмч нарын 5,6 хувь нь жил бүр ямар нэг хэлбэрээр шилжиж байгаагаас эмч нарын дөнгөж 32,7 хувь нь өөрийнхөө төрж өссөн орон нутагт тогтвортой ажиллаж байгаа юм. Ажиллах нөхцөл, хангамж жигд бишээс болж эмнэлгийн зарим байгууллагад эмч нар тогтвортой суурьшилтай ажиллахгүй байгаагаас сум, сум дунд, хэсгийн эмнэлэг, түргэн тусlamжийн станц зэрэг газар эмч нарын дамжин шилжих-өртөөний үүрэг гүйцэтгэдэг тохиолдол байгаа билээ. Эмч нарыг хот хөдөөд жигд ойролцоо хангамжтай байхаар хуваарилах, хуваарилалтын системийг улам боловсронгуй болгох асуудал Эрүүлийг хамгаалах Яамны үргэлжийн анхааралд байх ёстой.

Хөдөө орон нутагт ажилладаг эмч нарт нэмэгдэл цалин олгож тэднийг курс сургуульд суралцуулах асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэж байх нь зүйтэй юм. Залуу эмч нар сургууль төгсөөд хөдөө орон нутагт гурваас доошгүй жил ажилладаг зарчим нэгээнт тогтсон боловч 2—3 жилийн дараа заавал шилждэг ёстой юм шиг үзэх нь том алдаа болно. Цаашид хөдөө орон нутагт тасралтгүй ажилласны нэмэгдэл цалин буюу амралт олгодог болох, тэдний үр хүүхдийг эмнэлгийн сургуульд тэргүүн ээлжинд авдаг болзолт жургам тогтоох, саналаараа ирж ажилласан эмч нарт эхний ээлжинд орон сууц олгох, сууцны хөлсийг хөнгөлөх зэрэг арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Эмч мэргэжилтнүүдийг зүй зохистой ажиллахад тэдний хөдөлмөрийг зөв зохион байгуулах, шинжлэх ухагны үндэслэлтэй хөдөлмөр зохион буйгуулалтын янз бурийн хэлбэрийг нээтрүүлэх явдал чухал суурь эзэлнэ. Тусгай судалгаанаас үзэхэд манай эмч нарын 14 хувь нь өвчлөх, зориулалтын бус ажилд дайчлагдах зэрэг янз бурийн шалтгаанаас болж эмчлэн сэргийлэх ажилд оролцохгүй, жилийн туршид үндсэн ажлаасаа хөндийрч байна.

Ажлын цагийн энэхүү хөндийрөлт, алдагдлыг багасгах нь хөдөлмөрлөх хүчний ихээхэн нөөц болно. Уүний тулд эмч нарын хөдөлмөрийг зөв зохион байгуулж курс сургуульд явуулах, амрах хуваарийг зөв хийх, жилийн туршид ажиллах эмч нарын төлөвлөгөөг ирийн гаргах, тэдний хөдөлмөрийн чадвар тур алдах өвчлөлийг бууруулах арга

хэмжээг тууштай авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Нөгөө талаар эмч нарын энэхүү ажлын цагийн алдагдал, үндсэн ажлын хөндийрөлтийг төлөвлөлтөнд тусгаж байх хэрэгтэй юм. Мөн эмч мэргэжилтнуудийг зөв зохистой ашиглахад тэдний орон тооны нормативыг хүн амын эмнэлгийн тусламж авах хэрэгцээнд уялдуулан хийх, их эмч, эмнэлгийн дунд ба бага мэргэжилтний тооны харьцааг зөвөөр тогтоох явдал маш чухал юм.

Өнөөгийн шинжлэх ухаан-техникийн хөгжлийн үр дагавраар анагаах ухааны зарим мэргэжил улам бүр салбарлан нарийсч, зарим нь олон шинжлэх ухааны зааг дээр өргөжин хөгжих болсноос орчин үеийн эрүүлийг хамгаалах системд инженер техникч, эдийн засагч, бодис зүй (физик), хувилahuийн ухаан, математик зэрэг янз бүрийн мэргэжлийн хүмүүс хамтран ажиллах шаардлагатай боллоо.

Эрүүлийг хамгаалахын боловсон хүчний ашиглалт, өгөөжийг сайжруулах маш чухал чиглэлийн нэг бол салбарын удирдлагыг эрс сайжруулах асуудал юм. Ер нь эрүүлийг хамгаалахын удирдлага бол тухайн салбарын хөдөлмөрийн нөөцийн ашиглалт, өгөөжийг бүх талаар дээшлүүлэх, засаг захиргаа-зохион байгуулалтын болон эдийн засаг, төр эрхийн цогц арга хэмжээний нэгдэл юм.

Удирдлагын арга хэлбэр, түүний эцсийн үр дүн нь салбарыг удирдаж байгаа боловсон хүчний бүрэлдэхүүн, мэргэжил мэдлэгийн түвшингээс хамаардаг нь мэдээж хэрэг.

В. И. Ленин удирдах боловсон хүчнийг сонгон дэвшүүлэхэд анхаарах гол зүйлсийн талаар олон удаа тодорхойлон заасан байдаг. Тийм ч учраас манай намын удаа дараагийн их, бүгд хурлуудаас боловсон хүчнийг зөв сонгон дэвшүүлэх, тэднийг удирдлагын ажилд сургах талаар онцгой анхаарч дэс дараатай чухал асуудлуудыг дэвшүүлэн хэрэгжүүлж байдаг билээ.

Манай улс эрүүлийг хамгаалахын удирдах ажилтнуудыг Дэлхий Эрүүлийг Хамгаалахын Байгууллагын шугамаар Москвагийн курст сургадаг уламжлалтай болж энэ курсийг нилээд сайн ашиглаж байгаа юм. Гэвч түүнд явуулж байгаа бүрэлдхүүнийг нарийн хянаж ирсэн хойноо удирдах ажил хийж чадах, эрүүлийг хамгаалах системд ажиллах хүмүүсийг явуулж сургах шаардлагатай байна.

Эмнэлгийн удирдагчдын удирдлагын ба эдийн засгийн мэдлэгийг сайжруулж шинэ шатанд гаргах шаардлагатай байна. Нөгөөтэйгүүр орчин үеийн аж ахуйг удирдахад шинжлэх ухаан техникийн мэдээллийг өшиглэхгүйгээр сонвчтой зөв шийдвэр гаргах боломжгүй юм. Цаг үеэ олсон, найдвартай, оновчтой мэдээллийн (өгсөх ба уруудах урсгалын аль аль нь чухал) үр дунд өөрийн орны төдийгүй, гадаад орнууд дахь тухайн салбарын хөгжлийн орчин үеийн түвшин, тулгамдсан асуудал, эрэлт хэрэгцээ, онцлогийг олж харах, гарч болох алдаанагс сэргийлэх, бусдас сургах, хэмгийн сүүлийн үеийн тэргүүн туршлага, шинэ санаачилгыг авч хэрэглэх боломжтой болно.

Тийм ээс орчин үеийн эрүүлийг хамгаалах системийг оновчтой, дайчин удирдахад анагаах ухааны мэдээллийг хөгжүүлэх, түүнийг ашиглах явдал чухал байна.

Эдгээрээс гадна эмч, мэргэжилтнуудийн ашиглалт, өгөөжийг сайжруулжад тэдний дунд социалист уралдааныг зөв оновчтой өрнүүлэх, эдийн засгийн урамшуулах системийг туршин ашиглах, эрдэм шинжилгээний ажил хийлгэх, энэ эрхийг эмнэлгийн дарга нарт олгох, шинжлэх ухааны үндэслэлтэй хөдөлмөр зохион байгуулалтын төрел бүрийн хэлбэрийг тууштай нэвтрүүлэх явдал чухал байна.

ЖИРЭМСЭН ЭХ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ДИСПАНСЕРИЙН ХЯНАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АРГА ЗАМ

УЛААНБААТАР ХОТЫН III АМАРЖИХ ГАЗАР

Эх барих эмэгтэйчүүдийн тусламжийн цөм болсон эмэгтэйчүүдэд зөвлөлгөө өгөх газрын үйл ажиллагааны үндсэн зарчим, ажлын арга барил нь жирэмсэн эх, эмэгтэйчүүдийн өвчтэй эмэгтэйчүүдийг диспансерчлах арга ажиллагаа байх ёстой.

Орчин үеийн анагаах ухааны ололт амжилтыг эмэгтэйчүүдэд зөвлөлгөө өгөх газрын үйл ажиллагаанд нэвтрүүлэх нь жирэмслэлт, жирэмсний хүндрэл, эмэгтэйчүүдийн өвчлөлийг эрт үед нь илрүүлэх, оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх ажлыг үр дүнтэй явуулах, эх нялхсын эрүүл мэндийг хамгаалан бэхжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлж байна.

Эмэгтэйчүүдэд зөвлөлгөө өгөх газар нь амбулатори-поликлиничийн бурэлдхүүнд хамрагддаг, нэгдсэн эмнэлэг, тусгай мэргэжлийн диспансерууд, стационартайгаа нэгдмэл үйл ажиллагаатай эмнэлэг үйлчилгээний систем юм.

Тус газар нь жирэмсэн эхчүүд болон өвчлөлийг эрт илрүүлэн эмчлэн эрүүлжүүлэх хяналт тогтоож, гарч болох хүндрэлүүдээс урьдчилан сэргийлэх, тэднийг системт сургалтанд бүрэн хамруулж ариун цэвэр, эрүүл ахуйн анхны мэдэглэхүүн эзэмшиүүлэх, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, эрх ашгийг хамгаалсан хууль тогтоомж, шийдвэрийн биелэлтэнд хяналт тавьж биелүүлэх, эмэгтэйчүүд, эхчүүдийн амьдрал ахуйн болон хөдөлмөрийн нөхцелийг сайжруулахад ажлаа чиглүүлнэ.

Жирэмсэн эх, эмэгтэйчүүдийн өвчтэй эмэгтэйчүүдийг диспансерийн хяналтанд хамруулах гол арга бол үйлчлэх хүрээний дэвсгэр нутгийн 15—49 насны эмэгтэйчүүдийн бүртгэл судалгааг гаргаж хөдөлгөөнийг тогтмол хийж байх, эмнэлгийн байгууллагын зориудын урьдчилан сэргийлэх үзлэг, өдөр тутмын үйлчилгээнд хамрагсдын дотроос жирэмсэн эх, эмэгтэйчүүдийн өвчтэй эмэгтэйчүүдийг идэвхтэй аргаар илрүүлэх явдал мөн.

Харьяа дэвсгэр нутгийн эмэгтэйчүүдэд хагас жил тутам урьдчилан сэргийлэх үзлэгийг төлөвлөгөөт графикаар хийх, хот төвлөрсөн газар жирэмсэн эмэгтэйчүүдийг эхний хагас жилд сард нэг, жирэмсний сүүлийн хагасаас эхлэн хоёр долоо хоногт нэг, төрөхөөс өмнө 45 хоногийн хугацаанд 7 хоногт нэг удаа, онцгой хяналтын жирэмсний үзүүлэх хугацаа нь үүнээс улам ойрхон байх шаардлагатай.

Жирэмсний эхний 3 сарын дотор зөвлөлгөөнд хамруулах нь тухайн жирэмсний бодит байдлыг цаг үед нь үнэн зөв тогтоох, илүү өртөмтгий эхчүүдийг онцгой хяналтанд авч эхийн эрүүл мэндийн байдлаас шалтгаалан уг жирэмслэлтийг таслах, жирэмсний цаашдын аливаа хүндрэлээс урьдчилан сэргийлэх, хэвлий дэх ураг хамгаалалтыг бүрэн хийх, жирэмслэлтийг хэвийн төрөлтөөр төгсгөхөд шийдвэрлэх ач холбогдолтой юм.

Эх барихын ужиг дурдатгалтай, бусад эрхтэн системийн өвчин хавсарсан жирэмсэн эмэгтэйчүүдэд онцгой хяналт тогтоон, нарийн мэргэжлийн эмчийн хяналтанд байлгаж эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохиож, амаржих газар, тасагт хэвтүүлж, бүх талын шинжилгээ

хийж оношийг бататган эмчилж, төрөлтийн төлөвлөгөөг боловсруулна.

Жирэмсэн эхчүүдэд шаардлагатай шинжилгээнүүдийг хийх ба жирэмсний тээлтийн нэг, хоёрдугаар хагаст хүн бурд сурьеэ, тэмбүү, өвчин илрүүлэх шинжилгээ хийхээс гадна ужил халдвараас хамгаалах анатоксиныг З удаа тарина.

Зөвлөлгөө өгөх газраас жирэмсэн эхчүүдэд эмнэлэг, ариун цэвэр эрүүл ахуйн суртал нэвтрүүлгийн ажлыг нэг бүрчилэн зохиож ариун цэвэр, эрүүл ахуйн анхны мэдэгдхүүнтэй болгож, жирэмснээс хамгаалах арга барилыг шаардлагатай эмэгтэйчүүдэд зааж сургах, үргүй хүмүүсийг эмчлэх, зөвлөлгөөн өгөх, мөрдөж байгаа журмын дагуу умайн хаацай, ерөндөг тавих ажлыг эрхлэн гүйцэтгэх, жирэмсэн эмэгтэйчүүдэд амаржихын өмнө хэрхэн хувцаслах, ажиллах, амрах, хооллох, амаржсаны дараахь эрүүл ахуйн дэглэм, хүүхдээ хооллох, арчлах, сувилах, витаминжуулах, чийрэгжүүлэх, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх арга барил дадал заншил эзэмшүүлэх ажлыг эрэмбэ дараалалтай зохионо.

Эхчүүдэд зориулсан системт сургалтыг хот суурин газруудад байнга зохион байгуулж, хичээлийн хөтөлбөрт эмэгтэйчүүдийн бэлэг эрхтний анатом физиологийн онцлог, сарын тэмдгийн мөчлөг, түүний хямрал, эмчид үзүүлэхийн ач тус, эмэгтэйчүүдийн эрүүл ахуй, урьдчилан сэргийлэх тарилгын ач холбогдол, хөхөө хэрхэн арчлах, арьс өнгөний өвчин, түүний хор холбогдол, эмэгтэйчүүдэд элбэг тохиолдох утреэний урэвсэл, түүнээс урьдчилан сэргийлэх, ур хөндөлтийн хор холбогдол зэрэг сэдвээр явуулахын гадна жирэмсэн эмэгтэйчүүдийг өвчингүй амаржуулахад бэлтгэл хийж, амаржих нь физиологийн хэвийн үзэгдэл мөн болохыг ойлгуулж, амаржихаас айж болох шалтгаануудыг арилгаж, сэтгэл санааны урьдчилсан бэлтгэл хийнэ.

Эмэгтэйчүүдэд зөвлөлгөө өгөх газраас жирэмсэн эмэгтэйчүүдэд үйлчлэх гол хэлбэрийн нэг нь эргүүлийн идэвхтэй үйлчилгээ байх ёстой. Эх барих-эмэгтэйчүүдийн эмч, эргүүлийн бага эмч, сувилагч нь хариуцсан дэвсгэр нутагт жирэмсэн эмэгтэйчүүдийг эхний З сарын дотор илрүүлэн хяналтандaa авахыг гол зорилт болгоно.

Эргүүлийн бага эмч нь эмчийн заавар зөвлөлгөөнийг жирэмсэн ба төрсөн эхчүүд хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, хувийн болон гэр срны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах зөвлөлгөөн өгч эхчүүд эмчийн заасан хугацаанд ирж зөвлөлгөө авч байгаа эсэхэд анхаарч, ирээгүй бол дудаж үзүүлэх, халдварт өвчтөн, нян агуулагчийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна.

Эмэгтэйчүүдэл зөвлөлгөө өгөх газрын нэг чухал зорилт бол жирэмсэн эмэгтэйчүүдийн дундаас илүү өртөмтгий байдал бүхий жирэмсэн эхчүүдийг илрүүлэн, зөв оношилж, онцгой хяналтандaa авч жирэмсний ба төрөх үеийн онооны үнэлгээг тогтооно. Илүү өртөмтгий байдал бүхий жирэмсэн эмэгтэйчүүдийг 10 ба түүнээс дээш онооны зэрэглэлд хуваана. Энэ онооны үнэлгээнд үндэслэж, эх үргийн эрүүл мэндэд ноцтой нөлөөлөх, гарч болзошгүй хүндрэлээс сэргийлэн эмчлэн эрүүлжүүлэх иж бүрэн арга хэмжээг авна.

Жирэмсэн ба төрөх үед өртөмтгий байдалд

хүргэж болох хүчин зүйлс:

A. Төрөхийн өмнөх үе

1. Нийгэм-биологийн байдлаар
2. Эх барих-эмэгтэйчүүдийн дурдатгалтай
3. Бэлгийн бус өвчтэй
4. Жирэмсний хүндрэл
5. Эхийн хэвлүүдийн дэх үргийн эрүүл мэндийн байдалд өгөх үнэлгээ

Б. Төрөх үе

6. Эхийн талаас
7. Эхсийн талаас
8. Ургийн талаас

Илүү өртөмтгийжирэмснийг ерөнхийд нь дараахъ 3 бүлэг болгон хуваана.

1. Эх барих эмэгтэйчүүдийн ужиг дурдатгалтай
- II. Бэлгийн бус өвчтэй

III. Тухайн жирэмсний үед хүндрэлтэй байгаа эмэгтэйчүүдийг тус тус хамруулна.

Онооны үнэлгээг 10 ба түүнээс дээш бол хүнд, 5—9 байвал дунд. 4 ба түүнээс доош бол хөнгөн гэж үзнэ.

ИЛҮҮ ӨРТӨМТГИЙ БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛОХ ҮНЭЛГЭЭНИЙ СХЕМ

A. Төрөхийн өмнөх үе

1. Нийгэм-биологийн байдлаар:

| | |
|----------------------|--------|
| Эхийн нас; 20 хүртэл | 2 балл |
| 25—29 | 1 балл |
| 30—34 | 2 балл |
| 35—39 | 3 балл |
| 40-өөс дээш | 4 балл |

2. Эцгийн нас 20 хүртэл 1 балл
Эцгийн нас 40 ба түүнээс дээш 2 балл

3. Мэргэжлийн хортой нөхцөл:

| | |
|------|----------|
| Эх | 1—4 балл |
| Эцэг | 1—4 балл |

4. Хортой зуршууд:

| | |
|----------------------------|--------|
| Эх тамхи татдаг бол | 1 балл |
| Эх, эцэг нь архи уудаг бол | 2 балл |

5. Ганц бие бол 1 балл

6. Боловсрол бага, дунд 1 балл

7. Боловсрол дээд 1 балл

8. Эхийн биеийр өндөр 150 см-ээс намхан бол 1 балл

9. Эхийн биеийн жин хэмжээнээс 25%-иар их бол 2 балл

Эх барих эмэгтэйчүүдийн дурьдатгал,

1. Анхны төрөлтийн өмнөх үр хөндөлт 1—2 балл

2. Давтан төрөлтийн өмнөх үр хөндөлт 2—3 балл

3. 8 ба түүнээс дээших төрөлт 2 балл

4. Дутуу төрөлт:

| | |
|------------|--------|
| 1 удаа бол | 2 балл |
| 2 удаа | 3 балл |
| 3 удаа | 4 балл |

5. Давтан төрөлтийн хоорондын зайд 1—2 жил бол 1—2 балл

6. Амьгүй төрөлт 1 удаа бол 3 балл

2 удаа 8 балл

7. Нярайн үеийн ухэл

1 удаа бол 2 балл
2 удаа бол 7 балл

8. Хүүхдийн тахир дутуу хөгжил 3 балл

9. Хүүхдийн мэдрэлийн хямрал 2 балл

10. Хүүхдийн биеийн жин 2500-аас бага бол 2 балл

11. Хүүхдийн биеийн жин 4000-аас дээш бол 1 балл

12. 5 жилээс дээш жирэмслээгүй бол 2—4 балл

13. Хагалгааны дараахъ умайн сорвижилт—4 балл

14. Умайн болон өндгөвчийн хавдар 2—4 балл

15. Умайн хүзүүний үйл ажиллагааны дутагдал 2 балл
16. Умайн хөгжлийн гажигтай бол 3 балл

II. Жирэмсний хүндрэлүүд

1. Эрт үеийн илэрхий хордлого 2 балл
2. Жирэмсний эхний ба суулийн хагасын үеийн цус багадалт 3—5 балл
3. Хожуу үеийн хордлого усан хаван 2 балл
4. Нефропати I, II, III ээрэгтэй 3—5—12 балл
5. Хавсарсан хордлого 9 балл
6. Эх, ургийн цусны тохиролцоогүй байдал 5—10 балл
7. Ургийн цусны ихдэлт 3 балл
8. Ургийн усны багадалт 4 балл
9. Ургийн өгзөг түрүүлэлт 3 балл
10. Илүү тээлттэй жирэмслэлт 3 балл
11. Ихэр төрөлт 3 балл
12. Өмнөх төрөлтүүдэд төрөлт түргэсгэх эмчилгээ авч байсан 1 балл
13. Уйтан аарцаг 4 балл
14. Ургийн буруу байрлал 4 балл

III. Бэлгийн бус өвчинүүд:

1. Зүрх судасны өвчинүүд:
 - а) зүрхний гажиг (цусны эргэлтэнд өөрчлөлт ороогүй үеийн) 3 балл
 - б) зүрхний гажиг (цусны эргэлтэнд өөрчлөлт орсон үеийн) 10 балл
2. Цусны даалт ихсэх өвчний I, II, III зэрэгтэй 2—8—10 балл
3. Цусны даалт багасах өвчин 2 балл
4. Жирэмслэлтийн өмнөх бөөрний өвчтэй бол 3 балл
5. Жирэмслэлтийн явцад бөөрний өвчин хурцадвал 4 балл
6. Дотоод шүүрлийн булчирхайн эмгэг;
 - а) чихрийн шижингийн өмнөх байдал 5 балл
 - б) чихрийн шижин 10 балл
 - в) бамбай булчирхайн өвчтэй 5—10 балл
 - г) бөөрний дээд булчирхайн өвчин 5—10 балл
7. Цус багадалт 90—100 г/л 19—10 гр% 4—2 балл
8. Цусны бүлэгнэх ажиллагааны эмгэг 2 балл
9. Илэрсэн харааны хүнд эмгэг, нүдний бусад өвчин 1—3 балл
10. Архаг өвөрмөц халдвартууд (сурьеэ, бруцеллээз, тэмбүү, токсоплазмоз 2—6 балл
11. Жирэмсний явц дахь хурц халдвартууд 2—7 балл
12. Сэтгэл мэдрэлнийн өвчтэй бол 4 балл

IV. Ургийн байдлын үнэлгээ:

1. Ургийн хатингаршил (турагл) 10—20 балл
2. Бүтэлт 3—8 балл
3. Хоногийн шээсэн дэх эстриолын хэмжээ (30—34) долоо хоногтойд 34 балл
4. 9 мг-аас бага ба (40 долоо хоногтойд 12 мг-аас бага байх) 15 балл
5. Ургийн усанд мекони байвал 3 балл

Эхчүүдэд төрөхөөс гарахад нь солилцох хуудсанд төрөлтийн ба төрсний дараах үеийн байдлыг бичсэн байх ба зөвлөлгөө өгөх хэс-2*

Тийн эмчдээ ирэхдээ төрсний дараахь амралтыг олгоно. Эмэгтэйчүүдийн зөвлөлгөө өгөх газар жирэмсний картанд тухайн жирэмсний явц төгсгөл, оношилгос, эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээ, түүний үр дүн, нярайн эрүүл мэндийн байдлыг нэгтгэн дүгнэсний үндсэн дээр хүн бүрт төгсгөлийн дүгнэлт бичнэ.

Эмэгтэйчүүдийн зөвлөлгөө өгөх газрын нөгөө нэг чухал зорилт бол эмэгтэйчүүдийн бэлэг эрхтний өвчлөлийг эрт илрүүлэн зөв оношилж тэгс эмчлэн эрүүлжүүлэх ажлыг чанартай хийх явдал юм.

Эмэгтэйчүүдийн өвчлөлийг бууруулах арга нь урьдчилан сэргийлэх үзлэг юм. Урьдчилан сэргийлэх үзлэгийн гол зорилго нь эмчилгээ сувилаа шаардагдах эмэгтэйчүүдийг өвчиний эрт үед нь идэвхтэй илрүүлэх явдал мөн. Эмэгтэйчүүдийн өвчинөөс бэлэг эрхтний хүрц ба архаг үрэвсэлт өвчинүүд, хавдрын үрьдэлтэй өвчинүүд, сарын тэмдгийн хямрал, жирэмслэлт ба төрөлтэй хувьсогдол бүхий эмэгтэйчүүдийн өвчин хоргүй хавдар, хорт хавдар зэрэг өвчин бүхий эмэгтэйчүүдийг цаг алдалгүй илрүүлэн диспансерийн хяналтанд авч төсөөс эмчлэн эрүүлжүүлнэ.

Эмэгтэйчүүдийг эрүүлжүүлэхэд эмийн эмчилгээ, ус, шавар, биений тамир, физик эмчилгээ болон чийрэгжүүлэлт, витаминжуулах, нөхөн сэргээх арга хэмжээг өргөн хийнэ.

Эх барих эмэгтэйчүүдийн байгууллагын үйл ажиллагаа нь эмнэлгийн тусламжийн чанарын үзүүлэлтээр илэрхийлэгдэнэ. Эмэгтэйчүүдийн зөвлөлгөө өгөх газрын (Эх барих, эмэгтэйчүүдийн хэсгийн) үйл гжиллагаа нь дараах үндсэн үзүүлэлтээр илэрхийлэгдэнэ.

Үүнэ:

1. Үзлэгийн төлөвлөгөөний бнелэлт:

Үзсэн бүх эмэгтэйчүүдийн тоо x 100

өгөгдсөн төлөвлөгөө

2. Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувийн жин:

Урьдчилан сэргийлэх үзлэгээр үзсэн хүний тоо x 100

үзсэн бүх эмэгтэйчүүдийн тоо

3. Эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хамралт:

Үзлэгт хамрагдвал зохих 15-аас дээш наасны

эмэгтэйчүүдийн тоо x 100

Үзлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо

4. Диспансерийн хяналтын хамралт:

Диспансерийн хяналтад хамрагдсан

жирэмсэн эмэгтэйчүүдийн тоо x 100

тухайн дэвсгэр нутагт хяналтын хугацаанд болсон жирэмсэн эмэгтэйчүүдийн

нийт тоо

5. Жирэмсний эхний 3 сард илрүүлэх хяналтанд хамарсан байдал:

Эхний 3 сард хяналтанд авсан бүх хүний тоо x 100

Хяналтанд авсан бүх жирэмсний тоо

6. 7 сартайгаас дээш хугацаанд хяналтанд хамарсан хувь:

7 сартайгаас дээш хяналтанд авсан

бүх жирэмсний тоо x 100

Хяналтанд авсан бүх жирэмсний тоо

7. Эмэгтэйчүүдэд зөвлөлгөө өгөх газарт амаржих хүртэл үзүүлсэн жирэмсэн эмэгтэйн зөвлөлгөө авсан дундаж тоо:

Эмэгтэйчүүдийн зөвлөлгөө өгөх газарт амаржих

хүртэл зөвлөлгөө авсан бүх жирэмсэн эмэгтэй-

чүүдийн нийт үзлэгийн тоо х 100

Эмэгтэйчүүдийн зөвлөлгөө өгөх газарт амаржих хүртэл үзүүлж зөвлөлгөө авсан бүх жи-
рэмсний эмэгтэйн тоо

8. Нефропатийн эзлэх хувь:

Нефропати болж хүндэрсэн жирэмсний тоо х 100

Хяналтанд байгаа бүх жирэмсний тоо

9. Эклампсийн эзлэх хувь:

Эклампси болж хүндэрсэн жирэмсний тоо х 100

Хяналтад байгаа бүх жирэмсний тоо

10. Төрөхийн өмнө олгогдсон амралтын алдаа:

Төрөхийн өмнөх амралт аваад тогтоогдсон
хугацаанаас 15 ба түүнээс дээш хоногоор
хэтэрч төрсөн эхчүүдийн тоо х 100

Төрөхийн өмнө амралт авсан бүх

жиремсний тоо

11. Төрөхийн өмнөх амралт аваад тогтоосон хугацаанаас 15 ба
түүнээс дээш хоногоор уртаж төрсөн эхчүүдийн тоо х 100

Төрөхийн өмнөх амралт авсан бүх жирэмсний тоо

12. Жирэмсэн эмэгтэйн цусанд тэмбүү илрүүлэх вассерманы ур-
вал тавьсан хувь:

Цусанд вассерманы урвал тавьсан жирэмсний тоо х 100

Хяналтанд байгаа бүх жирэмсний тоо

13. Өвчингүй амаржуулах хичээлд суугчдын хувь:

Өвчингүй амаржуулах хичээлд суусан жирэмсний
тоо х 100

Хяналтанд байсан бүх жирэмсний тоо

14. Страфлококкийн эсрэг анатоксин хийлтийн хувь:

Страфлококкийн анатоксин хийлгэсэн
эмэгтэйн тоо х 100

Хяналтанд байсан бүх жирэмсний тоо

15. Цусанд эсрэг резус хүчин зүйл илэрсэн хувь:

Цусанд эсрэг резус хүчин зүйл илэрсэн
эмэгтэйн тоо х 100

Цусанд резус хүчин зүйл тодорхойлох
шинжилгээ хийлгэсэн хүний тоо

16. Эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээний байдал:

Эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээ авагдсан
бүх жирэмсэн х 100

Эмчлэн эрүүлжвэл зохих бүх жирэмсэн

17. Төрөлтөөр төгссөн жирэмсний хувь:

Төрөлтөөр төгссөн жирэмсний тоо

(гүйцэд+дутуу)х100

төрөлтөөр төгссөн үр хөндөлтөөр

жиремсний тоо төгссөн жирэмс-

(гүйцэд+дутуу) ний тоо (үр зул-

балт+эмнэлгийн

магадлагаагаар

хийгдсэн үр

хөндөлт)

18. Дүтуу төрсөн жирэмсний хувь:

Дутуу төрсөн жирэмсний тоо х 100

Төрөлтөөр төгссөн жирэмсний тоо

(гүйцэд+дутуу)

19. Ур хөндөлтөөр төгссөн жирэмсний хувийн жин:

Ур хөндөлтөөр төгссөн жирэмсний тоо х 100
Төрөлтөөр төгссөн Ур хөндөлтөөр төгссөн
жирэмсний тоо жирэмсний тоо
(ур зулбалт+эмнэл-
гийн магадлагаа-
гаар хийгдсэн ур
хөндөлт)

20. Гэрийн төрөлтийн хувь:

Гэртээ төрсөн эхчүүдийн тоо х 100

Эмнэлэгт төрсөн бүх эх+гэртээ төрсөн бүх эх

21. Эрүүл жирэмсэн эмэгтэйчүүд. Диспансерчлах, явц түүний эмч-
лэн эрүүлжүүлэх арга хэмжээний ур дунд «зөвхөн жирэмснээс» өөр
өөрчлөлтгүй эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин юм. Диспансерчлалын
энэ ойлголтонд «жирэмсэн эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн индекс»
гэсэн чухал үзүүлэлт хамарагдана. Хяналтанд хамрагдсан нийт эмэг-
тэйчүүдийн дунд эрүүл жирэмсний эзлэх хувийн жинг жирэмсэн эмэг-
тэйчүүдийн эрүүл мэндийн индекс гэнэ.

ЖЭМИ: = Эрүүл хэвийн явц төгсгөлтэй жирэмсний тоо х 100

Хяналтанд хамрагдсан бүх жирэмсэн

22. Төрөхийн емнөх ургийн эндэгдэл;

Төрөхийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө
эхийн хэвлэлийд эндэж төрсөн хүүхэд х 100

Амьд төрсөн бүх хүүхэд+амьгүй төрсөн
ураг

23. Стационарт хэвтсэн эмэгтэйчүүдэд зөвлөлгөө өгөх газар ста-
ционарын тавьсан оношийн тохигооны хувь;

Эмэгтэйчүүдийн зөвлөлгөө өгөх газар,
стационарын онош тохирсон жирэмсний тоо х 100

Стационарт хэвтүүлсэн жирэмсний тоо

24. Жирэмсэн эмэгтэйчүүдээс амаржсаны дараа эмэгтэйчүүдэд
зөвлөлгөө өгөх газарт үзүүлсэн дундаж тоо:

Жирэмсэн эмэгтэйчүүдээс амаржсаны дараа эмэгтэй-
чүүдэд зөвлөлгөө өгөх газарт үзүүлсэн эмэгтэйн
тоо х 100

Амаржсан эмэгтэйн тоо

24. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдагсдын хувь:

Эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгт
хамрагдагсдын тоо х 100

Үзлэгт хамрагдвал зохих бүх эмэгтэйн
тоо

26. Эмэгтэйчүүдийн зөвлөлгөө өгөх газар үзүүлсэн эмэгтэйчүү-
дийн дотроос өвчин илэрсэн тохиолдлын хувь:

Эмэгтэйчүүдийн өвчин илэрч бүртгэгдсэн
эмэгтэйн тоо х 100

Үйлчлэх хүрээний эмэгтэйчүүдийн
дундаж тоо

27. Урьдчилан сэргийлэх үзлэгээр өвчин илэрсэн эмэгтэйчүүдийн
хувь:

Үзлэгээр өвчин илэрсэн тохиолдлын тоо х 100

Үзлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо

28. Эмэгтэйчүүдийн өвчтөнийг стационарт хэвтүүлсэн хувь:

Эмэгтэйчүүдийн өвчтэй эмэгтэйчүүдээс
стационарт хэвтүүлсэн өвчтөний тоо х 100

Эмэгтэйчүүдийн өвчтэй бүх эмэгтэйн тоо

СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

Б, ДЭМБЭРЭЛ

БНМАУ-Д ЭМНЭЛГИЙН БОЛОВСОН ХҮЧИН БЭЛТГЭСЭН ТҮҮХИХ ЭМЧ НАРЫН БҮРЭЛДЭХҮҮНД ХИЙСЭН ЗАРИМ СУДАЛГААНЫ ДҮНГЭЭС

АНАГААХ УХААНЫ ДЭЭД СУРГУУЛЬ

Орчин үеийн шинжлэх ухаан техникийн хувьслын үед эмнэлгийн боловсон хүчнийг бэлтгэх, тэднийг зөв хуваарилж ашиглах, мэргэжил мэдлэгийг нь байнга дээшлүүлэх явдал социалист системийн орнууд, түүний дотор манай орны эрүүлийг хамгаалахын анхаарлын төвд байгаа гол гогцоо асуудлын нэг юм.

Хэвлэлийн мэдээнээс үзэхэд дэлхий дээр 78000 дээд сургууль салбар байгаагийн дотор анагаах ухааны дээд сургууль салбар 800 байгаа нь бүх дээд сургуулийн 1% орчмыг эзэлж байна.

Дэлхийн Эрүүлийг Хамгаалах Байгууллагын (ДЭХБ) экспертуудийн тодорхойлсноор 2—3 сая хүн амд анагаах ухааны нэг дээд сургууль ногдох ёстой гэж үзвэл социалист бүх орон энэхүү заагийг хэдийнээ давж эмнэлгийн дээд сургуулиудаар сайн хангагдсан байна.

Энэ ч учраас социалист орнуудад эмч нарын жилийн дундаж өсөлт хөрөнгөтөн орныхоос үлэмж давуу байна. БНАГУ-д 8%, БНПАУ-д 7%, БНМАУ-д 6,6% байхад хөгжингүй капиталист орнуудад энэ үзүүлэлт 2—4% байна.

ДЭХБ-ын тооцоолсноор 1950 онд дэлхийн 1 095 500 эмч (10 000 хүн амд 5,74 их эмч байсан бол 1970 онд 2 192 700 (10 000 хүн амд 7,91) болсон нь 1950—1960 онд 44,5% 1960—1970 онд 38,5%-иар өсчээ. 1970 оны байдлыг ундэслэн гаргасан урьдчилсан тооцоогоор 2000 онд дэлхий дээр хүний их эмч нарын тоо 4 206 500 хүрэх бөгөөд 1970—1980 онд 28,3% 1980—1990 онд 23, 6%, 1990—2000 онд 21% иар тус тус өсөх төлөвтэй байна. [6] ДЭХБ-ын сүүлчийн мэдээгээр (1977) дэлхийн 3,3 сая эмч (хүн ам 4 млрд) ажиллаж байгаа бөгөөд 100 000 хүнд 80 их эмч буюу 1 их эмчид 1237 хүн ногдож байна.

Хүснэгт 1

Хэрэв үүнийг дэлхийн тивүүдийн байршилаар
хуваарилбал

| Тив | 100000 хүнд ноогдох их эмчийн тоо | 1 их эмчид ноогдох хүний тоо |
|-------------|-----------------------------------|------------------------------|
| Африк | 18 | 5434 |
| Ази | 35 | 2877 |
| Хойд Америк | 169 | 592 |
| Европ | 181 | 552 |

Эмчээр хамгийн бага хангагдсан Зүүн Африкт 100000 хүнд 6 эмч буюу нэг их эмчид 17480 хүн ногдож байхад эмчээр үлэмж сайн хангагдсан Баруун Европт 100000 хүнд 190 их эмч буюу нэг их эмчид 528 хүн, дэлхийн социализмын тэргүүний орон ЗХУ-д (шүдний эмчийн хамт (100000 хүнд 344,9 их эмч буюу нэг их эмчид 290 хүн ногдож байхад дэлхийн өндөр хөгжилтэй капиталист орон АНУ-д нэг их эмчид 595, Японд 845 ногдож байна. [5]

ДЭХБ-ын албан ёсны материалаас үзэхэд дэлхий дээр их эмчээр үлэмж сайн хангагдсанд тооцогдох (1 их эмчид 1000-аас илүүгүй хүн ногдох) 30-аадхан орон байгаагийн эхний байрыг ЗХУ, социалист нөхөрлөлийн бусад орон эзэлж байна.

Анагаах ухааны боловсролыг хөгжүүлж эмнэлгийн боловсон хүчин бэлтгэх талаар дэлхийн социалист системийн орнуудад дараах үндсэн зарчмууд тогтон мөрдөгдж байна. Үүнд:

Эмнэлгийн боловсролыг төр улсаас эрхлэн олгох, төлөвлөгөөтэй хөгжүүлэх, хөрөнгө чинээ яс угсаа үндэсний хязгаарлалтгүйгээр бүх хүн амд хүрэлцээтэй (нээлттэй) байх, үнэ төлбөргүй сургах, эмч нарыг хүнийг хайлрах энэрэнгүй үзэл, анагаах ухааны деонтологид сургах, эмнэлгийн сургууль төгссөний дараа ажилгүйдэлд хүрэхгүй нөхцөлийг хангах зэрэг зарчим нь аль ч хөрөнгөтөн оронд угүй юм.

Дэлхийн социалист системийн нэгдмэл гэр бүлийн нэгэн гишүүн БНМАУ ардын хувьстгалын түүхт 62 жилдээ ардын эрүүлийг хамгаалахын социалист системийг хөгжүүлэх, эмнэлгийн боловсон хүчин бэлтгэх талаар томоохон амжилт олж, эмнэлгийн боловсон хүчиний хангамжийн хувьд ах дүү социалист орны дотор доогуур бус суурь эзлэх болж, дэлхийн өндөр хөгжилтэй капиталист зарим орныг гүйцэж түрүүлсэн байна.

Хүснэгт 2

ЭЗХТЗ-ийн гишүүн социалист зарим орны их эмчийн хангамж

| Улсын нэр | 1965 он | | 10 000 хүн амд ногдох их эмчийн тоо |
|-----------|----------------------------------|----------------------------|-------------------------------------|
| | 10 000 хүнд ногдох их эмчийн тоо | Нэг их эмчид ногдох хүн ам | |
| 1. ЗХУ | 23,9 | 435 | 37,0 |
| 2. БНБАУ | 1 0 | 605 | 28,2 |
| 3. БНУАУ | 18,6 | 537 | 26,8 |
| 4. БНАГУ | 11,5 | 372 | 24,9 |
| 5. БНСРУ | 14,6 | 682 | 17,9 |
| 6. БНПАУ | 12,6 | 796 | 23,9 |
| 7. БНСЧУ | 20,5 | 487 | 29,5 |
| 8. БНМАУ | 13,5 | 756 | 22,0 |
| 9. БНҚУ | — | — | 18,6 |

Манай оронд анагаах ухааны боловсон хүчиний хангамж ийнхүү сайжирсан нь тус улсын ардын эрүүлийг хамгаалах болон ардын боловсролын системийн түүхэн хөгжилтэй салшгүй холбоотой юм. Үүнээс үндэслэн бид тус улсын эрүүлийг хамгаалахын хөгжлийн түүхийн үндсэн үе шатуудын дагуу эмнэлгийн боловсон хүчиний асуудал хэрхэн шийдвэрлэгдэж байсныг түүхчилэн судлах, анагаах ухааны боловсрол, боловсон хүчиний одоогийн бүрэлдэхүүн, хангамжийн байдалд зарим судалгаа хийв. [6]

Ганц удаагийн өгүүллээр судалгааны бүх материалыг хамрах боломжгүй тул гол агуулгын талаар тоймчлон өгүүльье.

Хүснэгт 3

**БНМАУ-ын анагаах ухааны боловсрол, эрүүлийг хамгаалахын
боловсон хүчний хөгжих ирсэн түүхийн үндсэн үе шатууд**

| | | |
|--|---|--|
| <p>Эрүүлийг хамгаалахын хөгжлийн үндсэн үе</p> | <p>Анагаах ухааны боловсрол эмнэлгийн боловсон хүчний талаар шийдвэрлэсэн үндсэн асуудал</p> | <p>Боловсон хүчин, бэлтгэж байсан үндсэн хэлбэр</p> |
| <p>I Ардын хувьсгалын ардчилсан шатан дахь эрүүлийг хамгаалах яв- дал (1921—1940)</p> | <p>ЗХУ-ын тусlamжтайгаар шинжилэх ухааны (Европ) эмнэлгийн мэдлэг бүхий дунд, дээд боловсролтой үндэсний боловсон хүчнийг бэлтгэн эхэлж, анагаах ухааны боловсролыг сур- гуулийн системээр эзэм- шүүлэх эхлэлт тавьсан үе.</p> | <p>а) ядуу ардын дотроос ит- гэл бүхий хүмүүсийг эмнэл- гийн удирдах ажилд дэвшүү- лэх. б) ЗХУ-д явуулан сургах буюу урьж ирсэн мэргэжилт- ний дагалдуулан сургах. в) Ардын армийн цэрэг офицер дундаас сургууль курст явуулах, буюу удирдах ажилд дэвшүүлэх. г) гадаад дотоодын сур- гууль курс төгссөн нам, эвлэ- лийн зарим гишүүдийг ЭХБ-д зориуд шилжүүлэн томилох. д) дотооддоо сувилагчийн курс, эмнэлгийн дунд сур- гууль байгуулах.</p> |
| <p>II БНМАУ-д социализ- мын үндсийг байгуулах үеийн эрүүлийг хамгаа- лах явдал. (1940—1960).</p> | <p>Анагаах ухааны боловсрол эзэмшүүлэх, эмнэлгийн боловсон хүчин бэлтгэх улсын нэгдсэн систем бүрэлдэн тогтох, дээд боловсролтой боловсон хүчнийг эх орондоо бэлтгэн гаргаж, эмнэлгийн боловсон хүчиний мэргэжил дээшлүүлэх ажил эхлэн тавигдсан үе.</p> | <p>а) улсын их сургуулийн анагаах ухааны факультетээр их эмч нар бэлтгэх ба мэргэжил эзэмшүүлэх. б) Анагаах ухааны дунд сургууль, бусад курсээр бэлтгэх. в) ЗХУ болон бусад оронд явуулан сургах буюу уригдаж ирсэн мэргэжилтний дагалдуулан сургах.</p> |
| <p>III БНМАУ-д социализ- мын материал техникийн баазыг өрнүүн байгуу- лах үеийн эрүүлийг хам- гаалах (1960 оноос хойш)</p> | <p>Анагаах ухааны боловсрол эзэмшүүлэх эмнэлгийн боловсон хүчин бэлтгэх улсын нэгдсэн систем уламжллыг бэхжин хөгжиж, төрөлжсөн нарийн мэргэжлийн боловсон хүчнийг олон оор бэлтгэн гаргаж, эмнэлгийн боловсон хүчиний мэргэжил дээшлүүлэх нэгдмэл систем бүрэлдэн тогтох, анагаах ухааны эрдэм шинжилгээний боловсон хүчнийг бэлтгэх эхлэлт суурь тавигдаж хөгжсөн үе.</p> | <p>а) анагаах ухааны бие даасан дээд сургуулийг нарийн мэргэжлийн салбартайгаар байгуулах. б) анагаах ухааны эрдэм шинжилгээний хүрээлэн болон эрдэм шинжилгээний бусад байгууллага байгууллагдаж улсын чанартай эмнэлгүүдэд эрдэм шинжилгээний ажил хийж эхлэв. в) анагаах ухааны дунд сургуулиудыг өргөтген байгуулж, сувилагчийн бие даасан 2 жилийн сургуулиуд байгуулж элсэгчдийн өрнхий боловсролыг шат ахиулав. г) ЗХУ болон бусад гадаад оронд явуулан сургах буюу уригдаж ирсэн мэргэжилтний дагалдуулан сургах. д) дотооддоо дээд, дунд мэргэжилтний мэргэжил олгох, дээшлүүлэх хэлбэрийг өргөтгэх. е) Дэлхийн эрүүлийг хамгаалах байгууллагын тусламжийг ашиглах.</p> |

Архив-түүхийн материалыас бидний судалж тогтоосноос узэхэд тус улсын болон эрүүлийг хамгаалахын хөгжлийн түүхийн үндсэн үе шатуудад анагаах ухааны боловсрол, эрүүлийг хамгаалахын боловсон хүчиний хөгжиж ирсэн түүхийг дараах үндсэн З үе шатанд хувааж болох байна.

Тус улсын эмнэлгийн боловсон хүчин ийнхүү ардын хувьсгалын жилүүдэд манай орны ардын сэхээтний бурдэл хэсгийн нэг болон хөгжихэд манай анд нөхөр аугаа их ЗХУ-ын үзүүлсэн тусlamж шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн байна.

Иймээс манай оронд эмнэлгийн боловсрол, боловсон хүчин хөгжсөн түүхийг ЗХУ-ын үзүүлсэн ах дүүгийн өгөөмөр тусlamжаас салангид ойлгож үл болно.


Бидний судалж тогтоосон урьдчилсан материалыар 1921—1970 онд тус улсын эрүүлийг хамгаалах байгууллагад ЗХУ-аас 1000 гаруй эмч, мэргэжилтэн уригдаж ажилласны 4,2% нь анагаах ухааны дунд, дээд сургуульд багшаар уригдсан бөгөөд 50-иад оны дунд үеийг хүртэл сургалт-хүмүүжил, эрдэм шинжилгээний ажлыг үндсэнд нь гардан хашицаж шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байжээ.

Тус оронд уригдан ажилласан зөвлөлтийн эмч, эрдэмтэн, мэргэжилтүүд нь зөвхөн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэн өгсөн төдийгүй, манай оронд социалист шинэ соёлыг түгээх, эмч эмнэлгийн ажилчдыг эзэмшсэн мэргэжил, нам ард түмний үйл хөрөгт үнэнч шударга хандах социалист ухамсарт чигнэр болон социализмын үеийн эмч хүний хамгийн нинжин энэрэнгүй сэтгэлтэй байх ёс суртахууны бүхэл бүтэн өв уламжлал үлдээснийг онцлон тэмдэглэх нь чухал юм.

Одоо тус улсын их эмч нарын бүрэлдэхүүн, байршил, тогтвортсуурьшилд хийсэн судалгааны зарим материалыас өгүүльье.

а) их эмч нарын наслы ба ажилласан хугацааны байдалд хийсэн бидний судалгаанаас (1969—1970) үзэхэд манай эмч нар наслы хувьд ч (87,1% нь 25—50 наслы хүмүүс) ажилласан хугацааны хувьд ч (58,3% ажиллаад 10 жил болоогүй) харьцангуй залуу байгаа нь үндэсний их эмч нарыг 1940 өөд оны сүүлээс бэлтгэж өхэлсэн манай анагаах ухааны боловсролын түүхэн хөгжилтэй холбоотой бөгөөд нийт эмч нарын 96%-иас илүү нь ардын засгийн жилүүдэд төрж, хүмүүжсэн байна.

Зураг 1



Зураг 2



Бидний судалгааны материалыг зарим судлаачдын судалгаатай харьцуулж үзвэл 25—50 наслы эмч нар 86,7%-ийг эзэлж эмч нарын дундаж нас 37,1 болж 49,7% нь ажиллаад арван жил болоогүй залуу эмч нар байгаагийн дийлэнх нь хөдөөнчий эмнэлгийн байгууллагуудад ажиллаж байгаа ажээ. [4] Энэ нь манай орны эрүүлийг хамгаалах болон нам, улс, олон нийтийн аль ч байгууллага залуу эмч мэргэжилтнийг хөдөлмөрийн талбар, хамт олны дунд ажил дээр нь байнга сургаж, хүмүүжүүлэхийн онц чухлыг зааж байна. Сүүлийн 10—15

жилд манай эмч нарын дотор хөдөлмөрийн хамт олны ахмад үе бүрэлдэж утсын баатар I, хөдөлмөрийн баатар 1, БНМАУ-ын гавьяат эмч 31, анагаах ухааны доктор 7, доцент профессор 20 гаруй, анагаах ухааны дэд эрдэмтэн 170 гаруй болсон нь залуу эмч нарын ёс суртахууны хүмүүжил, мэргэжлийн сургалтанд ашиглавал зохих халамжлан хүмүүжүүлэгчдийн чухал нөөц юм.

б) БНМАУ их эмчийн ерөнхий хангамжаар (1980 оны байдлаар 10 000 хүн амд 22 их эмч, 1 их эмчид 457 хүн ногдох) социалист орны дотор доогуур бус байр суурь эзэлж байгааг дээр өгүүлсэн билээ. Гэтэл энэ байдлыг аймаг хотоор авч үзвэл анхаарал татахуйц байдал харагдаж байна

Хүснэгт 4

Аймаг, хотын их эмчийн хангамж

| Аймаг хотын нэр | 1970 он | | 1980 он | |
|------------------|---------------------------|-----------------------------|---------------------------|--------------------------|
| | 10 000 хүнд ногдох их эмч | 1 их эмчид ногдох хүний тоо | 10 000 хүнд ногдох хүн ам | 1 их эмчид ногдох хүн ам |
| Аймгуудын дундаж | 10,0 | 1005 | 12,8 | 779 |
| Улаанбаатар хот | 41,0 | 244 | 41,8 | 240 |
| Дархан хот | 32,7 | 440 | 21,1 | 474 |
| Улсын хэмжээгээр | 17,9 | 560 | 21,9 | 457 |

Хүснэгтээс үзэхэд Улаанбаатар, Дархан хотод I их эмчид ногдох хүний тоо аймгуудаас 2—3 дахин цөөн байна. Хэдийгээр Улаанбаатар, Дархан хотод хүн ам, үйлдвэрүүд, нарийн мэргэжлийн эмнэлгийн байгууллагууд төвлөрч, хотын хангамж зарим талаар хөдөөгийнхөөс илүү байх шаардлагатай боловч хүн амын маань 49% хөдөө орон нутагт оршин суудаг манай орны нөхцөлд хот, хөдөөний их эмчийн хангамжийн дээрх ялгааг хэвийн байдал гэж үзэж болохгүй юм. Сүүлийн жилд (1981) хийсэн зарим судалгаа (Г.Зуунай)-гаар энэ тоо Эрүүлийг хамгаалах Яамны тайлангаас нилээд бага (Улаанбаатарт 10,000 хүнд 22,7 бусад байгууллага (Хөдөөд 13,4 эмч үйлчилж) байгаа нь эмнэлгийн үйлчилгээнд шууд ажиллаж байгаа эмч нараар тооцсоноор тайлбарлагдана.

Үүнээс үндэслэн БНМАУ-ын эрүүлийг хамгаалах Яам суулийн жилүүдэд анагаах ухааны дээд сургууль төгсөгчдийн 80—85%, дунд сургууль төгсөгчдийн 90—95%-ийг хөдөө орон нутагт хуваарилагдсныг тоогоор авч үзвэл хөдөөний эмнэлгийн байгууллагуудын батлагдсан орон тооноос давж байгаа юм. Гэвч энэ зөрүүг төдийлөн багасаж чадахгүй байгаагийн шалтгааныг судлан үзвэл анагаах ухааны сургуулиуд, ялангуяа дээд сургуулийн элсэлтийн хуваарь төлөвлөгөө аймгуудын болохсон хүчиний бодит хэрэгцээнд тохирогчийг аймгуудыг өөрийн нутгийн боловсон хүчинээр хангах хэтийн төлөвлөгөөгүй, эмч нарын шилжилт хөдөлгөөн жил бүр харьцангуй их байгаагаас болж байна. Бидний судалгаагаар жилд дунджаар (Эрүүлийг хамгаалах яамны систем) их эмч нарын 10—14%-д шилжилт хөдөлгөөн байгаа нь харьцангуй өндөр юм. Сүүлийн жилд хийсэн зарим судалгаагаар ЭХЯ-ны системд ажиллаж байгаа эмч нарын 7,1% нь жилд ажлаас гарч (хөндийрч) байгаагийн 15,2% нь нас барах, тахир дутуу болох насны тэтгэвэрт гарах зэрэг шалтгаанаар, 79,3% нь шилжих хөдөлгөөнөөр, 5,4 удаан угсааны томилолт буюу бусад шалтгаанаар хөндийрч байна. [2]

1966—1969 онд шилжсэн 225 эмчид хийсэн бидний (зориудын) су-
далгааны материалаас узэхэд:

Хүснэгт 5

Их эмч нарын шилжилт хөдөлгөөн
(хувиар)

| Бүх шилжсэн эмч | Аймгаас УБ хот | УБ хотоос аймагт | Аймгаас аймагт |
|--------------------|----------------|------------------|----------------|
| 100,0 | 65,7 | 25,9 | 8,4 |

Шилжилт хөдөлгөөн хийсэн эмч нарын бараг 2/3 нь аймгаас Улаанбаатар хотод шилжсэн байна. Шилжилтийн шалтгаанаар үзэхэд 5,3% нь өвчний учир, 84,9% нь гэр бүл төрөл төрөгсдийн гачигдал, зайлшгүй ажлын шаардлагын улмаас, 9,8% нь бусад шалтгааны учир шилжсэн байна. (Яамны томилолт, курс, сургууль зэрэг).

Бид эмч нарын шилжилтийн шалтгааныг тогтосохын тулд орон нутгийн эмч нарын бүрэлдэхүүнтэй харьцуулан 6 аймагт зориуд судалсан юм.

Хүснэгт 6

Зарим аймгийн их эмч нарын дунд орон нутгийн харьяат нарын
эзэлж байгаа хувийн жин, эмч нарын шилжилтийн жилийн дундаж
(хувиар)

| Аймгийн нэр | Өөрийнхөө аймагт ажиллаж байгаа орон нутгийн их эмч нарын хувийн жин | Их эмч нарын шилжилтийн жилийн дундаж хувь |
|----------------|--|--|
| 1. Баян-Өлгий | 91,4 | 9,2 |
| 2. Увс | 98,8 | 9,8 |
| 3. Сүхбаатар | 78,9 | 6,9 |
| 4. Булган | 67,4 | 18,1 |
| 5. Говь-Алтай | 64,4 | 18,1 |
| 6. Дорноговь | 19,5 | 15,2 |

Хүснэгтээс үзэхэд ажиллаж байгаа их эмч нарын 78,9—98,8%-ийг өөрийн нь нутгийн харьяат эмч нар эзэлж байгаа Сүхбаатар, Увс, Баян-Өлгий аймгуудад эмч нарын шилжилт харьцангуй бага (6,9—9,8%) ажиллаж байгаа их эмч нарын 35,6—80,5%-ийг өөр аймаг нутгийн хүмүүс эзэлж байгаа Дорноговь, Говь-Алтай зэрэг аймгуудад эмч нарын шилжилт их (15,2—18,1%) тогтвортой суурьшил муюу байна.

Судалгааны материалаас үзэхэд орон нутгийг эмнэлгийн боловсон хүчинээр хангахад анагаах ухааны дээд, дунд сургуульд элсэгчдийн хүйсний харьцааг зөв тогтоох явдал чухал ач холбогдолтой хүчин зүйл юм.

Үнээс үзэхэд амьдралын болон бусад шалтгаанаар эмэгтэй эмч нарын ихэнх нь Улаанбаатар хот, аймгийн төвүүдэд суурilan сууж, сум дундын эмнэлэг, их эмчийн салбаруудад цөөн ажиллаж байгаа нь орон нутгийг их эмчээр жигд хангах асуудлыг хүндруулж байж болзошгүй юм.

Энэ асуудлыг хөндөхдөө бид манай эрүүлийг хамгаалахын хөгжлийн түүх, эмнэлэг үйлчилгээнд эмэгтэй боловсон хүчин онцгой чу-

Хот, хөдөөний эмнэлгийн салбаруудад ажиллаж байгаа
эмэгтэй эмч нарын хувийн жин
(1969—1970 он)

| Ажлын байр | Улаанбаатар хот | Аймгийн төв | Сум дундын эмнэлэг, их эмчийн салбарт |
|------------------------------------|-----------------|-------------|---------------------------------------|
| Эмэгтэй эмч нарын эзлэх хувийн жин | 55,0 | 43,0 | 32,3 |

Ал үүрэг гүйцэтгэсээр ирсэн, одоо ч гүйцэтгэж байгаа, цаашид ч гүйцэтгэнэ гэдгийг онцгойлон цохон тэмдэглэхийг хүсч байнэ.

Манай эрүүлийг хамгаалахын хөгжлийн түүхээс үзвэл тус улсын анхны сувилагч (Бумаа, Жанчив зэрэг 12 эмэгтэй) Эрүүлийг хамгаалах яамны анхны сайд Д. Пунцаг, анагаах ухааны анхны доктор В. Ичинхорлсо, гихны их эмч Д. Сэргжмядаг нар цөм эмэгтэйчүүдийн дундаас төрөн гарсан билээ. Бидний судалгаагаар (1970) их эмч нарын 53,7%, 1982—1983 оны хичээлийн жилд Анаагаах ухааны дээд сургуульд суралцаж байгаа оюутны 81,4% нь эмэгтэйчүүд байгаа нь цаашид ч манай эрүүлийг хамгаалахын ажиллах хүчиний бүрэлдэхүүнд эмэгтэйчүүд зонхицж чухал үүрэг гүйцэтгэх нь тодорхой байна.

Энэ бүгд бол зөвхөн социалист нийгмийн уед эмэгтэйчүүд улстөрийн бүрэн эрхээ эдэлж, нийгтийн тэгш эрхт гишүүн байдгийг нотлон харуулж байгаа чухал тоо баримт юм.

Үүнээс үндэслэн цаашид улс ардын аж ахуй соёлын нийт салбарын боловсон хүчиний бүрэлдэхүүний хэрэгцээ шаардлагатай уялдуулан эмч нарын дунд эмэгтэйчүүдийн хувийн жинг бууруулах уу эсвэл эмэгтэй ажилчдын хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөр хамгаалал, материалаг сонирхлыг сайжруулах, дээшлүүлэх замаар хөдөөний эмнэлгийн боловсон хүчиний хангамжийг сайжруулах уу гэдэг асуудлыг судлан тогтоох хэрэгтэй санагданэ.

В) Орчин үеийн анагаах ухааны хөгжил болон эмнэлгийн нарийн мэргэжлийн тусlamжийн талаар хөдөлмөрчдийн байнга ёсч байгаа эрэлт шаардлагын дагуу эмч нарийн мэргэжил эзэмшүүлэх тэдний мэргэжил мэдлэгийг байнга дээшлүүлдэх явдал аль ч орны эрүүлийг хамгаалахын нэн чухал асуудал юм.

Нарийн мэргэжлийн эмч нарыг олноор бэлтгэх шаардлагатай холбогдуулан төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч, ерөнхий үйлчилгээний эмч (врач-специалист, врач общего профиля) хоёртын хоорондын харьцааг зэв судлан тогтоох явдал чухал асуудал болон тавигдаж байна. Энэ нь хүн амын байршилтын онцлогоос шалтгаалан их эмчийн салбарыг олноор байгуулсан манай орны нөхцөлд улам ч онцгой ач холбогдолтой байна.

Судалгаанаас үзэхэд (Б. Дэмбэрэл, 1970. Г. Зуунай 1981) нарийн мэргэжлийн эмч нарын эзлэх хувийн жингийн хувьд манай улс социалист орны дотор дундаж байрыг (61,3%, 78,4%) эзэлж байгаа боловч цаашид уг асуудлыг шинжлэх ухааны үндэстэйгээр нарийвчлан судалж тогтоох шаардлагатай байна.

Учир нь эмнэлгийн үйлчилгээг 5—15 км-ийн радиуст явуулдаг оронд нарийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх нэг ёөр байхад манай орон шиг 48 ± 20 км-ийн радиуст үйлчилгээ явуулдаг оронд уг мэргэжилтийг бэлтгэх нь бас ёөр асуудал юм. Нэгөө талаар хамар хоолой, нуд, зүрх судасны зэрэг мэргэжилтийн загвар, мэргэж-

лийн шинж байдлыг тодорхойлох нь нэг өөр, сумын эмнэлэг буюу сүм дундын эмнэлгийн түвшинд ажиллах мэргэжилтний загвар боловсруулж түүнд сургалтын төлөвлөгөө программыг уялдуулан арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь эрс өөр асуудал болно.

Мөн судалгаанаас үзэхэд нарийн мэргэжил эзэмшсэн эмч нарыг мэргэжлийн бус ажил хийлгэх, зарим мэргэжлийн эмч нарын дунд элдэв шалтгаанаар мэргэжлээ солих явдал барагүй байгаа нь дадлага туршилагатай мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд муугаар нелөөлж байнз. Бидний материалыаар нарийн мэргэжил эзэмшсэн боловч уг мэргэжлээрээ ажиллаагүй өөр ажил хийж байгаа эмч нарын 90,9% хөдөөний эмнэлгийн салбаруудад байгаа нь орон нутгийн эмнэлгийг ерөнхий мэргэжлийн (врач общего профиля) эмч нараар хангаж чадаагүйтэй холбоотой байна. Мөн рентген гэрлийн ба задлан шинжилгээ, мэс заслын эмч нарын мэргэжил дээрээ ажиллаж байгаа байдлыг судлан үзэхэд 22,4—39,5% нь 4—5 жилд мэргэжлээ сольсон байлаа.

ДҮГНЭЛТ. 1. Эмнэлгийн боловсон хүчинийг бэлтгэх, хуваарилах, ашиглах тэднийг мэргэжүүлэх, мэргэжлийг нь дээшлүүлэх асуудал аль ч орны эрүүлийг хамгаалахын түгээмэл шинж чанартай гол гогцоо асуудал боловч улс орны нийгэм, эдийн засаг соёлын шинж чанар, ангийн бүрэлдэхүүн улс төрийн бодлогоос шалтгаалан социалист, капиталист орнуудад зарчмын ялгаатай шийдвэрлэгдэж байна.

2. БНМАУ-д анагаах ухааны боловсрол, эмнэлгийн боловсон хүчин бэлтгэх асуудлыг тус улсын түүхэн хөгжлийн үе шатуудад өвөрмөц онцлогтойгоор шийдвэрлэж иржээ.

3. Манай орны эрүүлийг хамгаалахын хөгжлийн одоогийн үе шатанд их эмч нар насын бүрэлдэхүүний хувьд ч, мэргэжлийн хувьд ч залуу байгаа онцлогийг цаашдын төлөвлөлт, боловсон хүчинтэй ажиллах ажиллагаанд тусгаж, ахмад болон залуу боловсон хүчиний зөв хослуулан ажиллуулах зарчмыг чанд баримтлах.

4. Тус улсын эрүүлийг хамгаалахын түүхэнд эмэгтэй эмч, ажилчид чухал үүрэг гүйцэтгэж ирсэн бөгөөд цаашид ч зонхилох суурийг эзлэх төлөвтэй байна.

5. Улсын хэмжээгээр эмчийн ерөнхий хангамж өндөр байгаа боловч хот хөдөөний эмнэлгийн байгууллагуудын хангамж үлэмж зөрүүтэй байна. Үүнийг багасгаж хот хөдөөний эмнэлгийн байгууллагуудыг эмчээр жигд хангах, боловсон хүчиний тогтвортой суурьшилтай ажиллуулахад анагаах ухааны дээд, дунд сургуулийн элсэлтийн төлөвлөгөөг, аймгуудын боловсон хүчиний хэрэгцээний хэтнийн төлөвтэй нягт уялдуулан зохиож уг аймгийн үндсэн харьяат нараас эмч нарыг бэлтгэн хангах явдал шийдвэрлэх ач холбогдолтой байна.

6. Хүн зам сийрэг суурьшин, эмнэлгийн байгууллагууд тархай байгаа манай орны өвөрмөц нөхцөлд ерөнхий үйлчилгээний болон төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын хсорондын харьцаа уялдааг зөв тогтоон бэлтгэх, боловсон хүчиний хэрэгцээний үндэслэлтэй норматив тогтоох асуудал эрдэм шинжилгээний тусгайлсан судалгаа шаардаж байгаа гол гогцоо асуудлын нэг мөн.

7. Тус орны эмнэлгийн байгууллагуудын зохисн байгуулалтын онцлог, үйлчилгээний радиусын байдлыг харгалзан сумын болон сүм дундын эмнэлгийн түвшинд ажиллах их эмч нарын загвар, мэргэжлийн шинж байдлыг боловсруулж сургалтын төлөвлөгөө, программд тусгах нь сургалтыг боловсруулж болгох практик шаардлагын нэг мөн.

НЕКОТОРЫЕ РЕЗУЛЬТАТЫ ИЗУЧЕНИЯ ИСТОРИИ МЕДИЦИНСКОГО ОБРАЗОВАНИЯ, ПОДГОТОВКИ И СОСТАВА МЕДИЦИНСКИХ КАДРОВ В МНР.

Б. Дэмбэрэл

Изучены история развития медицинского образования и подготовки медицинских кадров в МНР и некоторые вопросы состава, размещения, текучести и специализации врачебных кадров. В работе применены архивно-исторические, социально-гигиенические и статистические методы исследования. На основе изучения выше указанных вопросов автор выдвигает определенные стадии развития подготовки медицинских кадров и образования соответственно с периодизацией истории развития здравоохранения МНР и предлагает некоторые практические рекомендации по улучшению эффективного использования врачей и усовершенствования учебных процессов в медицинском институте.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. В. И. Ленин. зохиолууд. боть. 33.285.
2. Ю. Цэдэнбал. МАХН-ын XVII их хуралд тавьсан МАХН-ын Төв Хорооны тайлан илтгэл УБ. 1976. 68.
3. Б. Дэмбэрэл. Медицинское образование и кадры МНР. 1921—1970 канд. диссерт. Баку, 1972.
4. Г. Зуунай. Социально-гигиеническая и профессионально-демографическая характеристика врачебных кадров МНР и пути повышения эффективности их использования. Автореф. канд.диссерт. М.1981.
5. Жур. Здоровье Мира. № 5. 1981. 30.
6. wold Health sjajislicel report. vol 27, № 2 Geneve 2974 WHO pp. 98—99.

Н. ЖАМБАЛДОРЖ, д. МАНГЛА

ЗҮРХ СУДАСНЫ ӨВЧНИЙГ АНАГААХ ЗАРИМ ЭМИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ СТАТИСТИК СУДАЛГАА

УЛСЫН ЭМ ХАНГАМЖ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ГАЗАР

Бид өөрийн срны эмнэлгийн практикт хэрэглэж буй зүрх судасны өвчний анагаах бүлгийн эмийн хэрэглээний хандлага хүртээмжийг тодорхойлох зорилго тавив. Үүний тул улсын хэмжээнд хэрэглэгдэж байгаа дээрх өвчний эмүүдийн сүүлийн 11 жилийн бодит зарцуулалтыг статистик-математикийн аргаар судалж, 1980 оноос хойшхи 4 жилийн хэрэглээний прогнозыг илрүүлэх судалгаа явууллаа. Энэ судалгаанд улсын хэмжээний эмийн зарцуулалтын нэгдсэн бүртгэлүүд, эмнэлгийн байгууллагуудын эрэлт хэрэгцээнд үндэслэж хийдэг эмийн гадаад захиалга, улирал жилийн дотоодын захиалга, системийн байгууллагын

жил бурийн эмийн үлдэгдлийн нэгдсэн бүртгэл зэргийг боловсруулах замаар зарцуулалтын динамик эгнээ зохиож, түүний дунг математик аргаар тэгшигэх хэлбэрээр явууллаа.

Манай орны эмнэлгийн практикт сүүлийн жилүүдэд зүрх судасны өвчин анагаах зориулалтын 61 нэр төрлийн бэлдмэлүүд хэрэглэж байгаагаас 57 нь голчлон зарцуулагдаж 12 нь сүүлийн таван жилд шинээр нэвтэрч 14 нэр төрлийн бэлдмэлүүд зарцуулагдааа больсноос одоо 20 нэр төрлийн бэлдмэлүүд тогтвортой хэрэглэгдэх болжээ. Бид судлагдсан эмүүдийг зурхний гликозид, хэм алдагдлын эсрэг эм ба бусад агшилт сургуулах, судас өргөсгөх, даралт багасгах гэж гурван бүлэгт хувааж нийт дүн бүлэг тус бурийн интервалт динамик эгнээ зохиож интерполяцийн аргаар судаллаа. Зүрх судасны өвчнийг анагаах эмийн нийт дүн, түүний дотроос кардиовалены бэлдмэлд шулуун шугамын ба парабол тэгшигэл зохиож, ерөнхий хандлагыг тодорхойлоод экстраполяцийн аргыг хэрэглэн цаашид өсөх прогнозыг гаргав.

График 1

Зүрх судасны эмийн үзүүлэлт




График 1-д зүрх судасны өвчнийг анагаах зориулалтын эмүүдийн хэрэглээ 1980 онд 1970 оныхоос 84,5%-иар өсчээ. Судлагдсан хугацааны хэрэглээний байдлаас шалтгаалан эхний 5 жилийн хэрэглээний дундаж өсөлт 5,1% байсан бол сүүлийн 5 жилд 16,0% болсон байна.

Бид эмийн хэрэгцээний прогноз үйлдэх экстраполяцийн судалгаанд шулуун шугамын тэгшигтгэлийн аргыг ашиглаж 1984 он хүртэлх хугацааны жилийн дундаж өсөлтийн хурдыг 5,8% байхаар тодорхойлов.

Зүрх судасны өвчнийг анагаах зонхилох эмүүдийн бодит зарцуулалтыг бүлэгчилэн судлав.

График 2

Бүлэг тус бурийн бодит зарцуулалт





График 2-оос үзвэл зурхний гликозид 1980 онд 1970 оныхоос 29,9%, зурхний хэм алдагдлын эсрэг эм 81,7% бусад (агшилт сургуулах, судас өргөсгөх, даралт багасгах, эмүүдийн хэрэглээ 98,1%-иар тус тус өссөн байна.

Бид кардиовалены хэрэглээний хэмжээнд дээрх аргаар судалгаа хийж үзэхэд түүний хэрэглээний өсөлтийн төлөвийг тодорхойлов.

График 3
Кардиовален 15,0 фл.

— бодит зарцуулалт
— шулуун шугамын тэгшитгэл
— паравол тэгшитгэл



Хэрэглээний судалгааг хамгийн үнэн зөв гаргахын тулд бодит зарцуулалтанд математикийн олон хүчин зүйлт регрессийн аргыг хэрэглэх шаардлагатай байна.

Одоогоор тогтвортой хэрэглэж байгаа эмүүдийг кардиовалены адиллаар нэг бүрчлэн судалгаа хийж ойрын 3—4 жилийн хэрэгцээний төлөвийг тодорхойлж болох үндэс байна.

Судалгаанаас үзэхэд зүрх судасны өвчнийг анааах эмийн жилийн дундаж өсөлтийн хурд 6,3% байгаа бөгөөд үүний дотор зүрхний гликозид 2,7%, бусад бэлдмэлүүдийн хэрэглээ 7,1%-ын дундаж хурдаар тус тус өсч байгааг илрүүлэв. Зүрхний хэм алдагдлын эсрэг үйлчилгээтэй бэлдмэлүүд тооны хувьд цөөн байгаа ба судлагдсан хугацаанд тогтвортой хэрэглэгдэж байсангүй.

ДҮГНЭЛТ. 1. Зүрх судасны өвчнийг анааах эмийн бэлдмэлүүдийн хэрэглээ нийтдээ нэмэгдэх хандлагатай байна. Ялангуяа агшилт сургуулах, даралт багасгах эмийн зүйлсийн хэрэгцээ их байна. Харин зүрхний хэм алдагдлын эсрэг эмүүдийн зарцуулалт тогтвортой бус байна.

2. Судалгаанд хамрагдсан 60 гаруй эмүүдээс 20 нэр төрлийн эмийг эмнэлгийн практикт тогтвортой хэрэглэх болжээ. Эдгээрийн хэрэглээг бэлдмэл тус бүрээр нь судалж хэрэгцээний төлөвийг тогтоож хангамжийг сайжруулах боломж байна.

3. Эмийн хэрэглээнд статистик-математикийн судалгаа хийж цаашдын хэрэгцээний төлөвийг тогтоож практикт ашиглах боломжтой бөгөөд өвчлөлийн байдал, бусад хүчин зүйлүүдтэй холбон иж бүрэн судлах явдал чухал байна.

СТАТИСТИЧЕСКИЕ ДАННЫЕ ПОТРЕБЛЕНИЯ СЕРДЕЧНО-СОСУДИСТЫХ СРЕДСТВ

Н. Жамбалдорж, Д. Манга

Изучено потребление сердечно-сосудистых средств за последние 11 лет. Проведенные исследования показали, что средний годовой темп роста потребления сердечно-сосудистых средств составлял 6,3%, в том числе, сердечные глюкозиды-2,7%, антиаритимические препараты-6,1%. и остальные препараты-7,1%

ХҮН АМЫН ЕРӨНХИЙ ӨВЧЛӨЛИЙГ СУДЛАХАД ТҮҮВЭР СУДАЛГААНЫ АРГЫГ ХЭРЭГЛЭХ НЬ

АНАГААХ УХААНЫ ХҮРЭЭЛЭН

БНМАУ-д хүн амын ерөнхий өвчлөлийн судалгааг 1970 оны бүх холбоотын хүн амын тооллоготой холбогдуулан ЗХУ-д хүн амын эрүүл мэндийн байдлыг иж бүрнээр судлах үед боловсруулж баталсан аргачиллын үндсэн дээр Н. А. Семашкогийн нэрэмжит Нийгмийн эруул ахуй эруулийг хамгаалахын зохион байгуулалтын институт (НЭАЭХЗБ), БНМАУ-ын Анагаах ухааны хүрээлэн хамтран явуулж байна.

Тус орны эдийн засаг газар зүйн онцлогийг тусгах зорилгоор говь, хээр, хангай, хотын гэж бүсчилэн хувааж бүрдмэл аргаар судалгааг хийллээ.

ЗХУ болон бусад орны туршлагаас үзэхэд хүн амын эруул мэндийн статистик судалгаанд түүвэр аргыг өргөн хэрэглэж байгаа бөгөөд ЗХУ-д хотын хүн амын өвчлөлийн судалгааг энэ аргаар явуулсан нь хүч хөрөнгө хэмнэсэн хялбар арга болсон байна. [1]

Түүвэр аргаар судалгаа явуулахад судлах нийт үзэгдлээс бүх шинж чанараараа өөрийг нь төлөөлж чадах хэсгийг* зөв сонгон авахад хамгийн гол нь байдаг. [1] Судалгааг хэд хэдэн үе шатаар явуулав. Нэгдүгээрт-судалгааны бааз газраа сонгон авч хамрах хүний тоог тогтоох, хоёрдугаарт-судалгааны бэлтгэлийг хангах хүн амаа сонгон авах, гуравдугаарт-сонгон авсан бааз газартаа тодорхой тооны хүн амын өвчлөлийн материалаас хуулбарлалт, шифрлэлт хийх, дөрөвдүгээрт-материалаа нэгтгэн боловсруулалтанд оруулах, тавдугаарт-хуулбарлалт хийсэн газартаа бүрдмэл үзлэг явуулах.

Хотын бусийг төлөөлүүлэн Улаанбаатар, Дархан хотыг авч тус хоёр хотын 452000 гаруй хүнээс

$$P = -\frac{Nt^2Pq}{N\Delta^2 + t^2pq} \cdot g \quad [2] \quad \text{үндэслэн насанд хүрэгчдээс 40000 хүүхэд (0-15) 15000 нийт 55000 хүн судалгаанд хамруулахаар тогтоов. Судалж байгаа үзэгдлийн шинж чанараас хамаарч ямар аргаар сонголт хийх вэ гэдэг нь их нөлөөтэй юм. Бид энэ 55000 хүнийг механик сонголт буюу тухайн хоёр хотын оршин суугчдаас тодорхой хэдэн үстгээр эхэлсэн нэр бүхий хүн амыг сонгон авсан юм.}$$

Сонголт хийх үсгээ тогтоохын тулд ЗХУ-ын Семашкогийн нэрэмжит институтийн мэргэжилтнүүд улсын клиникийн төв эмнэлэгт нэг жилийн хугацаанд хэвтэж эмчлүүлэгсдийн нэрийн бүрэлдхүүнд судалгаа хийж насанд хүрэгчдэд „А.Г.М.Н. -20%, хүүхдэд „М“-7,5% эзэлж байна гэж тогтсосныг үндэслэн бид ажилчны районы 1979 оны тооллогын материалаас хүн амын нэрийн бүрэлдэхүүнд туршилт судалгаа хийллээ.

Үнээс үзэхэд дээрх үсгүүдэд хүн амаа сонгон авч судалгаа хийхэд бүрэн боломжтой гэж үзээд хотын бусийн өвчлөл судалгааны ажлыг эхлэв. Хүн амын цөөнх хэсгийн дотор (тодорхой хэдэн үсгээр) өвчлөлийг судлахад тухайн хотын бүх төрлийн эмнэлэг, урьдчилан сэргийлэх байгууллагуудын бүртгэлийн тасагт байгаа заагдсан үсгийн картуудыг таних тэмдэгтэй болгох, карт эзэмшигчийн хаягийг тодруулан шинэчлэх, урьдчилан сэргийлэх үзлэг, гэрийн дуудлагын дэвтэр.

Хүснэгт 1

АЖИЛЧНЫ РАЙОНЫ А. Г. М. Н-УСГЭЭР
ЭХЭЛСЭН НЭРСИЙН ЭЗЛЭХ ХУВЬ

(1979 оны хүн амын тоол-
логын материалаар)

| Нэрийн эхний усэг | Эзлэх хувь | |
|-------------------|-----------------|-------------------|
| | насанд хүрэгчид | 0-15 насны хүүхэд |
| A | 7,3 | |
| Г | 4,7 | |
| M. | 4,2 | 7,0 |
| H. | 6,4 | |
| Нийт | 21,4 | 7,0 |

диспансерийн хяналтын карт, тусгай мэргэжлийн диспансеруудын картуудаас үзлэгийн мэдээг нөхөн хуулж, З3, 89, 95-р маягтуудыг хавсаргах зэрэг бэлтгэл ажил хийж нэрийн давхардалтыг арилгасны дараа тухайн хүний ёвчлөлийг судалгааны тусгай картанд хуулбарлаж шифрлэлтийг хийллээ.

Энд бид Дархан хотын хүн амын ёвчлөлийг, тайлангийн материалтай харьцуулан харуулав.

Хүснэгт 2

ДАРХАН ХОТЫН ёВЧЛӨЛ
(эмнэлэгт үзүүлснээр 1000 хүнд)

| Өвчиний ангилаал | Эмнэлэгт үзүүлэлтээр | | | Тайлангийн үзүүлэлтээр |
|---|----------------------|-------|-------|---------------------------|
| | эр | эм | бүгд | |
| 1. Халдварт паразитын өвчин | 68,8 | 48,8 | 58,2 | 15,4 |
| 2. Хавдар | 1,7 | 1,1 | 1,4 | 0,3 |
| 3. Дотоод шүүрлийн систем, хоол тэжээлийн хямрал, бодисын солилцооны өөрчлөлт | 2,6 | 3,6 | 3,3 | 5,4 |
| 4. Цус ба цус бүтээх эрхтэний өвчин | 2,1 | 2,6 | 2,4 | 1,4 |
| 5. Сэтгэц зүйн хямрал | 19,4 | 23,0 | 21,3 | 1,8 |
| 6. Мэдрэлийн систем ба мэдрэхүйн эрхтний өвчин | 29,6 | 39,2 | 34,7 | 22,8 |
| 7. Цусны эргэлтийн с/өвчин | 35,4 | 41,8 | 38,4 | 8,9 |
| 8. Амьсталин эрхтний өвчин | 246,1 | 238,9 | 242,3 | 226,7 |
| 9. Хоол боловсруулах Э/Ө | 74,1 | 64,1 | 68,8 | 71,7 |
| 10. Шээс бэлгийн эрхтэн С/Ө | 24,9 | 42,8 | 34,4 | 14,3 |
| 11. Төрөх үеийн ба дараахь/х | = | 25,4 | 13,5 | 1,5 |
| 12. Арьс ба арьсны х/өвчин | 25,5 | 25,4 | 26,6 | 11,7 |
| 13. Яс булчингийн с/ба холбоос эдийн өвчин | 13,2 | 14,7 | 14,0 | 3,5 |
| 14. Төрөлхийн гажгууд | 0,4 | 0,2 | 0,3 | 0,1 |
| 15. Төрөх үеийн өвчлөл ба ухлийн зарим шалтгаан | 2,8 | 5,3 | 4,1 | 1,4 |
| 16. Шинж тэмдгүүд ба тодорхой бус тэмдэглэгдсэн байдал | 1,3 | | 0,6 | |
| 17. Золгүй тохиолдол, хордлого гэмтэл | 31,1 | 15,3 | 22,7 | 4,4 |
| ДҮН | 578,9 | 592,4 | 585,9 | 400,9 |

| Үүнээс үзэхэд: | судалгаагаар | тайлангаар |
|--------------------------------------|--------------|------------|
| 1. Амьсгалын эрхтэний өвчин | 242,3 | 226,7 |
| 2. Хоол боловсруулах эрхтэний өвчлөл | 98,8 | 71,7 |
| 3. Халдвэрт паразитын өвчин | 58,2 | 15,4 |
| 4. Мэдрэлийн эрхтэн системийн өвчин | 34,7 | 22,8 |
| 5. Шээс бэлгийн эрхтэний өвчин | 34,4 | 14,3 |

Эзэлж байгаа өвчлөлийн бүтцийн хувьд онцын ялгаа байхгүй нь харагдаж байна. Бид өөрийн судалгааг 1970 оны ЗХУ-д энэ аргачиллаар хийсэн судалгаатай харьцуулан үзэхэд өвчлөлийн бүтцийн хувьд онцлогтой, түвшингийн хувьд нилээд доогуур байгаа нь харагдлаа. [3]

ДҮГНЭЛТ. 1. Судалгаагаар өвчлөлийн түвшин лоогуур байгаа нь манай эмнэлэг урьдчилан сэргийлэх байгууллагууд эмнэлгийн анхан шатны бичиг, баримтын хөтлөлт муу, өвчлөлийг дутуу бүртгэж байгаатай холбоотой байна.

2. Зарим ангиллын өвчлөлийн түвшин, тухайлбал хорт хавдар, до тоод шүүрлийн систем, хосл, тэжээл бодисын солилцооны өөчинүүд нилээд гарч байгаа нь тухайн нарийн мэргэжлийн эмч нар орон нутагт хүрэлцээ муутай, улсын хэмжээний нарийн мэргэжлийн диспансерт ирж оношуулж эмчлүүлэн, орон нутагтаа бүртгэгддэггүйтэй холбоотой байж болох юм.

3. Өвчлөлийн түвшин эмнэлэгт үзүүлэлтээр доогуур гарсан тул эмч нарын бурдмэл үзлэгийг чанар сайтай зохион байгуулж явуулах шаардлагатай байна.

ПРИМЕНЕНИЕ ВЫБОРОЧНОГО МЕТОДА ДЛЯ ИЗУЧЕНИЯ ОБЩЕЙ ЗАБОЛЕВАЕМОСТИ НАСЕЛЕНИЯ

Д. Батмунх

В статье изложены методы и некоторые предварительные итоги исследования заболеваемости населения городской зоны полученные материалы являются одной из составных частей исследований общей заболеваемости населения МНР.

По предварительным данным наших исследований общая заболеваемость по сбрасываемости на 1000 населения г. Дархана составляет 578,9.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. А. А. Роменский, Г. С. Жуковский, С. А. Леонов. Применение территориально-гнездового метода выборочного наблюдения для изучения общей заболеваемости Ж. Сов. Здравоохр. 1973. № 2. 39.
2. А. А. Роменский, Г. С. Жуковский и др. Методика организация комплексного изучения здоровья населения МНР в связи с государственной переписью населения 1979 г. М. 1977.
3. А. А. Роменский. Общая заболеваемость городского населения Ж. Сов. Здравоохр. 1978. № 6. 13.

А. ЛАМЖАВ, Е. НЯМЖАВ, А. СИДСВСАМБУУ

УРАЛ ЧИХЭР ӨВС ТАРИМАЛЖУУЛСАН СУДАЛГААНЫ ЗАРИМ ДҮНГЭЭС

АНАГААХ УХААНЫ ХҮРЭЭЛЭН

ЭМИЙН УРГАМАЛ БЭЛТГЭХ КОНТОР

Дэлхийд 10 гаруй зүйлийн чихэр өвс ургадгаас манай оронд урал чихэр өвс нилээд тархсан юм. Энэ өвс нь эмийн болон хүнд хөнгөн үйлдвэрийн 20 гаруй салбарт ашиглагддаг олон талын ач холбогдолтой үнэт ургамал юм.

Манай улс жилд нойтноор 60 шахам тонн чихэр өвсний үндэс бэлтгэж, гадаад дотоодын хэрэгцээг хангаж байгаа нь үндсээр бэлтгэдэг ургамлын хувьд нөөц нь амархан багадах хандлагатай байгаа учир одоогийн байгаа нөөцийг хэвийн хэмжээнд бэйлгах нөхөн сэргээх улмаар тарималжуулах ажлыг хийх шаардлага гарч байна.

БНМАУ-ын Сайд нарын Зэвлэлийн 1974 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 336 дугаар тогтоолд ховор бэхжүүлж байгаа болон улс ардын аж ахуйд олон талын ач холбогдолтой зарим эмийн ургамлыг хамгаалах, тарималжуулах шаардлагатай болохыг заасан билээ. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүлийг хамгаалах Яамны сайдын 1975 оны 406 дугаар тушаал гарч чихэр өвс тарималжуулах ажлыг эхэлсэн юм.

Манай орны чихэр өвсний тархалт, түүний нөөц хими биологийн талаар олон эрдэмтэд судалж байсан боловч чихэр өвс тарих талаар судалгаа хийсэнгүй.

Бид чихэр өвсийг үндэсний хэсгээр тарих хугацаа гүний асуудлыг шийдвэрлэх ажлыг гол болгов. Ийгээнээр чихэр өвс тарих агротехникийн зарим гсуудал шийдвэрлэгдэж, цаашид хийх агротехникийн асуудлыг нарийвчлан судлах үндэс суурь тавигдаж нэг га-аас авах ургацын хэмжээг урьдчилан тогтоох, чихэр өвсний нөөцийг хамгаалах боломж бүрдэх юм.

СУДАЛГААНЫ АРГА. Чихэр өвсийг үндэсний хэсгээр тарихдаа хажуугийн үндэсний хамгийн олон нахиатай хэсгийг 15-20 см урттайгаар тайрч тарих материал болгон ашиглан нэг га талбайд 40 000 ширхэг буюу 600 кг үндэсний хэсэг орохоор тооцолон суулгав.

Үндэсний хэсгээр тарих ашигтай гүнийг тогтоох туршлагыг 10-13 см, 13-17 см, 17-20 см гэсэн гурван янзын гүнд тарих ашигтай хугацааг тогтоох туршлагыг хавар, намар, зун гэсэн 3 янзын хугацааг тус тус сонгон авав.

Хөрс боловсруулалтын зарим аргыг илрүүлэх нэг га талбайд орох үндэсний нормыг тогтоох зэрэг асуудлыг юуны өмнө шийдвэрлэх зорилт тавиж ажиллав.

1976—1980 он хуртэлх хугацаанд 20 га талбайд чихэр өвсийг үндэсний хэсгээр тарималжуулав.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ. а) Туршлагын талбай нь газрын гадаргын хувьд голын гульдрал олонтой учир хотгор түдгэр ихтэй. Өвөл хүйтэн зун халуун эрс тэс уур амьсгалтай. Жилд дунджаар 100 мм тундас унадаг (сүүлийн 3 жилийн судалгаагаар). Хавар шуурга ихтэй, намар бага зэрэг шуурна.

б) Туршлагын талбайн хөрс. Туршлагын талбайн хөрс нь татмын нүүгүүн бага зэргийн мараалаг элсэнцэр цайвар хөрснөөс тогтсон байдаг. Хөрсний ялзмагт үе нь 0-30 см зузаан давхрагад байна. Хөрсний ялзмагийн хэмжээг тодорхойлоход 0-15 см гүнд 0,26-0,33%, 15-30 см

гүнд 0,25% байв. 30 см-ээс доош ялзмаг байхгүй. Хөрсний рН-г тодорхойлоход 0-15 см гүнд, 7,5%, 15-30 см гүнд 8%.

Үүнээс үндэслэн хөрс боловсруулалтыг 22-24 см гүнд хийх нь ашигтай байгаа нь тогтоогдов. Чихэр өвс тарих атар хөрсийг урд жилийн хавар ДТ-75 тракторт ДН-35 анжис зүүж борной бултай агрегатлан 22-24 см гүнд хагалж элдэншүүлэн уриншлав.

в) Тарих үндсийг бэлтгэсэн арга. Бид тарих үндсийг бэлтгэх дээ чихэр өвсний гол үндэс буюу хажуугийн үндэсний салааны хамгийн олон нахиатай хэсгийг 15-20 см урттайгаар тайрч бэлтгэв. Бэлтгэсэн үндсийг тарих хугацаа хүртэл чийгтэй элсэнд дарж хадгалав. Тарихын өмнө үндсийг элснээс гаргаж дахин тоолж, гэмтсэн хэсгийг ялган жигнэж зуун ширхгээр нь боож тарихад бэлэн болгов.

г) Чихэр өвсийг үндэсний хэсгээр тарьсан арга. Бид чихэр өвсийг үндэсний хэсгээр тарималжуулахдаа батлагдсан арга зүйн дагуу нэг га-д 40 000 ширхэг үндэсний хэсэг буюу 600 кг орохоор тооцоолон 50x50 см тэжээлийн талбайтайгаар зохих хувилбаруудад анжисны шангийн ховилыг ашиглан гар ажиллагаагаар үндсийг суулгаж тарьсны дараа чийг хаах хөрс нягтрүулах булдалт хийв.

УРГАМЛЫН ҮЗЭГДЭЛ ЗҮЙН АЖИГЛАЛТ. Хувилбар бүрээс сонгож авсан 100 ширхэг ургамал дээр жил бүр вегетациын хугацаанд ажиглалт, хэмжилт, судалгаа хийв. Үндэсний хэсгээр тарьсан чихэр өвс нь анхны жил тарьснаас хойш 30 гаруй хоногийн дараа буюу 6 дугаар сарын сүүлийн долоон хоногоос эхлэн цухуйж, 7 дугаар сарын 2 дугаар долоо хоногт жигдэрч, ургах хугацаа нь 10 дугаар сарын эхний 10 хоног хүртэл үргэлжиж байна. Хоёр дахь жилээсээ эхлэн зэрлэгээр ургаж байгаа чихэр өвстэй адилхан хугацаанд хөгжлийн үе шатыг дамжиж байна. Тарьсан хугацаанаас хамаарч эхний хсёржил иш навчны хөгжилт нь ялгаатай байв. Үндэсний хэсгээр тарималжуулсан чихэр өвс нь хоёр дахь жилээсээ эхлэн цэцэглэн үрийн ургац өгч байна. Тарималжуулсан чихэр өвсний газрын дээрх хэсгийн сарын дундаж өсөлт нь 5 дугаар сард 8 см, 6 дугаар сард 35 см, 7 дугаар сард 44 см, 8 дугаар сард 45 см өндөр болж, 9 дүгээр сард хагдарна. 6 дугаар сард буйдуйлж, 7 дугаар сард цэцэглэж, 8 дугаар сард үрлэж байна. Чихэр өвсний газрын дээрх хэсгийн хоногийн дундаж өсөлтийг гаргавал 5 дугаар сард 3 см, 6 дугаар сард 11 см, 7 дугаар сард 8 см, 8 дугаар сард 2 см тус тус өсөж байна.

ЧИХЭР ӨВСИЙГ ҮНДЭСНИЙ ХЭСГЭЭР ТАРИХ АШИГТАЙ ХУГАЦААГ ТОГТООХ ТУРШЛАГА. Бид чихэр өвсийг үндэсний хэсгээр тарималжуулах ашигтай хугацааг тогтоох туршлага хийхдээ хавар 5 дугаар сарын 10-25, зун 7 дугаар сарын 10-25, намар 9 дүгээр сарын 10-25 гэсэн гурван янзын хугацаанд суулгав.

Xүснэгт 1

(Ургац га/ц.)

| тарьсан он тарьсан хугацаа | 1977 | 1978 | 1979 | Нийлбэр | Дундаж |
|-------------------------------|------|------|------|---------|--------|
| Хавар | 21,8 | 18,1 | 14 | 53,9 | 18 |
| Намар | 20,2 | 17,4 | 13,2 | 50,8 | 16,9 |
| Зун | 10 | 8 | 6 | 24 | 8 |

Нэг га-д байгаа үндэсний ургацыг тооцохдоо монолит авах ар-таар нэг га-аас 12 дээж авч авсан дээжнүүдийн дундаж жинг гарган “Га-н ургацыг цт шилжүүлэн илэрхийлэв. Судалгаанаас үзэхэд хавар тарьсан га-н ургац нь намрынхаас 1,1 ц-р, зун тарьснаас 10 ц-р илүү байна. Намар тарьсан талбайн ургац нь зун тарьсан талбайн ургацаас 8,9 ц-р илүү, хавар тарьсан талбайнхаас 1, 1 ц-р бага. Зун тарьсан талбайн ургац нь хавар тарьсан талбайнхаас 10 ц-р намар тарьснаас 8,9 ц-р бага байгаагаас үзэхэд чихэр өвсийг үндэсний хэс-гээр тарихад хавар намрын улиралд тарих нь гшигтай болох нь илэрч байна.

ЧИХЭР ӨВСИЙГ ТАРИХ АШИГТАЙ ГҮНИЙГ ТОГТООХ ТУРШЛАГА

Бид чихэр өвсийг үндэсний хэсгээр тарих ашигтай гүнийг тогтоох туршлагыг 10-13 см, 13-17 см, 17-20 см гэсэн 3 янзын гүнд хийж судалгааг явуулав.

Хүснэгт 2

(Ургац га/ц)

| Тарьсан он тарьсан гүн см, | 1977 | 1978 | 1979 | Нийлбэр | Дундаж |
|-------------------------------|------|------|------|---------|--------|
| 10-13 | 21,8 | 8 | 13,2 | 43 | 14,3 |
| 13-17 | 10 | 17,4 | 14 | 41,5 | 13,8 |
| 17-20 | 20,8 | 18,1 | 6 | 44,9 | 14,3 |

Хүснэгтээс үзэхэд чихэр өвсийг үндэсний хэсгээр 10-13 см, 13-17 см, 17-20 см гүнд тарьсан чихэр өвсний үндэсний өсөлт ургацанд ялгаа гараагүй учир эдгээрийн аль ч гүнд тарих боломжтой нь илрэв.

Хүснэгт 3

Үндэсний хэсгээр тарьсан чихэр өвсний буурцагны ургац (га/ц.)

| Тарьсан он тарьсан хугацаа | 1977 | 1978 | 1979 | Нийлбэр | Дундаж |
|-------------------------------|------|------|------|---------|--------|
| Хавар | 1,3 | 1,0 | 0,8 | 3,1 | 1,0 |
| Намар | 1,1 | 0,3 | 0,6 | 2,5 | 0,8 |
| Зун | 0,3 | 0,2 | 0,5 | 0,5 | 0,2 |

Судалгаанаас үзэхэд тарималжуулсан чихэр өвсний буурцагны ургац нь тарьсан хугацаатай шууд хамааралтай байна.

Хавар тарьсан урал чихэр өвсний буурцагны ургац нь намар тарьснаас 0,2 ц, зун тарьснаас 0,8 ц-ээр тус бүр их байгаа нь харагдаж байна.

ДҮГНЭЛТ. 1. Судалгааны ажлын үр дүнд, чихэр өвсийг үндэсний хэсгээр тарихдаа 1м² талбайд 4 ширхэг үндэсний хэсгийг буюу 50x50 см тэжээлийн талбайтайгаар суулгах ашигтайг нотлов.

2. Урал чихэр өвсний үндэсний хэсгийг хавар 4 дүгээр сарын 15-30-ны хооронд, намар 10 дугаар сарын 1-ээс 15-ны хооронд 10-13 см, 13-17, см, 17-20 см гүнүүдэд суулгах нь тохиромжтой байна.

НЕКОТОРЫЕ РЕЗУЛЬТАТЫ ИЗУЧЕНИЯ КУЛЬТИВИРОВАНИЯ СОЛОДКИ

Б. Нямжав, А. Ламжав, А. Ойдовсамбу

В результате исследований сделан вывод, что самым эффективным условием культивирования солодки является посадка черенков в горизонтальном положении в количестве четырех черенков на $50 \times 50 \text{ см}^2$ плошади, во второй половине апреля или в первой половине октября на глубину 10-13 см, 13-17 см, или 17-20 см.

Б. ДОРЖГОТОВ

ГОЛ БАЙРЛАЛЫН ӨМӨН ҮҮСЭХЭД НӨЛӨӨЛӨХ ҮНДСЭН ХҮЧИН ЗҮЙЛҮҮД

АНАГААХ УХААНЫ ХҮРЭЭЛЭН

Манай оронд зонхилдог гол 5 байрлалын өмөнгийн „ходоодны өмөн — 26,91%, элэгний анхдагч өмөн 21,51%, улаан хоолойн өмөн — 13,56%, ушгыны өмөн — 12,34%, умайн хүзүүний өмөн — 10,32%“ үүсэхэд нөлөөлдөг үндсэн хүчин зүйлүүдийг илрүүлэх судалгааны анхны оролдлого хийлээ.

СУДАЛГААНЫ АРГА, МАТЕРИАЛ. Улаан хоолой, ходоод, элэг, ушги, умайн хүзүүний өмөн үүсэхэд нөлөөлж болох хүчин зүйлүүдийг илрүүлэх зорилгоор хавдар судлал-эпидемиологийн судалгааны тусгай карт боловсруулав. Карт тус бүрд 100—300 хүртэл асуулт багтаан кликкээс гадна, эд эс судлал, дуран рентген гэрлийн шинжилгээний аргуудаар онош нь батлагдсан өвчтөнд хөтөлсөн болно. Мөн ийм картыг нас, хүйс, яс, үндэс, оршин суух газраар нь өвчтөнд тохируулан зориуд сонгож авсан эрүүл жиших группийн хүмүүст хөтлөв. Жиших группийн ажиглалтын тоо үндсэн группийн тооноос 2 дахин илүү байв.

Энэ судалгааны ажлыг гүйцэтгэхдээ улаан хоолой, ходоод, элэг, ушги, умайн хүзүүний өмөн бүхий 1263 өвчтөн, жиших группийн 2545 эрүүл хүмүүст хөтөлсөн хавдар судлал-эпидемиологийн картанд статистикийн боловсруулалт хийв. Жиших группийн картыг манай орны газар зүйн янз бурийн районд явуулсан хавдар судлалын урьдчилан сэргийлэх үзлэгийн үеэр хөтөлсөн юм.

Судалгааны дун. Эх газрын эрс тэс цаг уур, хуурай уур амьстгалтай манай оронд амьдрал суудаг бүх ястнууд халуун цайг дангаар нь, эсвэл давс, хийцтэйгээр их хэмжээгээр уудаг эртний уламжлалт заншил одоо хүртэл ургэлжилсээр байна.

Хүснэгт 1

Гол 5 байрлалын өмөн бүхий өвчтөн ба жиших группийн
эрүүл хүмүүсийн тоо

| Өмнөгийн байрлал | Өвчтэй | Жиших эрүүл хүмүүс |
|------------------|--------|--------------------|
| Улаан хоолой | 373 | 746 |
| Ходоод | 350 | 700 |
| Элзг | 165 | 349 |
| Уушги | 175 | 350 |
| Умайн хүзүү | 200 | 400 |

Манай судалгаагаар давс хийцтэй цайг ихээр уудаг хүмүүсийн тоо өвчтөнд эрүүлээсээ их байна.

Хүснэгт 2

Давс, хийцтэй халуун цай уудаг
байдал (%)

| Цайны хэмжээ байдал | Улаан хоолойн өмөн бүхий өвчтөн | | | Жиших групп | | |
|--|------------------------------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|
| | эр | эм | бүгд | эр | эм | бүгд |
| Өдөрт 11 гяга буюу 2 литрээс дээш халуун цай уудаг | 50,22 ±3,33 | 57,43 ±4,06 | 53,08 ±2,58 | 28,0 ±2,11 | 30,74 ±2,68 | 29,08 ±1,66 |
| Давстай, хийцтэй цай уудаг | 76,0 ±2,84 | 81,08 ±3,22 | 78,01 ±2,14 | 65,10 ±2,24 | 55,06 ±2,89 | 61,12 ±1,78 |

Хүснэгт 2-оос үзэхэд өдөрт 2 литрээс дээш халуун цай уудаг хүмүүс улаан хоолойн өмөн бүхий өвчтөнд жиших группээс 24,0 %-иар (эрэгтэйчүүдэд 22,22%, эмэгтэйчүүдэд 26,69%) их байгаа бөгөөд эрэгтэй, эмэгтэйн ялгаа бага байна.

Давс, хийцтэй халуун цай уудаг хүмүүс өвчтөнд жиших группээс 16,88%-иар (эрэгтэйчүүдэд 10,9%, эмэгтэйчүүдэд 26,02%) их ба эрэгтэй эмэгтэйн ялгаа 15,12% байна.

Манай материалд статистикийн анализ хийхэд улаан хоолойн өмөн ба халуун, давстай, хийцтэй цайны утга холбогдлын түвшин $R_{xy}=0,61$ байгаа нь халуун ба давс, хийцтэй цай улаан хоолойн өмөн үүсэхэд нөлөөлөх нь тохиолдлын чанартай бишийг харуулж байна.

Хэвлэлийн тоймоос үзэхэд хэт халуун цай их хэмжээгээр уух заншил улаан хоолойн өмнөгийн өвчлөл нэмэгдэхэд нөлөөлдөг тухай олон мэдээ баримтууд байдаг боловч давс, хийцтэй цайны тухай бичигдсэн зүйл байхгүй байна. Цайны давс, хийц нь цайг өтгөрүүлж халуунаа барих хугацааг уртасгаснаар улаан хоолойн салст бурхэвчид үзүүлэх илчийн нөлөөг нэмэгдүүлж, архаг түлэгдэл үрэвслийн процессыг түнзгийрүүлж болох юм. Иймээс давс, хийцтэй цай уудаг заншил, улаан хоолойн өмөн үүсэхэд нэмэгдэл хүчин зүйл болон нөлөөлдөг байж болохыг үгүйсгэж болохгүй байна.

Хатуу бүхэл хоолыг муу зажилж залгих заншил улаан хоолойн өмөн үүсэхэд нөлөөлж болох тухай хэвлэлд ховор бичигдэж байгаа боловч бидний судалгаагаар энэ заншил улаан хоолойн өмөн бүхий өвчтөнд жиших группээс нийлээд илүү байна. Үүний утга холбогдлын түвшин $P<0,001$, $t>3$ байна.

Хатуу бүхэл зүйлийг муюу зажилж залгих заншил (%)

| | Улаан хоолойн өмөн | | | Жиших групп | | |
|--|--------------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|
| | эрэгтэй | эмэгтэй | бүгд | эрэгтэй | эмэгтэй | бүгд |
| Хатуу бүхэл зүйлийг муюу зажилж залгидаг | 57,77 ±3,29 | 54,05 ±4,09 | 56,30 ±2,57 | 29,11 ±2,14 | 29,05 ±2,64 | 29,08 ±1,66 |

Хүснэгт 3-аас үзэхэд хатуу бүхэл хоолыг муюу зажилж залгих заншил өвчтөнд жиших группээс 27,22% илүү байгаа нь цаашдын судалгаанд анхаарал татах зүйл мөн.

Улаан хоолойн өмөнгийн үүсэхэд нөлөөлдөг хүчин зүйлүүдийн судалгаанд хооллолтын байдал, дэглэмийн онцлогийг илрүүлэх нь сонирхолтой юм.

Мөн газарт сууж (сандал дээр суулгүй) хоолдоход хэвллийн хөндийн даралтыг нэмэгдүүлснээр ходоодны шүүсээр баялаг хоолоор дүүрсэн, ходоодны доторхи даралтыг нэмэгдүүлж ходоодны хүчил бүхий иsgэлэн хоол улаан хосолойд эргэж орох боломжийг улам ихэсгэнэ.

Манай оронд гол төлөв махан хоолыг оройн цагаар газарт сууж иддэг заншил өргөн тархсан бөгөөд улаан хоолойн өмөн бүхий өвчтөнүүдэд унтахаасаа өмнө хооллох заншил жиших группээс З дахин илүү ($P<0,001$, $t>3$) байна. Газарт сууж хооллох заншил улаан хоолойн өмөн бүхий өвчтөнд жиших группээс 2 хүйсэнд адил 10,0% илүү ($P<0,01$, $t>3$) байв.

Манай нөхцөлд ходоодны өмөн үүсэхэд голчлон нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг хүснэгт 4-т харууллаа.

Ходоодны өмөн үүсэхэд голчлон нөлөөлж байгаа хүчин зүйлүүд (%)

| Ходоодны өмөн үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлүүд | Ходоодны өмөн бүхий өвчтөн | Жиших групп |
|--|----------------------------|-------------|
| Орой хэт цадталаа иддэг | 92,57±1,40 | 77,28±1,58 |
| Голчлон мах иддэг | 88,77±1,68 | 77,42±1,58 |
| Өдөрт литрээс илүү халуун цай уудаг | 70,28±2,44 | 31,14±1,75 |
| Хэт халуун хоол иддэг | 18,57±2,08 | 8,71±1,13 |
| Яаруу иддэг | 33,42±2,52 | 17,71±1,44 |
| Бэлэн хоол хэрэглэдэг | 14,85±1,90 | 10,85±1,17 |
| Өтгөн цай уудаг | 58,57±2,63 | 51,28±1,89 |
| Тамхи татдаг | 61,71±2,60 | 48,14±1,89 |
| 20 нас хүртлээ тамхи татсан | 31,42±2,48 | 17,14±1,42 |
| Архи тогтмол уудаг | 26,23±2,35 | 9,28±1,09 |
| Архи хааяа уудаг | 35,14±2,55 | 26,57±1,67 |

Хүснэгт 4-өөс үзэхэд ходоодны өмөн үүсэхэд нөлөөлж болох хүчин зүйлүүдээс махан хоолыг орой унтахын өмнө хэт цадталаа идэх, халуун цайг их хэмжээгээр уух заншил өвчтөн ба жиших группэд бусдаасаа илүү байна. Орой унтахын өмнө хэт цадталаа идэх заншил өвчтөнд эрүүлээсээ 15,29% их, гол төлөв махан хоол хэрэглэх заншил өвчтөнд 11,15% илүү ба их хэмжээний халуун цай уудаг хүмүүс өвчтөнд эрүүлээсээ 39,14% илүү байлаа. Эдгээр хүчин зүйлүүдэд статистикийн ана-

лиз хийхэд ходоодны өмөн ба дурдсан хүчин зүйлүүдийн хоорондын холбооны утга холбогдлын түвшин $P < 0,001$, $t > 3$ байгаа нь уг хүчин зүйлүүд ходоодны өмөн үүсгэх олон хүчин зүйлүүдийн дотор нилээд чухал үүрэгтэйг харуулж байна.

Оройн цагаар махан хоолыг хэт цадталаа идэх нь ходоодны булчирхайд хэт ачаалал өгч аажмаар ходоодны хатангирт үрэвсэл үүсэх боломж бурддүүлнэ. Хэт цадталаа хооллох нь халуун цайг их хэмжээгээр уух заншилтай хавсрал ходоодыг байнгын суналтын байдалд оруулж бас түүнд халуун илчийн нөлөө үзүүлнэ. Дурдсан хүчин зүйлүүд, ходоодонд механик, илчийн нөлөө үзүүлэхээс гадна үйл ажиллагааны хэт ачаалал бий болгож ходоодны хэвийн ажиллагаа алдагдан архаг үрэвсэл зэрэг өмөнгийн урьдал байдалд хүргэнэ.

Эдгээрээс гадна хоолыг яаруу идэх (өвчтөнд 33,42%, жиших группэд 17,71%, $P < 0,001$, $t > 3$), хэт халуун хоол идэх заншил (18,57%, жиших группэд 8,71%) ходоодны өмөн бүхий өвчтөнд жиших группээс нилээд давуу байгаа нь ходоодны өмөн үүсэхэд нөлөөлж болох, цаашдаа анхаарвал зохих хүчин зүйлүүд мөн.

Манай судалгаагаар ходоодны өмөн бүхий өвчтөний дунд тамхичин хүмүүс 61,71% байхад жиших группэд 48,14% байсан ба 20-иос доош насандaa тамхи татагсад өвчтөнд 31,42%, жиших группэд 17,14% байлаа.

Тогтмол архи уугчид өвчтөнд 26,28%, жиших группэд 9,28%, хааяа архи уугчид өвчтөнд 35,14%, жиших группэд 26,57% ажиглагдаж байна.

Мөн бүх өвчтөний 40,57%-д ходоодны архаг үрэвсэл, 1,43%-д шархлаа өвчин байв.

Бүх өвчтөний 42,28%-д ходоодны амсрын өмөн, 27,43%-д ходоодны гарах хэсгийнх, 8,57%-д бага махианых, 1,14%-д их махианых, 0,8%-д урд ба ар ханынх, 0,57%-д ходоодны ёроолынх байсан ба 10,29%-д ходоодыг бүхэлд нь хамарсан өмөн, 8,86%-д байрлал заагдаагүй байна.

Бидний эпидемиологийн судалгааны карт хөтөлсөн, элэгний анхдагч өмөн бүхий 165 өвчтөний 85 ($51,51\% \pm 3,89$) нь халдварт гепатитаар өвчилсөн хүмүүс байсан бол эрүүл 349 хүний 47 ($13,7\% \pm 1,83$) нь уг өвчнөөр өвчилсөн байв.

Элэгний анхдагч өмөн үүсэхэд, халдварт гепатитын нөлөөлөх нөлөөний хэмжээ нь уг өвчнөөр зөвхөн өвчилсөн төдийгүй өвчилсөн тоо, хугацаанаас ихээхэн шалтгаалдаг байна.

Хүснэгт 5

Элэгний анхдагч өмөн бүхий өвчтөн ба эрүүл хүмүүсийн халдварт гепатитаар өвчилсөн тоо

| Өвчилсөн тоо | Өвчтөн | Жиших групп |
|-----------------|-----------------------|-------------------------|
| 1 удаа өвчилсөн | 69/81, 18% $\pm 4,24$ | 46 (97,87% $\pm 2,10$) |
| 2 — “ — — ” | 9/10, 59% $\pm 3,34$ | — |
| 3 — “ — — ” | 2/2, 35% $\pm 1,64$ | — |
| 4 — “ — — ” | 2/2, 35% $\pm 1,64$ | 1 (2,13% $\pm 2,10$) |
| 5 — “ — — ” | 1/1, 18% $\pm 1,17$ | — |
| 6 — “ — — ” | 2/2, 35% $\pm 1,64$ | — |
| Бүгд | 85 (100,0%) | 47 (100,0%) |

Хүснэгт 5-аас үзэхэд халдварт гепатитаар өвчилсөн элэгний анхдагч өмөн бүхий өвчтөний 18,82% нь уг өвчнөөр 2 ба түүнээс дээш удаа өвчилсөн байхад жиших группийн дөнгөж 2,13% нь 2 ба түүнээс дээш удаа өвчилжээ.

Элэгний анхдагч өмөн бүхий өвчтөн ба жиших эрүүл хүмүүсийн халдварт гепатитаар өвчилснөөс хойшхи хугацаа

| Халдварт гепатитаар өвчилснөөс хойшхи хугацаа | Элэгний анхдагч өмөн бүхий өвчтөн | Жиших эрүүл хүмүүс |
|---|---|--|
| 3—5 жил | 3 ($3,58 \pm 2,0$) | 7 ($14,89\% \pm 5,19$) |
| 6—10 жил | 8 ($9,41\% \pm 3,17$) | 9 ($9,15\% \pm 5,74$) |
| 11—15 жил | 16 ($18,82\% \pm 4,24$) | 8 ($17,02\% \pm 5,4$) |
| 16 ба дээш жил | 47 ($55,30\% \pm 5,39$) | 18 ($38,30\% \pm 7,09$) |
| Хугацаа заагаагүй Бүгд | 11 ($12,94\% \pm 3,64$) 85 ($109,0\%$) | 5 ($10,64\% \pm 4,50$) 47 ($100,0\%$) |

Хүснэгт 6-аас үзэхэд элэгний анхдагч өмөн бүхий өвчтөний 12,94% нь халдварт гепатитаар өвчилснөөс хойш 10 хүртэл жил өнгөрсөн бол жиших группэд 34,0.% байна. Халдварт гепатитаар өвчлөөд 10-аас дээш жил болгосод өвчтөнд 74,12%, жиших группэд 55,32% байна.

Бидний судалгаагаар халдварт гепатитаар өвчилсөн тоо, хугацаа (ялангуяа 10-аас дээш жил болсон) ба элэгний анхдагч өмөнгийн хооронд корреляцын ондёр хамаарал ($Rxy=0,96$) илэрч байгаа нь манай нөхцөлд элэгний анхдагч өмөн үүсэхэд нөлөөлдөг олон тооны хүчин зүйлүүдийн дотор халдварт гепатитын урхаг улдэгдэл элэгний архаг өвчинүүд ихээхэн үүрэгтэйг харуулж байна.

Манай материалыар элэгний анхдагч өмөн бүхий өвчтөний 56,36% нь архи тогтмол уудаг хүмүүс байсан ба жиших эрүүл хүмүүст энэ үзүүлэлт 41,83% байлаа. Үүний зэрэгцээгээр урьд нь халдварт гепатит өвчинөөр өвчилсөн элэгний анхдагч өмөн бүхий өвчтөний 62,35% нь архи уудаг хүмүүс байсан бол жиших группэд энэ үзүүлэлт 3,72% байгаа нь халдварт гепатит ба архи хөгжсөн тухай хэвлэлийн мэдээ баримтууд олон байдаа.

Хоол боловсруулах эрхтэний архаг өвчинүүд, зарим халдварт ба шимэгч хорхойн өвчинүүд элэгэнд эмгэг процессыг үүсгэж өмөн үүсэхэд аятай нөхцөлийг бүрдүүлдэг тухай хэвлэлийн мэдээ баримтууд олон байдаа.

Элэгний анхдагч өмөн бүхий 147 өвчтөнд задлан шинжилгээ хийсэн манай материалыд судалгаа хийхэд элэгний өмөн сорвижлын хамт 55,11%—4,10 (81)-д байсан ба үүнээс 34,57—5,28 (28) нь урьд халдварт гепатитаар өвчилсөн байлаа.

Элэгний анхдагч өмөн бүхий өвчтөний 55,76%—3,86 нь халдварт гепатитаас бусад архаг ба халдварт өвчинөөр өвчилсөн хүмүүс байв. Энэ үзүүлэлт жиших группэд дөнгөж 11,19%—0,57 байлаа.


Урьд нь халдварт гепатитаар өвчилсөн хүмүүс дурдсан өвчинөөр өвчлөгчдийн дотор нилээд их байгаа нь эдгээр өвчинүүд халдварт гепатитын хамт элэгний эд, эсэд хортойгоор нөлөөлж элэгний өмөн үүсэх урьдчилсан аятай нөхцөлийг бүрдүүлдэг болохыг харуулж байна.

Манай судалгаанд хамрагдсан элэгний анхдагч өмөн бүхий өвчтөний 61,71% \pm 7,7 нь, жиших эрүүл хүмүүсийн 40,5% \pm 3,7 нь хоолонд хүнсний ногоо хэрэглэдэггүй буюу бага хэрэглэдэг хүмүүс байв. Урьд нь халдварт гепатитаар өвчилсөн ба өвчлөөгүй элэгний анхдагч өмөн бүхий өвчтөнийг харьцуулахад идэшний ногоо хэрэглэдэггүй хүмүүс урьд нь халдварт гепатитаар (13,7%) илүү өвчилсөн байна. Энэ нь нүурс ус, витаминаар баялаг идэшний ногоо хэрэглэхгүй, гол төлөв өөх, тос ихтэй махран хоол хэрэглэх нь халдварт гепатит өвчиний эдгэрэлтийн алсын

ҮР дунд муугаар нөлөөлж, улмаар уг өвчин архагшиж, үүнд суурилан өмөн үүсэх аятай нөхцөл бүрддэг болохыг харуулж байна.

Уушгины өмөнгөөр тамхичин хүмүүс илүү өвчилдөг болох нь статистикийн баялаг материалд тулгуурлан хийсэн олон тооны судалгаагаар батлагдсан асуудал юм.

Зураг 2



Уушгины өмөн бүхий өвчтэн ба жишиг группийн тамхи татдаг байдал (%)

Бидний материалыар одоо тамхи үргэлжлэн татаж байгаа хүмүүс уушгины өмөн бүхий өвчтөний дунд жишиг группээс 31,6% илүү байна.

Уушгины өмөн бүхийн өвчтөнд тамхичин хүмүүсийн эзлэх хувийн жинж ишшиг группээс ихээхэн илүү байгаагийн зэрэгцээгээр уг өвчин үүсэхэд татах тамхины хэмжээ, тамхи татсан хугацаа ихээхэн үүрэгтэй байна.

Бидний судалгаагаар 20-иос доош насандaa тамхи татагсад уушгины өмөнтэй өвчтөнд жишиг группээс 11,07% илүү ба 25-аас дээш насандaa тамхи татагсад жишиг группэд өвчтөнөөс 13,80% илүү байв. Мөн уушгины өмөнтэй тамхичин хүмүүсийн $33,59 \pm 4,13$ нь, жишиг группийн $19,13\% \pm 3,09$ нь өдөрт 20-иос дээш удаа тамхи татдаг хүмүүс байсан бөгөөд статистикийн үнэн магадлал $Rxy=0,97$, $P<0,001$, $t>3$ байгаа нь уушгины өмөн үүсэхэд нөлөөлдөг гол хүчин зүйлүүдийн нэг нь тамхи болохыг харуулж байна.

Манай судалгаанд хамрагдсан уушгины өмөн бүхий өвчтөний 9 нь (5,14%) сурьеэ, 23 нь (13,14%) тоосжилт, 51 нь (29,14%) хатгалaa өвчнөөр өвчилсөн хүмүүс байсан ба жишиг группийн дөнгөж 1,43% нь дээрх өвчинүүдээр өвчилсөн байв. Энэ нь манай нөхцөлд уушгины өмөн, архаг хатгалaa өвчинд суурилан үүсэх явдал цөөнгүй байгааг харуулж байна.

Бидний судалгаагаар умайн хүзүүний өмөнгийн өндөр өвчлөлтэй Булган, Сэлэнгэ, Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Өмнөговь аймгуудад умайн хүзүүний шархлаа өвчний илрэлт, умайн хүзүүний өмөнгийн бага өвчлөлттэй Баян-Өлгий, Ховд, Завхан, Баянхонгор, Архангай аймгуудаас 6,46% илүү байгаагийн зэрэгцээгээр умайн хүзүүний шархлаа бүхий өвчтөний наасны бүрэлдэхүүн умайн хүзүүний өмөнгийн өндөр өвчлөлтэй аймгуудад бага өвчлөлтэй аймгуудаас 29 хүртэлх насанд 5,04% илүү байна.

Дурдсан тоо баримтууд нь манай нөхцөлд умайн хүзүүний шархлаа өмөн болон хувирах нь цөөнгүй байгааг харуулж байна. Иймээс умайн хүзүүний өмөнгөөс урьдчилан сэргийлэхийн тулд эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгийг тогтмол зохион явуулж, илэрсэн өвчтөнийг эрүүлжүүлэх арга хэмжээ авч байх нь чухал юм.

ДҮГНЭЛТ 1. Манай улсад улаан хоолойн өмөнгийн өвчлөл харьцангуй өндөр байгаад нөлөөлж болох олон тооны хүчин зүйлүүдээс хамгийн гол нь хэт халуун, давстай, хийцтэй цайг их хэмжээгээр уух, хатуу бүхэл зүйлийг муу зажилж залгих, орой унтахын өмнө махан хоолыг хэт цадталаа идэх заншилзууд юм. Мөн хоолыг яаруу идэх, архи уух нь ходоодны өмөн үүсэхэд нөлөөлөх нэмэгдэл хүчин зүйл болж байна. Ходоодны өмөнгийн 40,57% нь ходоодны архаг үрэвсэл, 1,43% нь шархлаа өвчинд суурилан үүсчээ.

2. Элэгний анхдагч өмөн үүсэхэд халдварт гепатит, хооллох дэглэм сахихгүй байх, нэг төрлийн хоол дагнан хэрэглэх, архи уух зэрэг хүчин зүйлүүд голчлон нөлөөлж байна.

Элэгний анхдагч өмөн, хоол боловсруулах эрхтэний янз бүрийн архаг, халдварт өвчинд суурилан үүсэх нь цөөнгүй байна.

Дээр дурдсан хүчин зүйлүүд, урьд нь халдварт гепатитаар өвчилсөн, элэгний анхдагч өмөн бүхий өвчтөнд улам тод илэрч байна. Иймээс халдварт гепатиттай өвчтөнийг бүрэн эмчилж, уг өвчинөөс урьдчилан сэргийлэх, түүгээр өвчилсний дараа хооллох дэглэмийг чанд сахих нь элэгний анхдагч өмөнгөөс урьдчилан сэргийлэх бодит аргуудын нэг мөн.

3. Ушгины өмөн ба тамхины хооронд корреляцын ондөр холбоо байгаа бөгөөд манай нөхцөлд ушгины өмөн архаг хатгалаа өвчинд суурилан үүсэх нь цөөнгүй байна.

Ушгины өмөнгийн өвчлөл, нас барагтыг бууруулахын тулд төрел бүрийн тсосжилт бүхий үйлдвэрийн газруудад хөдөлмөр хамгааллын ажлыг сайжруулах, Улаанбаатар зэрэг томсохон хотод агаарын бохирдлыг багасгах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх явдал чухлаар шаардагдаж байна.

ГЛАВНЫЕ ФАКТОРЫ СПОСОБСТВУЮЩИЕ ВОЗНИКНОВЕНИЮ РАКА ОСНОВНЫХ 5 ЛОКАЛИЗАЦИЙ В УСЛОВИЯХ МНР.

Б. Доржготов

Из многочисленных факторов относительно высокой заболеваемости раком пищевода в МНР, самыми главными являются привычки употреблять чрезмерно горячий чай, чай с солью, чай с жареной мукой, крупами, глотать грубую твердую плохо разжеванную пищу, принимать мясную пищу преимущественно в вечернее время.

Для рака желудка в условиях Монголии преобладающее место занимают в сравнении с другими, привычки переедания преимущественно мясной пищи перед сном и употребление горячего чая в большом количестве. Обращает на себя внимание и то, что в качестве возможных дополнительных факторов, способствующих возникновению рака желудка выступают торопливость в еде, злоупотребление алкоголем.

Возникновению первичного рака печени способствуют, главным образом, такие факторы как перенесённый в прошлом вирусный гепатит, нерегулярное питание, одиночный пищевой рацион и употребление алкоголя.

Среди больных раком легкого преобладают курильщики и рак легкого нередко возникает на фоне хронической пневмонии.

Возникновению рака шейки матки способствуют такие факторы, как раннее наступление менопаузы, многократное замужество, беременность в раннем возрасте, многократные роды и роды в домашних условиях. Раку шейки матки часто предшествует эрозия шейки матки.

Б. ГССШ, Ч. ПУНЦАГ

ЯСНЫ АРХАГ ҮРЭВСЛИЙГ ЭМЧЛЭХ АСУУДАЛД

АНАГААХ УХААНЫ ДЭЭД СУРГУУЛЬ

Ясны архаг үрэвсэл (остеомиелит)-ийг эмчлэх асуудал нь мэс заслын түвэгтэй, маргаантай асуудлын нэг юм. Энэ архаг үрэвсэл нь удаан хугацаагаар үргэлжилж олон дахин мэс засал хийх явдал ч цөөнгүй тохиолддог.

Хэвлэлийн мэдээнээс үзэхэд ясны архаг үрэвслийн хурц хэлбэр архагт шилжих нь их ч, хүнд хэлбэрүүд тааралдах нь олонтоо байна. [1—6] Үүний зэрэгцээ архаг үрэвслийн хүнд хэлбэр үүсч олс ясыг зэрэг гэмтээх тохиолдол 20—45%-ийг эзэлж [байна. [6—7]

Зарим эрдэмтэд архаг үрэвсэл үүсэхэд З хүчин зүйл нөлөөлж байна гэж үздэг. [1]

Нэгдүгээрт насны онцлогоос хамаарна.

Бага насны хүүхэд тухайлбал З хүртэлх насны хүүхдэд энэ өвчин архагших нь насанд хүрсэн хүүхдийнхээс цөөн, 10-аас дээш насны хүүхдэд элбэг тохиолддог байна. Учир нь 5—6 хүртэлх насны хүүхдийн чөмөг ясны гаверсов суваг болон судаснууд нь өргөн уужим байдагтай холбоотой юм. [8]

Хоёрдугаарт ямар эс үрэвссэнээс болно. Доод мөчний ясны үрэвслийн архагшил бусад ясныхаас 2 дахин их нь доод мөчний ясны цусны урсгал удаан, байнга зогсонги байдалд байдаг, үрэвслийн процесс гүйцэд шимэгддэггүйтэй холбоотой юм.

Гуравдугаарт өвчин эхэлсэнээс хойш ямар хугацаанд эмчилгээ хийгдсэнээс хамаарна.

1960 онд хурц үрэвсэлтэй 24 өвчтөнд зохих эмчилгээг эхний З хоногт нь хийсний үр дүнд зөвхөн 1 өвчтөнд уг өвчин архагшсан байна. Гэтэл өөр 21 өвчтөнд эмчилгээг өвчин эхэлсэнээс хойш З хоногийн дээш хугацаа өнгөрсний дараа хийсэн учир 12 хүнд өвчин нь архагшжээ. [8] Бидний ажиглалтаар дээрх З төрлийн хүчин шалтгаанаас гадна дөрөв дэх шалтгаан байж болох төлөв байна.

Манай орны нөхцөлд ч гэсэн ясны үрэвсэл архаг хэлбэрт шилжих хувь өндөр, түүний хүнд хэлбэрүүд цөөнгүй байгаа нь бидний практик үйл ажиллагаанд тохиолдож байна. Энэ нь ясны үрэвсэл өвчиний хурц архаг хэлбэрүүдийг эмчлэх иж бүрэн аргуудыг эмч бүр харилцан адилгүй хэрэглэж байгаатай холбоотой байж болно.

Бид улсын клиникийн төв эмнэлгийн мэс заслын тасагт 1970—1980 онд эмчилгээ хийлгэсэн ясны үрэвсэлтэй 464 өвчтөний эмчилгээнд судалгаа хийв. Эдгээр өвчтөний 301 (64,6%) нь эрэгтэй, 163 (35,4%) нь эмэгтэй бөгөөд бүх насны хүмүүс (хүүхэд, залуучууд болон настайчууд) энэ өвчнөөр өвчилж байна.

Тэгэхдээ ихэнх тохиолдолд (51,9%) 15—30 насны идэр залуучууд өвчилсөн байна. 83 өвчтөн буюу 18,9%-д нь уг өвчин 6—20 жил, түүнээс дээш хугацаагаар ургэлжлэн олон удаа давтан эмчлүүлсэн байна.

Бидний судалгаагаар 1,7 хувьд нь өвчин үүсэхдээ 2—3 ясны гэмтээж үрэвсүүлсэн байлаа. Удаан хугацаагаар өвчин үргэлжилж, олон дахин дахилт өгснөөс бүх тохиолдлын 0,2 хувь нь архаг үрэвслээс ясны хорт хавдарт шилжсэн байна. Өвчний эхний үед онош сройтож тавигдан, хийсэн эмчилгээ иж бүрэн биш, эмчилгээнд оройтон ирж байсан зэрэг нь өвчиний архагшиж, чөмөг ясны улам их хэмжээгээр гэмтээх үндсийг бүрдүүлсэн байв. Архаг үрэвслийн эмчилгээ нь иж бүрэн байх ёстой бөгөөд үндсэн арга нь мэс заслын эмчилгээ юм.

Эмчилгээ хийлгэсэн 464 өвчтөнөөс 237 (51,07%)-д мэс заслын эмчилгээ хийсний 84-д нь зөвхөн үндсэн яс авах хагалгаа хийж түүний 18-д нь буюу 21,4 хувьд нь өвчин дахисан байв. Харин үндсэн ясныг авч, ясны хөндийг булчингаар нөхөх мэс засал хийлгэсэн 54 өвчтөнөөс 1 хүнд буюу 1,8 хувьд нь өвчин дахисан байна.

Доод мөчний үрэвсэлтэй 23 өвчтөнд хэвллийн доод артерийг сэтгэж, дээд мөчний үрэвсэлтэй З өвчтөнд цээжний гадна хажуугийн артерийг сэтгэн удаан хугацаагаар антибиотик эмийг тарьж хэрэглэв. Түүнээс гадна ясны үрэвсэлтэй бараг бүх өвчтөнд стафилококкийн эсрэг дархлал үүсгэх эмчилгээг стафилококкийн анатоксин, дархалсан сийвэн хэрэглэж хийв. Өвчин нь их хүндэрч чөмөг ясны ний-

Тэд нь гэмтээнээс гадна удаан хугацаагаар өвчлүүлж, архагсепсис, амилоидоз үүсгэсэн бөгчтөнд үе мөчийг тайрах мэс засал хийсэн нь бүх тохиолдлын 1,2 хувийг эзэлж байна.

Бидний эдгээр судалгааны дүнгээс үзэхэд ясны архаг үрэвсэлтэй өвчтөнд мэс заслын хавсарсан эмчилгээ хийх нь сайн үр дүн өгч байна. Тухайлбал хагалгаагаар үйрсэн ясиг авахын зэрэгцээ түүний хөндийг сэйтар цэвэрлэх, уул хөндийг булчингаар таглах, хагалгааас хойш уул мөчний артерт гуурс тавин удаан хугацаагаар антибиотик хийх аргуудыг нэгтгэн хийж байна.

Хагалгааны үед үйрсэн ясиг авсны дараа эмгэг өөрчлөлт бүхий ясны бүх хэсгийг бүрэн цэвэрлэхийн тулд хагалгааны өмнө фистулографийн шинжилгээ хийх, ясны зургийг өсгөж авах, идээт цоорхойгоор метиленин хөхийг шахах зэргийг бид их чухалчилдаг.

К ВОПРОСУ ЛЕЧЕНИЯ ХРОНИЧЕСКОГО ГЕМАТОГЕННОГО ОСТЕОМИЕЛИТА

Б. Гош, Ч. Пунцаг

Из всех обследованных больных по поводу хронического гематогенного остеомиелита женщин было 163 (35,4%) и мужчин — 301 (64,6%) человек. Хроническим гематогенным остеомиелитом в основном страдают люди довольно молодого возраста, от 15 до 30 лет (51,9%). У 83 больных данное заболевание продолжалось в течение 6—20 лет и более, с частыми рецидивами. По нашим данным в 1,7% случаев заболевание началось с одновременным поражением 2—3 костей организма. В результате длительного заболевания и частого рецидива у одного больного на фоне хронического воспалительного процесса развилась малигнизация костной ткани в злокачественную. Самым эффективным методом лечения данного заболевания является оперативный метод с последующей мышечной пластикой костной полости и комбинацией антибактериальной терапии, сделанной внутриarterиальным длительным введением антибиотиков через специальные катетры в артерии. После такого метода лечения рецидивы занимают 1,8%. Рецидив данного заболевания после операции секвестр-эктомии без ликвидации костной полости занимает 21,4%.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Гринев М. В. "Некоторые вопросы хирургического лечения хронического остеомиелита ж." Вестник хирургии, 1966 г. № 12, стр. 67.
2. Шиш В. Ф. "О диагностике и лечении хронического гематогенного остеомиелита у детей". ж. Вестник хирургий, 1973 г. № 1. стр 135.
3. Шилов В. Н. "Классификация и лечение хронического гематогенного остеомиелита у детей". ж. Вестник хирургий, № 9, 1973 г. стр. 122.
4. Капорский И. Д., Недвецкая Л. М. и другие. "Использование иммунологических методов при лечении хронического остеомиелита". ж. Хирургия, 1978 г. № 5, стр. 48.
5. Мазурик М. Ф. "Лечение хронического остеомиелита" ж. Хирургия, 1978 г. № 5, стр. 53.
6. Султанбаев Т. Ж. "Острый гематогенный остеомиелит у детей", Алма-Ата, 1979 г.
7. Кононов В. С. "Гематогенный остеомиелит у детей" М. 1974 г.
8. Штефко В. Г. "Возрастная остеология". М. 1947 г.
9. Султанбаев Т. Ж. Ормантаев К. С. "Внутрикостные промывания при остеомиелите у детей". "Медицина", 1979 г.
10. Гринев М. В., Петров В. И. "Малигнизация язв и остеомиелитических свищей". ж. Вестник хирургии, 1968 г. № 1. стр. 142.
11. Гринев М. В. "Общий амилоидоз у больных остеомиелитом" ж. Вестник хирургии, 1968 г. № 8, стр. 77.

АЛТАЙН ХОЙЛГИЙН БУЛЧИНГИЙН ЭДЭД АГУУЛАГДАХ МАКРО БА МИКРОЭЛЕМЕНТИЙН УЛИРЛЫН ХӨДЛӨЛ ЗҮЙ

АНАГААХ УХААНЫ ХҮРЭЭЛЭН

Гэрийн тэжээвэр аливаа амьтны бие махбодод агуулагдах эрдэс бодисын хэмжээ уул амьтны төрөл зүйл, насын онцлог, идэш тэжээлийн байдал, нядлагдсан цаг улирлаас хамааран шалтгаалгийг хэвлэлд тэмдэглэжээ [1, 2]. Гэвч зэрлэг шувуунд энэ чиглэлээр шинжилгээ судалгаа хийсэн тухай мэдээлсэн гадаад дотоодын хэвлэлийн мэдээ баримт бидэнд тааралдсангүй.

Ялангуяа алтайн хойлгийн булчингийн эдэд агуулагдах макро ба микро элементийн улирлын хөдлөл зүй огтхон ч судлагдаагүй байгаа нь энэ зүйл шувууны махны биологийн шимт чанарыг бүрэн гүйцэд үнэлэх явдлыг хангатгүй болгож байна. Иймээс бид алтайн хойлгийн булчингийн эдэд агуулагдах натри, кали, фосфор, төмөр, зэс, цайр, мangan, кобальтын агуулга хэмжээ уг шувууг агнасан цаг улирлаас хэрхэн хамаардгийг тогтоох зорилгоор энэхүү шинжилгээг хийлээ.

ШИНЖИЛГЭЭНИЙ МАТЕРИАЛ БА АРГА ЗҮЙ. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тусгай зөвшөөрлийн дагуу Монгол Алтайн нурууны салбар уулсаас нийт 38 хойлог (намар ба өвлийн улиралд тус бүр 10, хавар-зуны цагаар 18) шувууг 1975—1979 онд агнаж, тэдгээрийн булчин-махнаас 182 дээжийг сонгон авав.

Шинжилгээний дээжийг биологийн зүйлст микроэлемент тодорхойлох (3) аргачлалын дагуу (105°C) хатааж, (450°C) шатааж үнсжуулэн бэлтгэлээ. Харин натри ба калийг дөлөн фотометрийн аргаар „Карл—Цейс—Иена“ аппаратаад хэмжиж, фосфор, төмөр, мangan, кобальтыг фотометрийн аргаар (3) задлан шинжилж „Спекол“ аппаратаар экстинкцийг шинжилсэн ба зэс, цайрыг колориметрийн аргаар (4) тус тус тодорхойлсон юм.

ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН. Хавар, зуны цагаар ба намар, өвлийн улиралд агнасан алтайн хойлгийн булчингийн эдэд тодорхойлогдсон макро ба микро элементийн агуулга хэмжээг статистикийн аргаар боловсруулан хатаасан дээжний нэг килограммд агуулагдах миллиграммраар илэрхийлж гарган хүснэгт 1-д үзүүлэв.

Хүснэгтээс хараад алтайн хойлгийн булчингийн эдэд агуулагдах макро, микро элемент хавар, зун, намар, өвлийн улиралд хоорондоо харилцан адилгүй хэмжээтэй байдаг нь илэрлээ. Үүнд: кали, натри, фосфор ба төмөр зэрэг макроэлементийн агуулагдах хэмжээ эдгээр улиралд ($14,3$ — $971,5$ мг/кг хүртэл), их хэлбэлзэлтэй, мangan, кобальт, зэс, цайр мэтийн микроэлементийн агуулга нь харьцангуй бага ($0,4$ — $7,4$ мг/кг) хэлбэлзэлтэй тус тус тодорхойлогдож байна. Харин хойлгийн булчингийн эдэд орших эрдэс бодисын их ба бага агуулга нь хавар зун, хавар ба өвлийн улирлын аль аль дээжид илэрч харагдav.

Янз бурийн цаг улиралд нядлагдсан хойлгийн булчингийн эдэд агуулагдах химиийн элементийн хэмжээ ийнхүү харьцангуй ижил бус

**Алтайн хойлгийн булчингийн эдэд агуулагдах
макро ба микроэлементийн улирлын хөдлөл зүй
(мг/кг)**

| Химийн элемент | Хавар-зун | Намар | Өвөл |
|----------------|--------------|--------------|--------------|
| Кали | 4974,6±950,1 | 4003,1±147,4 | 3988,8±548,4 |
| Натри | 1890,5±285,5 | 2354,9±200,2 | 2819,4±115,0 |
| Фосфор | 3212,7±213,8 | 3509,5±233,2 | 3745,4±826,3 |
| Төмөр | 286,0±24,1 | 196,1±19,8 | 80,3±11,1 |
| Зэс | 28,5±4,6 | 36,9±4,8 | 32,7±4,7 |
| Цайр | 26,1±0,2 | 23,6±0,9 | 25,0±1,1 |
| Манган | 7,1±2,9 | 11,0±0,2 | 5,7±0,9 |
| Кобальт | 1,7±0,1 | 2,1±0,4 | 1,7±0,2 |

агуулгатай байгаа нь түүний амьдралд нөлөөлөх байгаль-цаг уурын нөхцөл онцлог, амьдрах орчных нь тухайн үеийн байдал, ялангуяа идэш тэжээлийх нь хэмжээ, найрлага, бүрэлдэхүүн, шим чанартай холбоотой нь ойлгомжтой.

Амьд бие махбод бол өөрийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай химийн элементийг хүрээлэн буй орчноосоо авдаг (7) тул нэг талаас амьд бие махбод, нөгөө талаас орчны хөрс, ус, агаарын хооронд эрдэс бодисын харилцан солилцоо явагддаг (5—7). Юуны өмнө уг шувууны тэжээлийн ургамал ургах биогеохимиин ландшафт эрдэс бодисын солилцоонд гол үйлчлэл нөлөө үзүүлдэг. Бидний урьд (8) тогтоосноор алтайн хойлгийн бие махбодод орох химийн элементийн дамжлага нь хөрс-ус-агаар-хойлгийн тэжээлийн ургамал-бие махбод гэсэн биогеохимиин гинжин холбоосоор явагддаг. Иймээс ургамлаар дагнан хооллодог хойлгийн булчин-махнаа янз бурийн цаг улиралд агуулагдах эрдэс бодисын хэмжээнд түүний тэжээлийн элдэв зүйл ургамлын тухайн үеийн тодорхой найрлага чанар гол үүрэг гүйцэтгэнэ.

Хойлог нь цаг улирлын онцлогийн дагуу ургамлын төрөл бурийн бие хэсгийг идэш тэжээлдээ ашигладаг бөгөөд хавар, зуны цагаар ургамлын ногоон хэсэг тэжээлд нь зонхилон шүүсэрхэг нялх найлзуур, нахиа, навч, цэцэг, шинэ үр, ишээр хооллодог бол намар, өвөлдөө мөнхүү зундаа иддэг олонхи зүйл ургамлын хатсан үр, буурлаг, навч, үндэслэгт иш, булуу, үндсээр голчлон хооллож амьдарна. (9, 10). Ингэж хойлог нь жилийн янз бурийн цаг улиралд ургамлын төрөл бурийн хэсгийг, ургамлын хөгжлийн нь тодорхой ба хоорондоо ялгаатай үе шатанд нь, өөр өөр найрлагатай үед нь идэхдээ химийн эрдэс элементийг харилцан адилгүй хэмжээтэй шимж авахад хүрэх бөгөөд улмаар өөрийн амьдрах үйл ажиллагаа, биохимийн болон физиологийн процессын цаг улирлын онцлотойгоо тохируулж бие махбод, эд эрхтэндээ тэдгээр элементийг хуваарилан тараах нь лавтай.

Хойлгийн булчингийн эдэд агуулагдах макро ба микроэлементийн улирлын хөдлөл зүйг өрөнхийд нь авч үзвэл, кали ба төмрийн агуулга хавар, зуны ($4974,6\pm950,1$ мг/кг ба $286,0\pm24,1$ мг/кг) үеийнхээсээ өвлийн улиралд ($3988,8\pm548,4$ мг/кг ба $80,3\pm11,1$ мг/кг хүртэл) ба гасах. фосфор ба натри харин эсрэг буюу дулааны цаг ($3212,7\pm213,8$

мг/кг, $1890,5 \pm 285,5$ мг/кг) үеийнхээсээ хүйтний эрч чангараах улиралд ($3745,4 \pm 826,3$ мг/кг ба $2819,4 \pm 115,0$ мг/кг болтлоо) ихсэх хандлагатай байна.

Эдгээр өөрчлөлт хувиралт нь нэг талаар янз бурийн цаг улиралд няллагдсан хойлог шувуу ба түүний булчин-махны өсөлт хөгжилт, физик-химийн шинж байдал, бие маҳбодод нь явагдах биохимиин урвал, бодисын солилцооны өөр өөр үе шатанд байсантай, нөгөө талаар хойлгийн тэжээлийн ургамлын найрлагад орох химийн элемент тус бурийн нөөц хэмжээ, үүрэг, ач холбогдолтой уялдаатай юм. Тухайлбал, хавар, зуны цагаар, эл шувууны үүрлэж өндөглөх ба үр төл нь үржиж хөгжих ид үеэр фосфор нь өндөгний хальсны найрлагад орох ба залуу шувууны ясанд хуримтлагдах тул булчингийн эдэд багаар илрэх боломжтой юм.

Гэтэл намар өвлийн улиралд хойлог фосфороор эрс баялаг үр буурцаг (11) тэжээлдээ давамгай хэрэглэдэгтэй шууд зохицон булчин маханд нь энэ элемент ихээр тодорхойлогдож байна.

Үүний нэг адил, хойлгийн булчингийн эдэд агуулагдах төмрийн хэмжээ уул шувууны тэжээлийн ургамлын өсөлт хөгжилтийн физиологийн үе шаттай уялдаатай байж болох талтай. Ургамлын газар дээрх ногоон хэсэг-навч, найлзуур, нахиа ба буурцагт ургамал, үрийн хальсанд төмөр мэш элбэг (11) байх тул хавар, зуны ба намрын улиралд ургамлын тэдгээр бие хэсгийг идэш тэжээлдээ өргөн хэрэглэх боломжтой хойлгийн булчингийн эдэд өвлийнхөөс илүү их хэмжээний төмөр илрэв.

Кали ба натри нь бие биенийн эсрэг үйлчлэл олонтоос үзүүлдэг элементүүд учир кали булчинийн эдэд ихээр илэрч байгаа үед натрын бага, аль эсвэл эсрэг байна. Кали нь ногоон мөхлөгөөр баялаг, ургамлын сийвэнлэг залуу эс эдэд 50 хувь хүртэл маш өндөр хэмжээтэй агуулагддаг (5, 11) төдийгүй бусад эрдэс элементүүдээс илүү их хэмжээтэйгээр амьтанд хэрэглэгддэг байхад натри нь ургамлын гаралтай тэжээлд харьцангуй бага нэөцлэгдөнө (11) Иймээс тагцхуу ургамлаар дагнан хооллодог хойлгийн булчинд кали бусад элементээс давамгай их цээрсэн ба энэ нь уг элементийн голлон нэөцлөгдхээд эд эрхтэн нь булчин байдагтай ч бас холбоотой юм. Калийн хэмжээ хойлгийн тэжээлийн хувийн жинд ургамлын газар дээрх хатаж гандсан бие хэсгийн эзлэх жин харьцангуй багасч үндэслэг иш, үндэс, булцуу давамгайлах өвлийн улиралд буурч байна.

Харин микро элемент зэс, мangan, кобальт нь үет ургамал, үр тариа, буурцагт баялаг агуулагдах (5, 7, 11) тул хойлог эдгээр төрлийн тэжээлийг ид хэрэглэж тарга хүч авах намрын улиралд түүний булчинд их хэмжээтэй ($\text{Си}—36,9 \pm 4,8$ мг/кг, $\text{M}—11,0 \pm 0,2$ мг/кг, $\text{Co}—2,1 \pm 0,4$ мг/кг) болж байна. Ялангуяа хатсан үр нь зэсээр баялаг. Гэвч өвлийн улирал, хойлгийн тэжээл харьцангуй өөрчлөгдөн хатсан үр буурцаг хомсдож сонгинын ба бусад төрлийн ургамлын булцуу, үндэслэг иш, үндэс тэжээлд нь ахиж ирэхэд эдгээр элементийн хэмжээ буурах тал харагдлаа. Тэжээлийн ургамалд цайр ямагт хонгалттай (ургамлын үр хөврөлд бүр их) хэмжээгээр байдаг (11) боловч түүний агуулга бас улирлын хэлбэлзэлтэй байна.

Шинжилгээний дун баримттай уялдуулан тэмдэглэхэд, аливаа зэрлэг амьтан шувуу нь гадаад орчиндоо төрдгийн зэрэгцээ, гадаад орчин нь амьтны цагшид амьдрах, есөх, хөгжих амин гол нөхцөлийг хангадаг билээ. Амьд бие маҳбод ийнхүү гадаад орчинтойгоо салшгүй нэгдэл нягтралтай, түүнээсээ салангид амьдрах аргагүй учир гадаад орчных нь нөхцөлөөс бие маҳбодыг тусгаарлан авч үзэх аргагүй юм. Амьд бие маҳбодын есөх, хөгжих, амьдрах анхны нөхцөл нь идэш тэжээл, ус, таарч тохирсон температур, хүчилтерөгч гэх мэт байх ёстой. [6, 12]

Гэтэл аливаа нэг амьтны амьдрах гадзад орчин, амьтны амьдралд зайлшгүй чухал шаардлагатай нөхцөл, хүчин зүйлс нь хувирамтгай бөгөөд үргэлж өөрчлөгдөж байдаг. [13] Иймээс амьд биеийг төрүүлж өсгөсөн, түүний амьдрах нөхцөлийг хангдаг гадаад орчны өөрчлөлт болсход амьд бие мајбол өөрөө бас дагаж өөрчлөгдөнө [6,13] Тэгээд бие махбод амьдралынхаа харьцангуй шинэ нөхцөлд дасан зохицох шаардлагатай болж, өөрчлөгдсөн энэ шинэ нөхцөлдөө тохирсон бодисын солилцоо явуулна. Бодисын шинэ солилцоо нь бие махбод „өөрийгөө шинэтгэх“ процесст хургэнэ.

Араг ясны булчингийн идэвхтэй үйл ажиллагаа нь өөврмөц бодисын солилцооны үр дунд явагдах ба тэр нь „өөрийгөө шинэтгэх“ процессын үндсийг тавих бодисын нийт солилцоотой зэрэг явагдана. [6] Булчингийн эдийн химийн бүрэлдхүүн хэсгийн найрлагын „шинэчлэлт“ булчин мајбод тайван байх үед ч, үйл ажиллагаагаа гүйцэтгэн явуулж байгаа үед ч явагддаг.

Үүнээс үзвэл онгон байгаль хатуу шиরуун нөхцөлийн дунд амьдрах хойлгийн бие мајбод гэдаад орчныхо буюу тухайн тохиолдолд цаг улирлын хувирал өөрчлөлттэй нөхцөлд дасан зэхицохын сацуу „өөрөө шинэчлэгдэн хувирч“ байх үндэслэлтэй. Харьцангуй утгаар арабал, хавар, зуны тааламжтай цаг өнгөрч намар, өвлүүн улирал эхлэхэд хойлгийн амьдрах нөхнөл (хоол тэжээл хомсдон найрлаг), чанэр нь өөрчлөгдөх, хүйтэн сэргүүн хахир цаг болох гэх мэт), мөн өөрийнх нь өсөлт хөгжилт (энэ шувуу мөш хурдан өсөлттэй гэдгийг тооцвол амьдын жин нь эрс нэмэгдэх, тарга хүч авах, нас бие гүйцэх зэрэг) өөрчлөгднө.

Бидний хийсэн шинжилгээний дун нь хойлог шувуу өөрийн амьдралын үйл ажиллагааг жилийн янз бурийн улиралд тохирсон төвшинд (эрдэс бодисын солилцоог) явуулдгийг харуулсан нэгэн баримт боллоо. Түүнчилэн хойлгийн булчин-маханд янз бурийн цаг улиралд харилцан адилгүй хэмжээтэй макро-ба микроэлемент тодорхойлогдож байгаа нь энэ шувуу жилийн цаг улирлын хэмд сайтар тохирсон дасан зохицох чанартай болохыг давхар гэрчилж байна. Мөн уг шинжилгээ агууруын шувууны бие мајбодын химийн найрлага харьцангуй хувьсалтай, түүнд „өөрийгөө шинэтгэх“ процесс явагддаг ба бодисын солилцооны улирлын харьцангуй хөдлөл зүйтэй байдгийг харуулснаарга эмнэлэг-биологийн судалгааны ач холбогдолтой юм.

Цаашид хойлог болон агуулж бусад шувууны махыг хүнс тэжээлийн ба сувилгааны зорилгоор ашиглахдаа тэдгээрийн эрдэс бодисын найрлага төдийгүй аминхучил, витамин зэрэг бусад биологийн идэвхт бодисын улирлын хөдлөл зүйг уул шувууг агнах цаг улирлаар харгалзан үзэж байх нь зүйтэй юм.

ДҮГНЭЛТ. Алтайн хойлгийн булчингийн эдэд (маханд) агуулгахаа макро ба микроэлементийн агуулга улирлын хөдлөл зүйтэй байдаг нь нотлогдлоо. Энэ нь уул шувууны идэш тэжээлийн ургамлын бие хэсэг, эрдэс бодисын нөөцтэй холбоотой болно. Хойлгийн махыг сувилгаанд ашиглах болбол түүний эрдэс бодисын найрлага, эл шувууг агнах цаг улирлаас хамаарах талтайг харгалзан үзвэл зохицно.

СЕЗОННАЯ ДИНАМИКА СОДЕРЖАНИЯ МАКРО-И МИКРОЭЛЕМЕНТОВ В МЫШЕЧНОЙ ТКАНИ АЛТАЙСКОГО УЛАРА

Г. Зориг

Изучена сезонная динамика содержания макро-и микроэлементов в мышечной ткани алтайского улара-широко известной птицы и одного из ведущих представителей лекарственных животных монголь-

ской народной медицины, апробация и использование которого перспективно в целях коррекции обмена веществ человека.

Определены натрия, калия, фосфор, железо, медь, цинк, марганец и кобальт в сухой массе 182 пробы из мышечной ткани 38 алтайских уларов отстреленных (в том числе, по 10 птиц в осенний и зимний сезон, 18 птиц в весенне-летний период) в 1975—1979 гг. в магистральных хребтах и отрогах монгольского Алтая и представлены результаты их количественного содержания.

Установлено, что количественное содержание вышеуперчисленных минеральных элементов в мышечной ткани улара имеет свою особенность. Сезонной динамики в связи с поддержанием жизнедеятельности и метаболизма на свойственном виду уровне в разные сезоны года. Минимальная и максимальная концентрация минеральных веществ выявлена как в весенне-летний, так и в осенне-зимний период. Таким образом, необходимо учитывать особенности минерального состава, мяса улара при использовании в диетических целях для коррекции обмена веществ.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Афонский С. И. Биохимия животных. М. 1930. 511. 514, 517—519, 553.
2. Меньшиков Ф. К. Диетотерапия. М. 1972. 55. 61.
3. Тауцинь Э. Я. Определение микроэлементов в организме животных. В книге "Определение микроэлементов в биологическом объекте". Рига. 1968.
4. Ринькис Г. Я. Методы ускоренного колориметрического определения микроэлементов в биологическом объекте. Рига. 1963.
5. Власюк П. А., Шкварук Н. М., Сапатый С. Е., Шэмотиенко Г. Д. Химические элементы и аминокислоты в жизни растений, животных и человека. Киев 1974. 23.
6. Гулый М. Ф., Ремесло В. Н. О биологическом значении процессов постоянного обновления составных компонентов живых организмов. Киев. 1979. 9, 11.
7. Коломийцева М. Г., Габович Р. Д. Микроэлементы в медицине. М. 1970. 83. 146, 151, 163, 181, 215, 231, 236.
8. Зориг Г. Уртнаасан Д., Цэндээ Б. Содержание макро—и микроэлементов в мышечной ткани алтайского улара. Химийн хүрээлэнгийн бүтээл, УБ. 1981. 19.
9. Болд А. Алтайн хойлог. „БНМАУ-ын агууруын амьтад ба ан хамгаалал“ номонд. УБ. 1972. 114.
10. Зориг Г. Алтайн хойлог шувуу, „Хүүхдийн хүмүүжил“ сэтгүүл, 1978. 3. 121.
11. Мак—Дональд П. Эдвардс Р., Гринхолд Дж. Питание животных. М. 1970. 102—105, 110—115, 118—121.
12. Селянский В. М. Анатомия и физиология сельско-хозяйственной птицы. М. 1972. 231—232, 235, 238—240.
13. Плященко С. И. Сидоров В. Т. Естественная резистентность организма животных. Л. 1979. 66—67.

МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛГӨӨ, ЛЕКЦ, ТОЙМ

Ц. ЦЭРЭГМАА, Г. СУХБАТ, Ш. ЖИГЖИДСҮРЭН

БӨӨРНИЙ ДЭЭД БУЛЧИРХАЙН ЭМГЭГИЙН ГАРАЛТАЙ АРТЕРИЙН ДАРАЛТ ИХСЭЛТ

АНАГААХ УХААНЫ ДЭЭД СУРГУУЛЬ

Орчин уед 50 гаруй төрлийн өвчний уед цусны даралт ихсэх шинж тэмдэг дагалдан илэрдэг гэж үзэж байна. (1—4) Тэдгээрийг эмгэг жамынх нь хувьд: 1. Төв мэдрэлийн системийн, 2. Бөөрний, 3. Том судасны 4. Цусны эргэлтийн алдагдлын, 5. Дотоод шүүрлийн булчирхайн эмгэгүүдийн гаралтай цусны даралт ихсэлт гэж 5 том бүлэгт хуваадаг.

Дотоод шүүрлийн булчирхайн эмгэгүүдийн гаралтай шинж тэмдгийн цусны даралт ихсэлтийн дотср бөөрний дээд булчирхайн өвчнүүдийн аденоата, гиперплази, хортой хоргүй хавдрууд г. м. (үүсэлтэй шинж тэмдгийн цусны даралт ихсэлт зонхилох хувийг эзэлдэг. ДЭХБЫН мэдээгээр уг булчирхайн эмгэгийн үүсэлтэй цусны даралт ихсэлт нь нийт шинж тэмдгийн цусны даралт ихсэлтийн 5—6 хувьд тохиолдноно. (1, 2, 6)

Одоогоос хэдхэн жилийн өмнө уг эрхтэний эмгэгийн гаралтай цусны даралт ихсэлтийг ховорхон тохиолдол гэж үзэж байжээ. Энэ нь бөөрний дээд булчирхайн эмгэгүүдийн олонхи нь булчирхайн дааврын өөрчлөлтийн эмнэл зүй илрэхгүйгээр явагддагийн гадна, цусны даралт ихсэлт нь ихэнх тохиолдолд бусад шалтгаанаар үүссэн цусны даралт ихсэлтийн нэгэн адил нийтлэг шинж тэмдгүүдтэй байдаг. Энэ нь эрхтэний анатомийн байрлал бүтэцгэй холбоотой юм.

Бөөрний дээд булчирхайн хавдрын анхны шинж тэмдэг нь цусны даралт ихсэлтээр илэрдэг бөгөөд үүний хүндрэлийн улмаас өвчтөн нас барах нь олонтоо тохиолддог. Харин цөөн тохиолдолд хавдрын хордлогоор нас бардаг. Иймээс бөөрний дээд булчирхайн эмгэгийн гаралтай артерийн даралт ихсэлтийг сношлох нь уг эрхтний эмгэгийг эрт илрүүлэн эмчлэх ач холбогдолтой юм.

Бөөрний дээд булчирхайн эмгэгийн гаралтай даралт ихсэлтийн $\frac{2}{3}$ хувь нь хорт явцтай байдаг.

Иценко-Кушингийн хам шинж, эстрогенома, андрогеномын үеийн цусны даралт ихсэлт нь булчирхайн эмгэгийн тодорхой эмнэл зүй дагалдан илэрдэг учраас сношлоход хялбар. Харин олонтоо тохиолддог Коннын хэм шинж, феохромоцитомын үеийн даралт ихсэлт нь сношлоход түвэгтэй.

Бөөрний дээд булчирхайн артерийн даралтын зохицуулалтанд оролцох үйл ажиллагаа нь түүний тархилаг давхаргын хромафин эдээс ялгаран гардаг (катехоламин, адреналин, норадреналин, дофамин) холтослог давхрын 40 гаруй төрлийн стероид даавуудтай холбсotой юм.

Катехоламин нь хэвийн уед моноаминоксидаза (МАО) ферментийн нөлөөгээр байнга задарч байдаг учир бие махбодод тогтмол хэмжээ-

тэй байж артерийн даралтыг ихэсгэдэггүй байна. Бөөрийй лээд булчирхайн феохромоцитома, феохромобластома, гиперплази зэрэг эмгэгийн уед катехоламин хэт ихээр ялгарч МАО ферментийн үйлчлэл дутагдаж артерийн даралт ихэсдэг байна. Орчин уед катехоламины артерийн даралтыг ихэсгэдэг механизмыг дараах байдлаар тайлбарлаж байна.

Катехоламин судас нарийсгах замаар артерийн даралтыг ихэсгэдгийг нээрт эрдэмтэн Клорд Бернар анх нээсэн билээ. Сүүлийн 10 жилд катехоламины төрлийн үндсэн бодис тус бүрийн судасны зохицуулалтад оролцох үйлчлэлийг нээлээ. Тухайлбал норадреналин нь адрено-рецепторт сонгомол үйлчилдэг учир судас нарийсган артерийн даралтыг ихэсгэдэг байхад, харин адреналин β -адренорецепторт үйлчилж судас өргөсгөх их хэмжээгээр ялгарвал α -адренорецепторыг цочроож артерийн даралтыг ихэсгэдэг. (1,2)

Катехоламин нь гипоталамусын судас хөдөлгөх төвийг цочроож сэтгэл хөдлөл үүсэн бүрэлдэх бүтцүүдийг (торлог бзигууламж, лимбийн систем) хэт сэрэлд оруулж, бөөрний дээд булчирхайн холтослог давхаргын стероид даавруудын ялгаралтыг нэмэгдүүлэх замаар артерийн даралтыг ихэсгэдэг. Нэгөө талаар бөөрний дээд булчирхайн холтослог давхаргын эмгэгүүдийн (анхдагч альдостеронизм-Коннын хамшинж, глюкостерома, альдостерома г. м) уед стероид дааврууд тухайлбал альдостерон их хэмжээгээр ялгарч артерийн даралтыг ихэсгэх бас нэгэн хүчин зүйл болдог. Альдостероны хэт ялгаралт нь бөөрний тахир сувгандраар натри, ус эргэн шимэгдэх процессыг улам идэвхжүүлэх, гипоталамусын осморецепторыг цочроон антидиуретик дааврын ялгаралтыг нэмэгдүүлэх, судасны хананд ус, натри хуралдан, судасны сувийг нарийсгах зэрэг механизмуудаар артерийн даралтыг ихэсгэдэг. Судасны нарийсалт нь гипоталамусыг цочроож, катехоламины шүүрлийг улам идэвхжүүлэн бие махбодод артерийн даралтыг өндөр түвшинд тогтвортой хадгалагдах эмгэг процесс тасралтгүй үргэлжлэхэд хүргэнэ. Ийнхүү ээдрээт харилцан нөлөөллийн замаар бөөрний дээд булчирхайн эмгэг голомт нь зурх судас болон бусад эрхтэн системуудийг гүнзгий хямралд оруулдаг байна.

Бөөрний дээд булчирхайн эмгэгүүдээс олонтоо тохиолддог Коннын хамшинж болж феохромоцитомын үеийн артерийн даралт ихсэлтийн эмнэл зүй, оношлолын асуудлыг авч үзье. Коннын хамшинж, анхдэгч альдостеронизм нь 84,5 хувь нь бөөрний дээд булчирхайн adenoma, 11,3% гиперплази, 2,1% хавдрын уед тохиолдоно. Уг хамшинжийн үеийн цусны даралт ихсэлт нь толгой өвдөх, зүрх дэлсэх, өвдөх, ядрах, зурх томрох, нүдний ёроолд гүнзгий өөрчлөлт үүсэх зэрэг түгээмэл шинж тэмдгүүдээс гадна бөөрийг хоёрдогч шалтгаанаар гэмтээж, шээсэнд уураг, дүрст элементүүд гарах, их шээх (ялангуяа шөнийн цагаар) шинжууд ажиглагдан хожуу уедээ бөөрний үйл ажиллагааны архаг дутагдалд орж ялган оношлоход түвэгтэй болдог. Эдгээрийг ялган оношло шалгууруудад өвчтөн амархан ядрах, хөдлөхөөс дургүй хүрэх гэх мэт зовиур шаналгаа орно. Зарим тохиолдолд гарцаа хөдөлгөх, толгойгоо өндийлгөх, ярж чадахгүй болтлоо тамирдах зэрэг зовиур шаналгаа нь үе үе давтагдах байдлаар илэрдэг онцлогтой.

Өвчний эхний үе шатанд тодорхой бүлэг булчин (гар хөл, хүзүүний) сурлан хатингаршиж өвчин даамжрахын хирээр биеийн бүх булчин өвдөх, шөрмөсний рефлекс ихсэх, уруул цорвойх, труссын рефлекс ажиглагдах бөгөөд эцэст бүлэг булчингийн саажилт үүсэх нь олонтоо тохиолдоно. Энэ уед даралт тогтвортой өндөр түвшинд байх ба даралт бууруулах эмчилгээнд үл буурна.

Тиазидын бүлгийн эмүүдийг хоногт 100 мг тунгаар хэрэглэхэд даралтын бууралтанд ямар ч нөлөө үзүүлэхгүй, харин булчингийн

сулрал ихсэн өвдөлт нь нэмэгддэгээрээ хоргүй явцтай цусны даралт ихсэх өвчинөөс ялгаатай.

Верошироныг хоногт 300—400 мг тунгаар 3—4 долоо хоног хэрэглэхэд артерийн даралт амархан буурч хэвдээ орж биений ерөнхий байдал дээрдэн эрдсийн хямрал (цусанд кали багадалт) засарч ренин цусанд тодорхойлогдож эхэлнэ. Цус ба шээсэнд альдостерон хэвийн хэмжээнээс эрс ихснэ.

Венин ялгаралт багассан ихэнх тохиолдолд цусанд ренин тодорхойлогдохгүй. Учир нь альдостерон нь ренинийг ялгаруулан гаргадаг бөөрний юкстагломеруляр аппаратын уйл ажиллагааг дараангуйлдаг. Үүнийг ренин багатай буюу рениний идэвхжилгүй артерийн даралт ихсэлт гэж зарим судлагчид нэрлэдэг. Үүгээрээ бөөрний эмгэгийн гаралтай артерийн даралт ихсэлтээс ялгагдана.

Хоногийн шээсэн дэх натри калийн коэффициент 1-ээс буурна. Хүчил шүлтийн тэнцвэр шүлтлэг тал руугаа давамгайлж шээсний орчин шүлтлэгжинэ.

Диурезийн эсрэг даавар хэрэглэхэд их шээх нь татрахгүй. Энэ шинж чанараараа бусад дааврын эмгэгээс ялгаатай.

Феохромоцитома нь ихэвчлэн 1 талын бөөрөнд тохиолдоно. Оношийн шалгуурууд нь артерийн даралт ихсэлт нь криз хэлбэрээр явагддаг бөгөөд ($\frac{2}{3}$) криз нь сөрт мэдэгдэм тодорхой шалтгаангүйгээр цусны даралт хэвийн хэмжээнд буюу яльгүй ихсэхэд илэрдгээрээ онцлог юм. Криз гэнэт эхэлнэ. Эхлээд бие бадайрна, чичирнэ, айдас хүрнэ, толгой өвдөнө (55%), толгой эргэнэ (15%), зүрх дэлсэнэ (38%) даралт 200—250 м. у. б хүртэл ихсэж болно.

Кризийн үед зүрхний хэм алдагдах зүрх, тархинд цус харвах зэрэг ноцтой хүндрэл ховор гардаг.

Криз хэдэн цаг ч үргэлжиж болно. Даралт буурч хэвийн хэмжээнд орсны дараа их хөлөрч, их шээж бие сулардаг.

Хоёр бөөрний орчимд дараад даралт ихсэж, цус ба шээсэнд катехоламины ихснэ. Хааяа криз илэрдэг. Мөн 2 гарыг мөстэй хүйтэн усанд дурсний дараа артерийн даралт ихсэдэг.

Катехоламины задралын эцсийн бүтээгдэхүүнүүд тухайлбал ванилилминдалины хүчлийг хоногийн буюу З цагийн шээсэнд тодорхойлоход (ялангуяа кризийн дараа) хэвийн хэмжээнээс нэмэгдсэн байдаг.

Гистамины сорил: 0,1—0,5 мл гистаминыг судсанд хийхэд криз ёгнэ. (Энэ сорилыг артерийн даралт 160—100 м. у. б-с дээш тохиолдолд хийж болохгүй) Тропафенийн сорил: тропафенийг 10—20 мг-г судсанд хийхэд артерийн даралт хэт буурна. Бусад шалтгаанаар үүсэн артерийн даралт ихсэлтэд тропафенин ямар ч нөлөө үзүүлэхгүй.

Сүүлчийн хоёр сорил нь феохромоцитомыг таних онцгой өвөрмөц сорил юм.

Эцсийн оношийг тодруулах бодисын тусламжтайгаар бөөрний зураг авах, тэмдэгт атомын тусламжтайгаар бөөр болон бөөрний дээд булчирхайд бичлэг хийх, ретропневмоперитониум, аутографи, бөөрний дээд булчирхайн томографи зэрэг шинжилгээний тусламжтайгаар тогтооно.

Эмчилгээний үндсэн арга нь мэс заслын эмчилгээ юм. Эрт илрүүлэн оношилж чадвал мэс заслын эмчилгээ 100 хувь үр дүнтэй байдаг. Харин эрхтэн системд гүнзгий өөрчлөлт орсон өвчиний хожуу үед мэс заслын эмчилгээ хийх боломжгүй юм.

Ашигласан хэвлэл

1. Гогин, Е. Е. Сененко А. Н. Тюрин Е. И. — Артериальные гипертензии А 1978.
2. Кононяченко В. А. Гипертоническая болезнь и симптоматические гипертонии М. 1971
3. Ратнер, Н. А. Болезни почек и гипертонии М. 1965
4. Ратнер, Н. А. Артериальные гипертонии М. 1974
5. Герасименко П. П. Кардиология, 1981, №5 109—114
6. Виноградов А. В. Дифференциальный диагноз внутренних болезней том—1 М., 1980. №5. 63—95

Л. БАЯР

НЯРАЙ БА ХҮҮХҮЛ ХҮҮХДИЙН ТАРХИНЫ ТӨРӨЛХИЙН ГЭМТЭЛ, ТҮҮНИЙ ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭ

ЭРДЭНЭТ ХОТЫН НЭГДСЭН БОЛЬНИЦ

Тархины төрөлхийн гэмтлийн улмаас тохиолдох нас баралт их байхаас гадна амьд үлдсэн зарим хүүхэд элий балай ухаантай, унаж татдаг өвчтэй, тахир дутуу хүн болдог учир орчин уед эмч эрдэмтэйн анхаарлыг татаж байгаа чухал асуудлын нэг болж байна. Эрдэмдийн судалгаагаар тархины төрөлхийн гэмтлийн улмаас нас барах нь бүх нас баралтын 24—54%-ийг эзэлж, мэдрэл болон сэтгэл мэдрэлийн өвчтэй хүүхдүүдийн 55%-ийг тархины төрөлхийн гэмтэлтэй хүүхдүүд эзэлж байна. [1] Улаанбаатар хотын амаржих газруудад бидний хийсэн судалгаагаар (1974—1978) бүх төрсөн 63235 хүүхдээс нярайн элдэв өвчинөөр 1354 хүүхэд амьдралын эхний хоногуудад нас баржээ.

Энэ хугацаанд тархины төрөлхийн гэмтэлтэй 1216 хүүхэд байснаас 414 нь буюу 34% нь нас баржээ. Гэтэл энэ 5 жилд тархины төрөлхийн гэмтэл бүхий хүүхэд, төрсөн бүх хүүхдийн 1,9%-ийг, нярайн өвчлөлөөр амаржих газар нас барсан хүүхдийн 30,6%-ийг эзэлж байна. Үүнээс үзэхэд тархины төрөлхийн гэмтэл манай орны нөхцөлд ч нилээд элбэг тохиолддог ажээ.

Тэрчлэн энэ хугацаанд П. Н. Шастины нэрэмжит клиникин нэгдсэн З дугаар эмнэлгийн мэдрэлийн мэс заслын тасагт тархины төрөлхийн гэмтлийн үлдэц урхаг бүхий 53 хүүхдэд мэс заслын эмчилгээ хийсэн байна.

Тархины төрөлхийн гэмтэл бүхий хүүхдүүдэд эмнэлгийн тусламжийг төрсний дараах эхний хоногуудад яаралтай үзүүлэх нь цаашид гарах хүндрэлээс урьдчилан сэргийлэх ба энэ эмчилгээ нь тухайн гэмтлийг төгс эмчлэх арга болох юм.

Энэ эмчилгээг аль болохоор эрт хийснээр хүүхдийн цаашидын хувь заяа шийдэгдэнэ. Тархины төрөлхийн гэмтлийн үлдэц урхаг бүхий хүүхдэд хожим уед хийх мэс заслын эмчилгээ нь эхэн уед хийх мэс заслын эмчилгээг бодвол үр дун нь тийм ч сайн биш байдаг болох нь ажиглагдлаа. Хүүхдийн төрөлхийн гэмтлийг эрт оношлох ба эмчлэх, тархины төрөлхийн гэмтлээс урьдчилан сэргийлэх зэрэг арга хэмжээг боловсруулах, эрүүлийг хамгаалах практикт үйл ажиллагаанд

ЗХУ ба тэргүүний хөгжилтэй бусад орны туршлагыг өргөн хүрээтэй нэвтрүүлэх шаардлагатай болж байна. Тархины төрөлхийн гэмтэл бүхий нярай хүүхдүүдийг төрсний дараах эхний хоногуудад мэдрэлийн болон хүүхдийн эмчийн хяналтанд ажиглах хэрэгтэй. Хүүхдийг төрсний дараа гавлын дотоод даралт ихсэх шинж тэмдэг болон менингиаль шинж илэрч байгаа эсэх, биеийн ерөнхий байдал бүтэлтийн шинж тэмдэг илэрсэн эсэхийг шалгаж үзэх хэрэгтэй.

Хүүхдийн толгойн хэмжээг тогтмол шалгаж үзнэ. Нярай хүүхдийн толгойн өндрийн хэмжээ биеийн уртын 1/4-тэй тэнцдэг. Төрөх үед толгойн эргэн тойрны хэмжээ 35,3 см, хамгийн бага нь 33,0, хамгийн их нь 37,5 см байна. Төрөх үед толгойн эргэн тойрны хэмжээ нь цээжний хэнхэрцгийн хэмжээнээс 1—2 см илүү байдаг. Хүүхэд 1 нас хүрэхэд хэмжээ нь тэнцэж, хожим нь цээжний эргэн тойрны хэмжээ толгойныхоос илүү том болдог. Эрүүл зөв өсөлттэй ч гэсэн хүүхдийн толгойн хэмжээ дундаж хэмжээнээс мэдэгдэхүйц өөрчлөгдсөн байвал цаашид эмчийн хяналтанд байх шаардлагатай. Учир нь зарим өөрчлөлтийг хэвийн гэж үздэг боловч зарим нь эмгэг шинж төрхтэй болж хувиждаг байна. Зөвхөн толгойн хэмжээг (хэвийн, багассан-микроцефали, томорсон-макро эсвэл гидроцефали) анхаараад зогсохгүй бас хэлбэрийг нь анхаарах нь чухал. Гавал яс ч хоёр талдаа адил бус байх нь төрөлхийн гэмтэл согог юм уу эсвэл ямар нэгэн гэмтлээс, гаж буруу хөгжил, тархины хавдар зэргээс эсвэл хүүхдийг үргэлж нэг талаар нь хэвтүүлж байснаас болдог юм. Нярай хүүхдийн зулайг заавал үзэх хэрэгтэй. Хүүхдийн толгойг тэмтэрч үзэхдээ хоёр гарын эрхий хурууг зурайн хонхорт тавьж их зулайг, долоовор ба дунд хурууг тэтэм болон гол заадас дээр мөн зурай яс дагз ясны завсрлын заадсууд дээр тавьж тус тус тэмтэрч үзнэ. Хүүхдийн их зурай 1,2—1,8 настайд, бага зурай 2—3 сартайд битүүрнэ. Тогшилтоос үүссэн дуугаар гидроцефали (тархи усжин томрох) юм уу заадсууд салсан эсэхийг тодорхойлж болно.

Чатнаж үзсэнээр гавлын доторхи судсуудын гажиг (аневризма, артери венийн шууд холбоо зэрэг) эмгэгийг илрүүлж болоо. Хүүхдийн гавлын доторхи хөндийн зайлт багасгахад хүргэдэг өвчинүүдийн үед тайван бус байдал, орчиндоо сонирхолгүй болох, огих, гулигуулах, бөөлжих (хоол идсэнтэй холбоогүй) биеийн ерөнхий өсөлт хоцрох гэх мэт шинж тэмдгүүдийг анхаарах хэрэгтэй. Няях хүүхдэд гавлын доторхи даралт ихэдсний гол шинж тэмдэг нь толгойн хэмжээ хэвийн байдлаас илүүгээр томрох (гидроцефали тархины хатуу хальс доогуур цус хурах, тархины хавдар бий болох зэргээс болж) юм.

Гавлын хэмжээг шалгаж үзэх нь чухал бөгөөд толгойн эргэн тойрны хэмжээгээр түүний хэмжээг тогтоодог. Толгойн эргэн тойрны хэмжээ өөрчлөгдөх нь гавлын доторхи хэвийн буюу эмгэг өөрчлөлтийг оношлох үндэслэл болж өгдөг. Хэрэв толгойн эргэн тойрны хэмжээний өөрчлөлтийг графикаар дурсэлж үзүүлбэл нярай болон хөхүүл хүүхдийн зөвхөн гавлын доторхи даралт төдийгүй, оношилгоо ба цаашдын хувь тавиланг тодорхойлж болохуйц чухал зураглал гарна. Үнийг 1 дүгээр хүснэгтээс үзэж болно. Ердийн үед толгойн эргэн тойрны хэмжээний (хамгийн их ба хамгийн бага) хоорондох зөрөө нь 10% байх ба дундаж хэмжээнээс их, бага тал руугаа 5% хэлбэлзэж болно. Хүүхдийн биеийн ерөнхий байдлыг тодорхойлох нэг гол зүйл нь биеийн жингийн нэмэгдэл юм. (2 дугаар хүснэгт) Бид нэг жишээ авья. Тархины хавдартай 5 сартай хүүхдийн толгойн эргэн тойрны хэмжээ нь нэг сард 5 см нэмэгдэж (43 см байснаас 48 см) мөн хугацаанд биеийн жин нь 200 гр нэмэгдэнэ. Гэтэл энэ хүүхэд тархины хавдартай байсан бол түүний биеийн жингийн нэмэгдэл нь наад захын хэмжээгээр 350 гр (5 x 70) байх ёстой. 5 сартай эрүүл хүүхдийн толгойн хэмжээ нь сард биеийн жингийн 70—100 гр тутамд 1—1,5 с_M

нэмэгдэх ёстой. Ийм харьцаагаар толгойн хэмжээ нэмэгдэх тутам би-
еийн жин ихсэж сард 350 граммаар нэмэгдэнэ.

Тархины төрөлхийн гэмтэлтэй нярай хүүхдэд нугасны хатгалтыг
оношилгоо ба эмчилгээний зорилгоор заавал хийнэ. Нугасны хатгалт
нь тархи нугасны шингэнийг авах ердийн арга юм.

Нугасны хатгалтыг бүсэлхийн 4—5 дугаар нурууны сэргэнгийн зав-
раар хийнэ. Хэрэв нугасны хатгалт хийхэд хүүхэд уйлбал тайвшир-
тал хулээнэ. Нугасны хатгалтыг хэвтээ байдлаар хийнэ.

Нярай хүүхдийн нугасны шингэний дараалт 100—180 мм усны түвшин-
тэй тэнцүү байна. 1 шоо см шингэн авахад тархины дараалт 10—15 мм
усны түвшингээр буурна.

Нярай хүүхдийн нугасны хатуу хальсны гаднах зайд венийн су-
дас их байдаг учир нугасны хатгалт хийхэд цус гарч оношилгооны
алдаанд хүрэх тохиолдол байдаг.

Нярай хүүхдийн гавлын арын хонхрын эмгэгтэй буюу эсвэл нуд-
ний ёроолд хавагналт үүссэн үед нугасны хатгалт хийж болохгүй.
Энэ тохиолдолд тархины хажуугийн ховдлын өмнөд эвэрт их зулайн
хэсгээр шууд хатгалт хийнэ. Үүний өмнө толгойн үсийг хусаж, спирт
иодоор ариутгаж их зулайн баруун, зүүн талд хатгана. Гол шугамаас
2 см гадагш, титэм заадсаас 2 см урагш Кохерийн цэгт эгц хатгаж
2—3 см гүн явуулахгд ховдлын шингэн гарна.

Ховдолд хадгалт хийснээр гавлын доторхи шингэний дараалт ямар
байгаа, түүний өнгө, ховдлын шингэн, нугасны хатгалт хийж авсан
шингэн хоёрын найрлагыг харьцуулан судлах боломжтой.

Хэрэв ховдлоос цусархаг шингэн гарвал ховдлын цус алдалт гэж
үзэж ховдолд гуурс улдээж Арендын системтэй залгана.

Хэрэв нярай хүүхдэд тархины хатуу хальсны гадна болон доо-
гуурхи цус хуралт үүссэн гэж үзвэл сэжигтэй тэр хэсэгт ясны гад-
наас шууд хатгаж хурсан цусыг соруулан авч болно.

Төрөх үед төрөлтөөс шалтгаалж толгойн яс цагш цөмөрсөн, ясан
доогуур цус хурсан, эсвэл тархины хатуу хальс дор буюу тархинд цус
хуралдсан гэж оношлогдсон үед яаралтай мэс заслын эмчилгээ хийнэ.
Нярай ба хөхүүл хүүхдэд тархины хатуу хальсны доогуурхи цус ху-
ралт нь тархины хоёр тал бөмбөлөгт хамтад нь тохиолддог.

Тархинд цус алдалт болж буй үед бүтэлтийн үед илрэх шинж
тэмдэг өгдгөөр нь оношилгооны алдаанд хүрэх тохиолдол бий. Энэ
шинж тэмдэг илэрсэн үед заавал ховдол болон хатуу хальсны доо-
гуур хатгалт хийж байх шаардлагатайг санах хэрэгтэй.

Мөн тархины хальс дсогуур болон тархинд цус хуралдсан байж бо-
лох сэжигтэй үед трансиллюминацийн аргаар тархийг гэрэлтүүлэн
үзэж болно. Энэ арга нь нярай хүүхдийн төрөл бүрийн эмгэгийг
оношлоход чухал ач холбогдолтой. Энэ аргыг хөдөө орон нутгийн
нэхцэлд хэрэглэж болох ердийн арга юм. Мөн ЭХО-энцефалографийн
аргаар тархинд байгаа эмгэгийн байрлал, хэмжээг мэдэж болно.

Энэ шинжилгээнүүдийг төрөх тасаг болон хүүхдийн тасгуудад
хийж болох бөгөөд оношилгоо эмчилгээний их ач холбогдолтой. Онсш
тогтсогдсоны дараа мэдрэлийн мэс заслын тасагт шилжүүлэн эмчил-
нэ. Энд нугасаар тархинд хий шахаж ховдлын замыг шинжлэх, гү-
рээний болон нурууны arterийн судсаар тодотгогч бодис хийж тар-
хины судасны замыг шинжлэх, ховдолд хий болон тодотгогч бодис
хийж шинжлэх, тодотгогч бодисоор нугасны эмгэгийг тодорхойлох,
тархины цахилгаан бичлэг гэх мэт аргаар тархины гэмтлийг оношилс,
байрлал хэмжээг тодорхойлдог. Тархины гэмтэл бүхий нярай (төр-
снээс хойш 3—4 долоо хоногтой) болон хөхүүл (3—4 долоо хоногссы
ойндоо хүртэл) хүүхдүүдэд гэмтлийн дараахь үед илрэх гол шинж нь
толгой усжин томрох юм.

Үүнийг мэдэхийн тулд толгойн хэмжээг 7 хоног бүр тогтмол хэмжиж графикаар тэмдэглэж байх хэрэгтэй. Толгойн хэмжээ ердийн өсөлттэй хүүхдийн толгойн хэмжээнээс 2—3 см ихэссэн үед мэдрэлийн мэс заслын эмчид үзүүлж, яаралтай мэс заслын эмчилгээ хийвэл зохино. Энэ үед тархины хажуугийн ховдлын доод эзвэрт гуурс оруулж улмаар гуурсыг тархинаас гаргаж хуйхан доогуур явуулж хүзүүний хэсэгт *V. facialis* аар дамжуулан *V. jugularis* т оруулж улмаар цааш зүрхэнд гуурсны үзүүрийг орууллаг мэс засал хийнэ. Энэ хагалгаанд хэрэглэдэг гуурс нь 0,2 см диаметртэй зөвхөн ховдлоос гарсан шингэн нэг зүгт даралтаар урсан зүрхэнд орж байх хавхлагтай гуурс юм. Энэ мэс заслын арга нь орчин үед тархины төрөлхийн гэмтэл болон олдмол гэмтэл бүхий хүүхдийг эмчлэх эмчилгээний цорын ганц арга болж байна. Энэ аргаас өмнө гидроцефалийн үед хийх хагалгааны олон арга байсан бөловч үр дүн мутай байв. Одоо үед гидроцефалийн янз бүрийн хэлбэрт ховдлыг хэвлийн хөндийтэй холбох хагалгааг хийж байна. Хагалгааны зорилго нь тархины даралтыг багасгаж, ховдлын илүүдэл шингэнийг цусны судсанд буюу хэвлийн хөндийд оруулах зорилготой бөгөөд физиологийн сайн талтай юм. 1949 онос энэ хагалгааг хийхдээ хавхлагтай гуурс хэрэглэнсээр тархины шингэнийг нэг чигт урсгаж буцаж цус гуурс болон ховдолд орохгүйгээр болгожээ.

1956 онос эхлэн гуурсыг цааш зүрхний баруун тосгуурт оруулж тавьснаар энэ хатгалгаа амжилтанд хүрч анагаах ухааны практикт нэвтэрч, олонтоо тохиолддог энэ төрлийн өвчтэй хүүхдийг аврах эмчилгээний үнэт арга болжээ.

Хүснэгт 2

Нэг нас хүртэлх хүүхдийн бисийн хэгжилтийн дундаж үзүүлэлт

| № | Нас сараар | Жинж-аар (мм) | Гендер (мм) | Толгойн эргэн тойрны хэмжээ | | |
|----|------------|------------------|----------------|-----------------------------|---------------|------------------------|
| | | | | Хамгийн багас хэмжээ | Дундаж хэмжээ | Хамгийн хүйтэнд хэмжээ |
| 1 | Төрөх үед | 3,2—3,4 | 49—50 | 33,0 | 35,3 | 37,5 |
| 2 | 1 сартай | 3,4—3,6 | 52—53 | 35,3 | 37,2 | 39,7 |
| 3 | 2 сартай | 4,2—4,4 | 56—57 | 37,0 | 39,2 | 41,5 |
| 4 | 3 сартай | 4,8—5,1 | 59—60 | 38,7 | 40,4 | 43,2 |
| 5 | 4 сартай | 5,6—6,0 | 62—63 | 40,0 | 41,5 | 44,2 |
| 6 | 5 сартай | 6,3—6,7 | 63—66 | 41,0 | 42,5 | 45,1 |
| 7 | 6 сартай | 6,8—7,3 | 67—68 | 42,1 | 43,4 | 45,9 |
| 8 | 7 сартай | 7,2—7,8 | 69—70 | 42,8 | 44,0 | 46,6 |
| 9 | 8 сартай | 7,6—8,2 | 70—71 | 43,3 | 44,7 | 47,2 |
| 10 | 9 сартай | 8,0—8,6 | 71—72 | 43,8 | 45,3 | 47,8 |
| 11 | 10 сартай | 8,4—9,0 | 72—73 | 44,2 | 45,8 | 48,2 |
| 12 | 11 сартай | 8,8—9,4 | 73—74 | 44,7 | 46,2 | 48,5 |
| 13 | 12 сартай | 9,2—9,8 | 74—75 | 44,9 | 46,6 | 48,9 |

ЦУСНЫ ЭРГЭЛТИЙН ЦОЧМОГ ДУТМАГШЛЫН ҮЕИЙН СЭХЭЭН АМЬДРУУЛАХ ЭРЧИМТ ЭМЧИЛГЭЭ

Өмнөговь аймгийн нэгдсэн эмнэлэг

Мэс заслын эмчилгээ хийх шаардлагатай олон төрлийн өвчний үед цусны эргэлтийн цочмог дутмагшил тохиолддог. Энэ үед сэхээн амьдруулагч, мэдээ алдуулагч эмчээс маш их анхаарал шаардлаг бөгөөд илрэх үндсэн шинж нь артерийн даралт буурах юм. Гэвч зөвхөн артерийн даралт буурсан шинжээр уг эмгэг байдлыг ялган оношилох, эрчимтэй эмчилгээ хийхэд учир дутагдалтай.

Артерийн даралт нь 5 хүчин зүйлээр тодорхойлогдно. Үүнд:

1. Зүрхний ба зүрхний минутын эзэлхүүний хэмжээ
2. Зах хязгаарын эсэргүүцлийн хэмжээ
3. Эргэлдэх цусны эзэлхүүн
4. Том артериудын уян хатан чанар
5. Цусны зууратгай чангр эдгээр хүчин зүйлсийн харилцан үйлчлэлээс артерийн даралтын төвшин хамаарна. Зүрхний ба зүрхний минутын эзэлхүүний багасалтаас зүрхний гаралтай, зах хязгаарын эсэргүүцэл буурснаас судасны гаралтай, эргэх цусны эзэлхүүн буурснаас цус шингэн дутагдсан артерийн даралтын багасалт тус тус үүснэ. Артерийн даралт багасалтын шалтгааныг зөв тодорхойлж, шокоос ялгах нь цаашдын эмчилгээний тактикт чухал ач холбогдолтой юм.

ЗҮРХНИЙ ГАРАЛТАЙ АРТЕРИЙН ДАРАЛТЫН БАГАСАЛТ.

Зүрхний гаралтай артерийн даралт багасалтын (зүрхний дутмагшил, зүрхний багтраа, оношийг доорхи шинжийн үндсэн дээр тогтоож болно. Үүнд:

1. Зүрхний эзэлхүүний багасалт
2. Судасны лугшилтын тоо олшрох
3. Амьсгалын тоо олшрох
4. Гол төлөв агшилтын даралт багассанаас судасны лугшилтын даралт буурах
5. Зах хязгаарын эсэргүүцэл ихсэх
6. Венийн даралт ихсэх
7. Арьс салстын өнгө хөхрөх
8. Шээс ховордох
9. Мөчнүүд хөрөх зэрэг юм.

Зүрхний гаралтай артерийн даралт багасалтын анхдагч, нилээд дэлгэрэнгүй шинж нь зүрхний хаялт багасах явдал юм. Энэ нь зүрхний булчингийн суралтаар тайлбарлагдана. Судасны лугшилтын тоо нэгэн зэрэг олширсон байх учир зүрхний минутын эзэлхүүн хэвээр байна. Зүрхний хаялт багассанаас зах хязгаарын цусны эргэлтийн хямрал үүснэ. Ингэснээр хүчилтөрөгчийн дутагдал болж зах хязгаарын эсэргүүцэл ихэснэ. Мөн венийн даралт ихсэж цусны бага эргэлтэнд тогтонги нэмэгдэж уушгини агааржилт муудсанаас хүчилтөрөгчийн дутагдал улам нэмэгдэн амьсгал зогсоход хүргэнэ. Энэ үед дорхи эрчимт үйлчилгээг хийнэ.

1. Өвчтөнийг фовлерын байрлалаар байрлуулах
2. Хүчилтөрөгчөөр эмчлэх
3. Венийн судсанд 40%-ийн глюкозыг 0,25—0,5 мл строфантинтай хамт тарих.

4. Венийн судсанд эуфиллин, харин артерийн даралт төдий л буураагүй уед артерийн бага даралтыг бууртал гексони, пентаминыг тарих.

5. Тогтонги, хавэнгийн уед антибиотикоор эмчлэх.

6. Осмодиуретик эмийг дуслаар тарих зэрэг болно.

СУДАСНЫ ГАРАЛТАЙ АРТЕРИЙН ДАРАЛТ БАГАСАЛТ.

Эфир, фторотан, хлороформын гүнзгий мэдээ алдуулалт, симпатик зангилааны хориг дээгүүр нугасанд хийсэн мэдээ алдуулалт, бөөрний дээд булчирхайн дутагдлын уед судасны гаралтай артерийн даралт багасна.

Жижиг артерууд өргөссөнөөр судасны урсгалын багтаамж ихэснэ. Ингэснээр цусны хэвийн эзэлхүүн, судасны ихэссэн багтаамж хоёрын хооронд зөрүү үснэ.

Эмнэл зүйн шинж тэмдэг нь доорхи байдлаар илэрнэ. Үүнд:

1. Судасны лугшилт олшрох

2. Ашилтын хаялт ихсэх юм уу багасах

3. Зүрхний минутын эзэлхүүн хэвийн, эсвэл багасах

4. Амьсгал олшрох

5. Судасны лугшилтын даралт нэмэгдэх (диастолын даралт буурах учир)

6. Артерийн даралт буурах

7. Венийн даралт хэвийн, эсвэл буурах

8. Диурез хэвийн, эсвэл бага зэрэг буурах

9. Арьс салстын өнгө цайвар

10. Мөчнүүдийн температур хэвийн зэрэг болно.

Судасны гаралтай артерийн даралт багасах уед хийх эрчимт эмчилгээг доорхи зарчмаар хийнэ.

Даралт бага зэрэг буурсан тохиолдолд наркозыг өнгөц болгох, нугасны сувагт мэдээ алдуулах бодис шахахыг зогсоох, глюокортикоидын дутагдал илрвэл түүнийг өгөх зэргээр шалтгааныг арилгах шаардлагатай.

Харин даралт харьцангуй ихээр буурсан уед доорхи эмчилгээнүүдийн аль нэгийг хэрэглэнэ. Үүнд:

1. Венийн судсанд цус, плазм, цус орлох шингэннийг хийснээр цусны эзэлхүүн нэмэгдэж тэр нь судасны нэмэгдсэн багтаамжтай тохирох болно.

2. Глюкоз, рингерийн 200—400 мл уусмалд 1 мл 01%-ний норадреналин хийж судсанд дуслаар тариад норадреналины үйлчилгээгээр судасны багтаамж багасч цусны хэвийн багтаамжтай тохирно.

3. Артерийн судсанд цус, цус орлох шингэн шахна. Энэ уед цусны эзэлхүүн ихэсч артер ба артериол нь зөөхөн тэр шэхсан хэсэгт л нарийсна.

Эмнэлгийн нөхцөлд дээрх аргуудаас нэгдүгээр аргыг хэрэглэх нь илүү тохиромжтой. Артерийн дэралтыг тогтмол хянаж байх шаардлага гардаг учир хоёрдугаар арга нь тохиромж муутайгаас гадна венийн судсанд норадреналиныг дуслаар удаан хийхэд тромбофлебит, некроз үүсгэх аюултай байдаг.

ШИНГЭН ДУТАГДЛЫН ГАРАЛТАЙ АРТЕРИЙН ДАРАЛТ БАГАСАЛТ. Энэ хэлбэр нь гол төлөв судасны урсалаар эргэлдэх шингэнний хэмжээ багассанаас мэс заслын болон гэмтлийн уед алдсан цусыг гүйцэд нөхөөгүйгээс үүснэ.

Эмнэл зүйн шинж тэмдэг нь доорхи байдлаар илэрнэ.

1. Судасны лугшилт олшрох

2. Амьсгалын тоо олшрох

3. Зүрхний хаялт багасах

4. Судасны лугшилтын даралт багасах (систолын даралт буурсны үр дүнд)

5. Төвийн венийн даралт буурах

6. Арьс салст цайрах

7. Шээс багасах эсвэл бүр үгүй болох зэрэг юм.

Шингэн дутагдлын гаралтай артерийн даралт багасалтын үед доорхи эмчилгээг хийнэ.

1. Венийн судсанд ижил группийн цусыг төвийн венийн даралтыг хэвийн болтол юулэх.

2. Венийн судсанд (цус юулэхээс өмнө) 10%-ийн 10 мл глюконат кальцын уусмал тарих,

Ампул цус бурийн дараа дээрх уусмалаас 5 мл-ийг тарина.

Энэ нь цусан дахь кальцын дутагдлыг арилгаж кали, кальцын тэнцвэрийг тохируулна.

3. Хүчил шүлтийн тэнцвэрийг хэвийн болгох зорилгоор бодисын солилцооны ацидозын үед 4%-ийн содын уусмалыг венийн судсаар цус хийх,

4. Цусан дахь эритроцит, гемоглобин ба гематокритийн хэмжээг ойрын 7 хоногийн турш сайтар хянаж шаардлагатай үед венийн судсаар цус хийх,

5. Венийн судсанд бага молекулын декстран поливинолийг зах хязгаарын цусны эргэлтийг хэвийн болтол тарина.

ЗҮРХ ЗОГСОХ. Цусны эргэлтийн хямралын хамгийн аюултай нь зүрх зогсох юм. Энэ хүндрэлийн гол шалтгаан нь хүчилтөрөгчийн дутагдал, нүүрсхүчлийн хийн хуримтлал, цус алдалтыг нөхөөгүй үе, хордлого, зурхний булчингийн шигдээс, уушгины артерийн эмболи, шок зэрэг болно.

Зүрхний ажиллагаа зогсох нь зүрх агшилтгүй болох, ховдлын жирвэлзлийн хэлбэрээр илэрнэ. Өөрөөр хэлбэл нь зүрхний булчингийн ажиллагаа хэвээр байгаа боловч ховдлын агшилт гэнэт зогсожиг хэлнэ.

Энэ үед арьс салст цайвар цагаан, амьсгал тасалдангуй чичиргээтэй, хүүхэн хараа өргөссөн байна. Зүрх агшилтгүй болохын өмнө гол төлөв судасны лугшилт олшрох, цөөрөх, хэм алдагдах, артерийн даралт буурах, амьсгалын хэм алдагдаж тоо нь өөрчлөгдөх шинж илрэх бөгөөд хүчилтөрөгч дутагдах, судасны лугшилтын хэм урт хугацаагаар алдагдсаны дараа тохиолдоно.

Зүрхний булчингийн ширхгүүдийн эмх замбараагүй агшилтыг ховдлын жирбэлзэл гэнэ. Энэ нь урт хугацаагаар хүчилтөрөгчөөр дутагдах, цахилгаан гэмтэл зэрэг бусад хямралын үед тохиолдоно. Эдгээр хямралаас урьдчилан сэргийлэхийн тулд доорхи арга хэмжээг авна.

1. Хагалгааны өмнөх шинжилгээг сайтар хийж тохиорох бэлтгэлээр хангана.

2. Наркозын үед өвчтөнийг нарийн нягт ажиглана. Артерийн даралт, судасны лугшилт, амьсгал, арьс ба хумсны угны өнгө, хөлс ялгаруулалт, цус алдалт

3. Уушгини агааржилтыг идэвхтэй хийнэ.

4. Эргэлдэх цусны эзэлхүүнийг хэвийн байдалд барина.

Зүрх зогсохыг тухайн үед нь оношлон сэхээн амьдрзуулах ажиллагааг эрт хийх нь амжилтанд хүрэх гол нөхцөл юм. Тархины цусны эргэлт 4—5 минутаас илүү хугацаагаар тасарвал эд эсэд эргэлтгүй өөрчлөлт явагддаг. Хэрэв энэ хүндрэл наркоз, мэс заслын үед тохиолдвол яаралтай ажилбарыг зогсооно.

Хамгийн анхны хойшлуулшгүй арга хэмжээ бол зүрхэнд шууд биш массаж хийх арга юм.

Мөн уушгини хийн солилцоог сайтар сэргээхийн тулд мөгөөрсөн хоолойд гуурс тавьж уушгинд хиймэл агааржилт хийх хэрэгтэй.

Дээрх арга хэмжээний зэрэгцээ зүрхэнд илрэх цусны дутагдлыг арилгахын тул венийн судсанд цус, цус орлох шингэнийг хийнэ. Хэрэв шууд биш массаж үр дүн өгөхгүй бол 5-р хавирганы завсраар хатгалт хийж зүүн ховдлын хөндийд 10%—3 мл глюконат, лактат, хлорт кальцийн уусмалыг физиологийн уусмалаар 2—3 дахин шингэлж тарьж, дараа нь тэр зуугээрээ 0,5—1,0 мл адреналин хийнэ.

Д. ДАРИЙМАА

ҮР АЯНДАА ЗУЛБАСАН ЭМЭГТЭЙН ХОНОГИЙН ШЭЭСНИЙ ПРЕГНАНДИОЛЫН ХЭМЖЭЭ

ЭХ НЯЛХСЫГ ХАМГААЛАХ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН

Үр аяндаа зулбах эмгэг нь эх барихын практикт цөөнгүй тохиолддог бөгөөд эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд муугаар нөлөөлөөд зогсохгүй хүн амын нөхөн есөлтийг бууруулдаг юм.

Зарим эрдэмтний судалгаагаар үр аяндаа зулбах нь нийт жирэмсний 10—15% ДЭХБ-ын 1981 оны мэдээгээр 15—25% хүртэл хувийг зээлж байна.

Энэ эмгэг нь эмэгтэйчүүдийн халдварт ба халдварт бус өвчин, жирэмсний хүндрэл, эх ургийн дархлалын системийн зөрчил, дотоод шүүрлийн булчирхайн өөрчлөлт, удамшлын эмгэг зэрэг олон шалтгаанаас үүсдэг. Эдгээр шалтгаанаас мэдрэл дотоод шүүрлийн тогтолцооны өөрчлөлт зонхилох суурь эзлэх бөгөөд ялангуяа өндгөвчний үйл ажиллагааны дутагдлаас 60—70%, бөөрний дээд булчирхайн гаралтай андроген гормоны ихсэлтээс 30—40% нь үр аяндаа зулбаж байна.

Өндгөвчний үйл ажиллагааг шинжлэхийн тулд прогестроны завсрын бүтээгдэхүүн, прегнандиолыг шээсэнд тодорхойлох аргыг өргөн ашиглаж байна. Ихэнх судлаачид прегнандиолын хэмжээгээр жирэмсний явцыг дүгнэдэг. Прогестроны ялгаралт хэвийн жирэмсний эхний хугацаанд бага зэрэг ихсэж, 18—30 долоо хоногтойгоос эхлэн эрчимтэй нэмэгддэг.

Бид прегнандиолын хэмжээг хоногийн н шээсэнд тодорхойлж үр аяндаа зулбах эмгэгийг оношлох, жирэмсий тавиланг урьдчилан тогтоох боломжийг судлах зорилго тавилаа.

СУДАЛГААНЫ АРГА. Хоногийн шээсэнд прегнандиолын хэмжээг Клоперын аргын Савченкогийн хувилбарыг ашиглан нимгэн үет хроматографаар тодорхойлов,

1. Нимгэн үет ялтас бэлтгэх.

20×20 см шил зүсч сайтар угааж хатаагаад тэгшлүүр дээр байрлуулна. 10,5 гр силикагель (Sigma) авч 15 мл нэрсэн усанд хийж хутгаад 0,3 мм зузаантайгаар тэгш шил дээр тарааж, тасалгааны агаарт загсаан, хатаах шүүгээнд 110°-д 1 цаг болгоно.

2. Гидролиз.

Өвчтөний хоногийн 24 цагийн шээсийг цуглувалж, сайтар холиод 50 мл-ийг авч 5 мл өтгөрүүлсэн давсны хүчил, 0,5 мл 10% формалин, 50 мл бензол хийж эргэх хөргөгчтэй усан халаагуурт 10 мин. буцалгасны дараа хөргөнө. Дараа нь салгах юулүүрт хийж бензолын давх.

рагыг ялган авч, үлдсэн усан үе дээр 25 мл бензол хийж хэдэн минут болгоомжтой холиод, усан үеийг асгаж, бензолын үеийг авч, түрүүчийн бензолын уетэй холиод 30 мл идэмхий натрийн уусмалаар 2 удаа, 30 мл нээрсэн усаар хоёр удаа зайлж, усан үеийг асгаж бензолыг үе дээр 5—7 грамм усгүйжүүлсэн сульфат натри хийнэ. Усгүйжүүлсэн бензолоо бөөрөнхий ёроолтой колбонд хийж, усан хаалагуурт 50°C болгоомжтой халааж, бензол ширгэхэд колбын ёроолд цагаан тундас үлдээнэ.

3. ХРОМАТОГРАФИ.

Гаргаж авсан тундсаа 0,1 мл цэвэрлэсэн хлорформд уусгаж аваад бэлтгэсэн силикагелийн үений нэг ирмэгээс 2 см зайд дусаах ба зэргэлдээ нь 2 см зйтай 30 мкг стандарт дусаана. Энэ ялтсаа дотроо хлорформ, ацетон хоёрыг 8:2 харьцаатайгаар авсан 100 мл уусгагчтай хроматографийн тэвшинд хийж 40 минут буюу уусгагчаас дээш 15—16 см хүртэл хөөмөгц эхлээд тасалгааны агаарт ууршуулж дараа нь 50—60°C-ийн хатаах шүүгээнд уусгагчийн үнэрийг гартал байлгана. Дээрх хроматографийн тэвшинд дахин хийж хатаагаад дараа нь 100 мл % этанолын уусмалтай хроматографийн тэвшинд 40 минут давтан хөөж тасалгааны агаарт уусгагчийг дэгдтэл байлгана.

4. ЯЛТСАА ИЛРҮҮЛЭХ.

Хатаасан ялтсаа нээрсэн усаар шүршихэд прогнандиол байгаа хэсэгт нороогүй хуурай цагаан толбо үлдэнэ.

5. ӨНГӨТ УРВАЛ

Үүссэн цагаан толбыг хусаж аваад хуруу шилэнд хийж дээрээс нь 3 мл өтгөрүүлсэн хүхрийн хүчил хийхэд 25—30 минутын дараа шаравтар өнгө үүснэ. Үүнийг спектрофотометрийн 430 нм долгионы урт дээр цэвэр силикагелийн эсрэг хэмжинэ.

Гарсан хариуг доорхи томъёогоор бодно.

$$X = \frac{E_{\text{сорил}}}{E_{\text{стандарт}}} \cdot d_{\text{стандарт}}$$

E—спектрофотометрийн үзүүлэлт.

d—гель дээр дусаасан стандартын хэмжээ.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН. Судалгаанд үр аяндаа зулбасан 100, хэвийн жирэмсэн 50 эмэгтэйчүүдэд шинжилгээ хийж харьцуулан судлав. Судалгаанд хамрагдагсад нь 26—35 насны 4—28 долоо хоногийн хугацаатай жирэмсэн байсан ба шалтгаан нь тодорхой үр аяндаа зулбасан тохиолдлыг оруулсангүй. Үр аяндаа зулбалт ба ажил мэргэжлийн хооронд онц холбогдол ажиглагдсангүй. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн өгүүлэмжээс үзэхэд 23%-д нь сарын тэмдгийн мөчлөг, хугацаа, хэмжээнд ямар нэг өөрчлөлт байв.

Мөн эдгээр эмэгтэйчүүдийн 50%-д үүнээс өмнө хэвийн жирэмсэлж төрсний дараа, 38%-д үр аяндаа зулбасны дараа, 9%-д үр хөндүүлсний дараа үр зулбасан байна.

Хүснэгт 1

Хэвийн жирэмсэн эмэгтэйчүүдийн хоногийн шээний прогнандиолын хэмжээ

| Судлаачид | Прогнандиолын хэмжээ мг. 24 цаг | | | |
|---|---------------------------------|-----------------------|------------------------|--------------------------|
| | И.С. Розовский | Sneurtar | klopper | Бидний судалгаагаар |
| Жирэмсний хугацаа | | | | |
| 42 долоо хоног хүртэл 12—28 долоо хоног хүртэл | 5,8—8,3 11—26,8 | 8,2—10,7 11,4—31,7 | 6,08—10,5 11,9—30,6 | 6,21—10,25 10,4—29,60 |

Хүснэгт 1-ээс үзэхэд хэвийн жирэмсэн үед хоногийн шээсээр ялгарах прегнандиолын хэмжээ 12 долоо хоног хүртэл $6,21 \pm 10,25$ мг 24 цаг, 12—28 долоо хоног хүртэл $10,4 \pm 29,60$ мг 24 цаг байлаа. Энэ узүүлэлтийг ЗХУ болон гадаадын судлаачдын судалгаатай харьцуулахад онцын зөрөөгүй байлаа.

Хүснэгт 2

Үр аяндаа зулбасан ба хэвийн жирэмсэн эмэгтэйчүүдийн хоногийн шээсний прегнандиолын хэмжээ

| Судалгааны бүлэг | Судалсан хүний тоо | Прегнандиолын хэмжээ (мг. 24 цаг) | P |
|--|---------------------------|---|----------------------|
| I бүлэг. Хэвийн жирэмсэн 12 долоо хоног хүртэл 13—18 долоо хоног 18 долоо хоногоос дээш | 28 16 6 | $6,27 \pm 1,52$ $14,02 \pm 4,66$ $23,35 \pm 6,25$ | |
| II бүлэг. Үр аяндаа зулбасан 12 д/х хүртэл 13—18 долоо хоног 18 д/х дээш | 51(24) 32(12) 17(8) | $3,14 \pm 1,13$ $6,58 \pm 1,25$ $12,40 \pm 3,8$ | 0,05 0,01 0,01 |

Хүснэгт 2-оос үзэхэд жирэмсний 12 долоо хоног хүртэл хугацаанд үр аяндаа зулбасан 24 эмэгтэйд шээсээр ялгарах прегнандиолын хэмжээ нь $3,14 \pm 1,13$ мг. 24 цаг байв. Энэ нь мөн хугацааны 28 хэвийн жирэмсэн эмэгтэйн шээсэнд тодорхойлсон прегнандиолын дундаж хэмжээтэй харьцуулахад статистикийн үнэн магадтай ($P < 0,05$) бага байв.

Хэвийн жирэмсэн цааш үргэлжлэхэд шээсээр ялгарах прегнандиолын хэмжээ ихсэж 13—18 долоо хоног болоход $14,02 \pm 4,66$ мг 24 цаг, 18 долоо хоногоос дээш болоход $23,35 \pm 6,25$ мг. 24 цаг хүртэл ихсэж байлаа.

Жирэмсний хожуу хугацаанд үр аяндаа зулбасан эмэгтэйчүүдэд прегнандиолын ихсэлт ажиглагдсангүй. 13—18 долоо хоногтой жирэмсний хугацаанд үр аяндаа зулбасан 32 тохиолдлоос 12-т нь шээсээр ялгарах прегнандиолын хэмжээ $6,55 \pm 1,25$ мг 24 цаг, 18 долоо хоногоос дээш хугацаанд үр аяндаа зулбасан 17 хүнээс 8-д прегнандиолын хэмжээ $12,40 \pm 3,8$ мг. 24 цаг тус тодорхойлогдсон нь мөн хугацааны хэвийн жирэмсэн эмэгтэйчүүдтэй харьцуулахад $P < 0,01$ -ээр үнэн магадтай бага байв.

Судалгааны эцэст гормон шинжилгээ хийсний үр дүнд шалтгаан нь тодорхойгүй үр аяндаа зулбасан эмэгтэйчүүдийн 44 хүртэл хувьд прегнандиолын дутагдах эмгэг илэрч байгаа нь харагдлаа.

ДҮГНЭЛТ. Хэвийн жирэмсний үед хоногийн шээсний прегнандиолын хэмжээ байнга ихсэж байхад үр аяндаа зулбасан, зулбаж эхэлж байгаа үед хоногийн шээсний прегнандиолын хэмжээ буурч байна.

ХАЙРСТ ҮЛДИЙГ ТОСОН НУУРЫН УС ШАВРААР ЭМЧИЛЖ БАЙГАА НЬ

АРЬС ӨНГӨНИЙ ЭМГЭГ СУДЛАЛЫН ТӨВ

Хайрст үлд (псориаз) нь арьсны өвчнүүдийн дотор 5,2%-ийг эзэлдэг архаг явцтай, олон удаа дахидааг, гол төлөв залуу насанд тохиолдох арьсны өвчин бөгөөд жам шалтгаан нь одоо болтол бурэн нотлогдоогүй байна.

Хайрст үлд нь хурцаар эхлэх бөгөөд эхлээд хөл гарч ялангуяа тохой, өвдөгний арьсанд жижиг, улаан өнгийн, бичгийн зүүний толтойн хиртэйгээс тарианы үр шиг хэмжээтэй гүвдруу гарах ба түргэн хугацаанд мөнгөлөг цайвар хайрсаар хучигдана.

Гүвдруу нь аажмаар томорч, зарим газраар хоорондоо нийлэхээс гадна тухайн үед зөвхөн өвдөг, тохойн арьсанд байрлаад удаан хугацаанд өөрчлөлтгүй байдаг байна. Цөөнгүй тохиолдолд тууралт нь толгойн үс, хэвлэлий, ууц нурууны арьсаар тархан байрлаж, дугуй хэлбэртэй болж удах тутмаа нэвчдэс нь ихэсч барьж үзэхэд арьс зузаарсан байна.

Хайрст үлдийн тууралтыг 3 үе шат болгон хуваадаг.

1-рт ХҮРЦ-ДАВШИХ ҮЕ. Энэ үед шинээр жижиг, тод улаан өнгийн гүвдруунууд гаран богино хугацаанд бүх арьсаар туурч, захаараа гуужилтгүй байх ба ялимгүй загатнаад маажсан арьсанд буюу тариа хийсэн хэсэгт жижиг гүвдруу гардаг байна.

2-рт. ЗОГСОНГИ ҮЕ. Энэ үед шинээр жижиг гүвдруу гардаггүй.

Хуучин гарсан гүвдруу нь цайвар өнгөтэй болж, харин гүвдруун дээр 1-р үеийг бодоход нилээд хайрсаар хучигдаж өнгө нь бүдгэрч ирийн.

3-рт. ЭДГЭРЭХ ҮЕ. Энэ үед туурсан гүвдруунууд нь хайрсгүй болж, аажмаар уусгагдан арилах бөгөөд гэхдээ өвдөг, тохойн арьсанд цайвар өнгийн гүвдруу үлдэж болно.

Хайрст үлдийн гүвдруу нь толгойн хүйхны арьсанд байрласан үе-дээ үсийг гэмтээж унагадаггүй байна.

Өвчлөл нь гол төлөв намар, өвөл буюу хавар зуны улиралд хурцдаж дахидааг учир өрлийн ба зуны гэж хоёр хэлбэрээр хувааж үздэг.

Хайрст үлдийн гүвдрууг хусаж үзэхэд эхлээд хайрс нь тодорч дараа нь үргэлжлүүлэн хусахад хайрсын сүүлийн хэсэг унаж, сүүлдээ жижиг цэг шиг хэлбэрийн цус харвалт илэрдэг бөгөөд энэ нь бусад өвчкөөс ялгагдах гол шинж тэмдэг болдог төдийгүй оношилгоонд чухал ач холбогдолтой юм.

Энэ өвчнийг сайн эмчлэхгүй бол үе мөчийг өвчлүүлж улмаар бүх арьсыг улайлгах хундрэлтэй болгодог.

ЭМЧИЛГЭЭ. Эмийн бус эмчилгээг амбулаториор голлон, больницийн нөхцөлд бол эмийн эмчилгээтэй хавсран хэрэглэж байгаа нь нилээд үр дүнтэй болж байна. Ер нь арьсны архаг өвчтэй хүмүүсийг Тосон нуурын ус, шавраар эмчлэх явдлыг 1960-аад оноос проф. Ч. Долгор, Т. Ядамсүрэн нар анх санаачилж шаврыг зөөвөрлөн больницидоо эмчилгээ хийж, 1977 оноос Эрүүлийг хамгаалах Яамны шийдвэрээр улирлын чанартай арьсны сувиллыг Аварга тосонд байгуулсан билээ.

Эмийн бус эмчилгээнд бид Тосон нуурын ус, шаврыг сүүлийн 4—5 жилд төрөл бурийн арьсны өвчин, ялангуяа хайрст үлдийг эмч-

лэхэд хэрэглэсээр ирэв. Үүнд өдөр бүр нуурт 3—20 минутаар 2—4 удаа орох ба шавраа +37—42°C халааж 15—20 минут уг өвчлөлтэй арьсанд 2—4 удаа тавихад гүвдруүний хайрс нь дундаасаа арилж, өнгө нь улам цайвар болж зарим жижиг гүвдруү арилах, нэвчдэс нимгэрэх зэргээр эдгэрч эхэлдэг бөгөөд цаашид нууртаа 8—12 удаа орж мөн шавраа 6—10 удаа тавихад бүх гарсан гүвдруү ба хөрзөнги нь шимэгдэн сорогдож, хайрс арилан эдгэрдэг байна. Харин хөрзөнги ихтэй бол нилээд удаж 2—3 дахь жилдээ сайжирдаг.

Гэвч гүвдруү нь шимэгдэж, хайрс нь арилан эдгэрэх нь хүн бүрт харилцан адилгүй байдаг байна. Зарим тохиолдолд зөвхөн нуурын содтой усанд 2—3 удаа ороход тууралт арилдаг.

Бид 1977—1981 онд бүгд 600 гаруй өвчтөн эмчилснээс хайрст үлд өвчтэй 300-аад өвчтөнг Тосон нуурын ус шзвраар дээр заасан аргаар эмчлэхэд клиникин эдгэрэлт 76,2—32% болж байгаа нь бусад орныхтой (ЗХУ-ын Алтайн хязгаарын „Большое Яровое“ нуур, ЗСБН Автономийн Буриадын „Рашаан“ Болгарын „Сак“ нуур зэрэг) харьцуулахад илүү үр дүнтэй байгаа болно.

Иймд мэргэжлийн эмчийн зөвлөлгөөнөөр арьсны архаг өвчтэй ба ялангуяа хайрст үлд өвчтэй хүмүүсийг энэ нуурын ус, шавраар эмчлэх нь өвчиний дахилтыг эрс цөөрүүлж улмаар хөдөлмөрийн чадвар түр алдалтыг багасгах сайн нөлөөтэй байна.

Р, ДАВААСУРЭН

БӨӨРНИЙ АРХАГ ДУТАГДАЛТАЙ ХҮМҮҮСИЙН ХООЛНЫ ЭМЧИЛГЭЭ

УЛСЫН КЛИНИКИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

Бөөрний дутагдалтай хүний хоолыг цусан дахь шээгийн хэмжээнд тохируулан уураг багатай байхаар бодож тохируулна. Уураг багатай хоол нь цусны үлдэгдэл азот, шээгийн хэмжээг багасгадаг.

Бөөрний архаг дутагдлын үе дэх хоол үнд нь дорхи шаардлагыг хангасан байх хэрэгтэй. Үүнд:

1. Уураг багатай, шүүтэн (амин) хүчил ихтэй байх.
2. Нүүрс ус, тослогийн зүйл хангалттай орсон илчлэг нь 2000—2500 кал байх.

3. Ногоо, жимс, жимсний шүүс их орсон байх.
4. Хүний хоол идэх дур сонирхлыг татсан өнгө үзэмжтэй байх.

Бөөрний архаг дутагдлыг үе болгонд тохирсон онцлог чанартай хоолыг хэрэглэх нь зүйтэй. 1 үед хоолны уураг 90—100 гр байх ба 7 хоногт 1—2 өдөрт (нэг өдөрт нэг төрлийн хоолыг дагнах) уураг багатай, илчлэг ихтэй хоол үнд идэж уух, arterийн даралт өндөр бол хлорт натрийг 3—4 гр-аар багасгана. Хэрэв ийм хоол үнданд сайжрал олохгүй бол уургийг 1 кг биесийн жинл хоногт 1 гр-аар багасгана.

II—A үед уургийг 1 кг биесийн жинд 1 гр-аас хэтрүүлж болохгүй. Ачаалал багатай, илчлэг ихтэй, уураг багатай хоолыг 7 хоногт 2—3 өдөр хэрэглэнэ.

II—B үед илчлэг ихтэй, уураг багатай хоолыг тогтмол хэрэглэнэ. Ногоо, жимсний зүйл их хэрэглэх нь бие махбодод витамин хуралдааны 68

хад тусалж, эрдсийн солилцоснд ёөрчлөлт бага өгнө. Биеийн шингэний тэнцлийг сайн барих нь чухал. Хүн хсногт уусан шингэнийхээ 80—85 дсошгүй хувийг шээсээр гаргаж байвал шингэний тэнцлийг барьж байна гэж үзэж болно. Хоногт 1,5—2 литрээс илүү шингэн ууж болохгүй.

Бөөрний архаг дутагдалтгүй, хагангүй, даргалт хээийн, зүрх судасны ажиллагааны дутагдалгүй, мөн шингэний тэнцлийг барьж байгаа хүн хоногт бөөрний архаг дутагдлын I үед давсыг 4—6 гр, II үед 6—8 гр, III үед 8—10 гр тус тус хэрэглэнэ. Давс нь хоолны амтыг засч, бөөрөөр азотын үлдэгдэл грахыг ихэсгэдэг тул давсыг хэт хорих нь муу.

Хоолны жорыг 7 хоногоор өдөрт 40 граммаас илүүгүй уурагтай гаргасан байдал

Даваа гариг.

7.00 цаг.

| | |
|--------------|---------|
| Цай (кофе) | 200 гр. |
| цөцгийн тоос | 50 гр. |
| сахар | 15 гр. |
| талх | 50 гр. |
| цөцгийн тос | 15 гр. |
| зөгийн бал | 30 гр. |

10.00 цаг.

| | |
|-------------|---------|
| Алим | 150 гр. |
| талх | 50 гр. |
| цөцгийн тос | 15 гр. |

12.00 цаг

I хоол: Хүүхдийн будаатай шөл.

| | |
|----------------|--------|
| хүүхдийн будаа | 10 гр. |
| ноггоо | 20 гр. |
| цөцгийн тос | 5 гр. |

II хоол:

| | |
|--------------|---------|
| чанасан тэмс | 200 гр. |
| цөцгийн тос | 10 гр. |
| гахайн мах | 50 гр. |
| тэмс | 20 гр. |
| өндөг | 10 гр. |
| сонгино | 10 гр. |
| улаан лооль | 80 гр. |
| ургамлын тос | 10 гр. |

III хоол:

| | |
|----------------|----------------------------|
| байцааны салат | 50 гр |
| байцаа | 2 гр (бага зэрэг цуу эсвэл |
| сахар | нимбэг нэмж амтална) |

15.00 цаг.

| | |
|-------------|--------|
| цай | 200 гр |
| сүү | 50 гр |
| сахар | 25 гр |
| талх | 50 гр |
| цөцгийн тос | 10 гр |

17. 00 цаг.

| | |
|-------------|------------|
| Хайрсан бин | 60 гр |
| гурыл | 70 гр |
| сүү | 3 халбага. |
| ус | |

| | |
|-----------------------------|---|
| өндөг | 22 гр |
| сахар | 10 гр |
| жимс | 50 гр |
| ургамлын тос | 15 гр |
| цай | 250 гр |
| Нэг өдрийн бүх дүн: | |
| Уураг | 40—84 гр. |
| өөх тос | 90,8 гр |
| чихэр | 320,7 |
| илчлэг | 2234 кал |
| натри | 918 мг |
| кали | 4134 мг |
| Мягмар гариг: | |
| 7.00 цаг. | |
| цай (какао) | 200 гр |
| цөцгий | 50 гр |
| сахар | 15 гр |
| тэлх | 50 гр |
| цөцгийн тос | 15 гр |
| жимсний чанамал | 30 гр |
| 10.00 цаг | |
| жимс | 100 гр |
| талх (исгэсэн гурилан боов) | 30 гр |
| цөцгийн тос | 10 гр |
| 12.00 цаг | |
| I. Хоол: | |
| Ясны шөл | 200 гр |
| ногоо | 20 гр |
| өндөг | 10 гр |
| сонгино | 10 гр |
| II хоол: | |
| үхрийн мах | 50 гр |
| цөцгийн тос | 10 гр |
| гурит | 2 гр |
| лууван | 100 гр (хачир нь тэмс 200 гр, масло 10 гр) |
| III хоол: Царцаамал. | |
| Ус | 100 гр |
| цөцгийн тос | 10 гр |
| сахар | 15 гр |
| царцаах бодис | 10 гр |
| жимсний шүүс | 10 гр |
| 15.00 цаг | |
| цай | 250 гр |
| сахар | 15 гр |
| тэлх | 50 гр |
| цөцгийн тос | 15 гр |
| жимсний чанамал | 30 гр |
| 17.00 цаг | |
| Хайрсан тэмс: | |
| тэмс | 200 гр |
| цөцгийн тос | 10 гр |
| цөцгий | 10 гр |
| өндөг | 40 гр |
| ургамлын тос | 10 гр |

| | | |
|----------|--------|--------|
| дагавар: | алим | 100 гр |
| | компот | 50 гр |
| | сахар | 10 гр |

Лхагва гариг.

7.00 цаг.

| | |
|-----------------|--------|
| цай | 200 гр |
| сахар | 15 гр |
| сүү | 50 гр |
| талх | 50 гр |
| цөцгийн тос | 15 гр |
| жимсний чанамал | 30 гр |

10.00 цаг.

| | |
|-------------|------------------------------|
| жимс | 150 гр (эсвэл компот 50. гр) |
| талх | 50 гр |
| цөцгийн тос | 10 гр |
| сахар | 10 гр |

12.00 цаг

I хоол: Ногоотой шөл.

| | |
|-------------|--------|
| мак | 50 гр |
| төмс | 100 гр |
| байцаа | 50 гр |
| лууван | 25 гр |
| сонгино | 10 гр |
| цөцгийн тос | 15 гр |
| ус | 300 гр |

II. хоол: Гоймонтой хуурга.

| | |
|-------------|--------|
| гоймон | 100 гр |
| цөцгийн тос | 15 гр |
| сонгино | 10 гр |

III хоол:

| | |
|--------|-------|
| компот | 50 гр |
|--------|-------|

15. 00 цаг.

| | |
|-------------|--------|
| цай | 200 гр |
| сахар | 10 гр |
| талх | 50 гр |
| цөцгийн тос | 10 гр |

17. 00 цаг. Шарсан өндөг

| | |
|-------------|-------------------------------------|
| төмс | 100 гр |
| цөцгийн тос | 10 гр |
| өндөг | 50 гр (дагавар нь цай эсвэл компот) |

Пүрэв гариг.

7. 00 цаг.

| | |
|-----------------|--------|
| цай | 200 гр |
| сүү | 50 гр |
| талх | 50 гр |
| цөцгийн тос | 15 гр |
| жимсний чанамал | 30 гр |

10. 00 цаг.

| | |
|-------------|--------|
| талх | 50 гр |
| цөцгийн тос | 15 гр |
| улаан лооль | 50 гр |
| цай | 200 гр |

12. 00 цаг. I хоол: Шөл

| | |
|----------|--------|
| Ясны шөл | 300 гр |
| байцаа | 50 гр |
| манжин | 25 гр |
| лууван | 25 гр |

| | |
|-----------------------------|-----------------------------|
| төмс | 100 гр |
| нимбэгний хүчил | 1 гр |
| цөцгийн тос | 15 гр |
| сахар | 5 гр |
| II хоол: Хуушуур. | |
| мах | 50 гр |
| гурил | 100 гр |
| сонгино | 5 гр |
| ургамлын тос | |
| III хоол: | |
| компот эсвэл бяллуу (торт) | 200 гр |
| 15. 00 цагт. | |
| 17. 00 цаг. | |
| Шарсан төмс: | |
| төмс | 200 гр |
| масло | 30 гр |
| сонгино | 5 гр |
| Баасан гариг. | |
| 7. 00 цаг. | |
| сүү | 200 гр |
| талх | 50 гр |
| цөцгийн тос | 15 гр |
| сахар | 20 гр |
| 10. 00 цаг. | |
| талх | 50 гр |
| масло | 10 гр |
| жимсний чанамал | 30 гр |
| цай | 200 гр |
| сахар | 20 гр |
| 12. 00 цаг. | |
| I хоол: Гурилтай шөл | |
| мах | 50 гр |
| гурил | 100 гр |
| төмс | 50 гр |
| сонгино | 5 гр |
| ус | 300 гр |
| II хоол: Пүнтүүзтэй хуурга. | |
| пүнтүүз | 100 гр |
| байцаа | 50 гр |
| сонгино | 5 гр |
| цөцгийн тос | 30 гр |
| цай | 200 гр |
| печень | 50 гр |
| III хоол: | |
| компот | |
| 17. 00 цаг. | |
| Сүүтэй будаа | |
| сүү | 100 гр |
| цагаан будаа | 100 гр |
| цөцгийн тос | 15 гр |
| Бямба гариг | |
| 7. 00 цаг. | |
| цай | 200 гр |
| талх | 50 гр |
| цөцгийн тос | 15 гр. варень 30 гр. |
| 10. 00 цаг. | |
| ногго | 200 гр (есвэл жимсний шүүс) |

| | |
|--|-----------------------|
| 12. 00 цаг. I хоол: | |
| Банштай шөл. | |
| гурил | 100 гр |
| мах | 50 гр |
| байцаа | 25 гр |
| лууван | 25 гр |
| ясны шөл | 200 гр |
| сонгино | 10 гр |
| 15. 00 цаг. | |
| цай | 200 гр |
| бялдуу (торт) | 50 гр |
| 17. 00 цаг. | |
| шарсан төмс | 200 гр |
| төмс | 30 гр |
| ургамлын тос | 200 гр (эсвэл цай) |
| компот | |
| Ням гариг. | |
| 7. 00 цаг. | |
| сүүтэй цай | |
| сүү | 50 гр |
| цай | 200 гр |
| талх | 50 гр |
| цөцгийн тос | 15 гр |
| жимсний чанамал | 30 гр |
| 10. 00 цаг. | |
| байцаа буюу өргөст хэм- хийн салат. | |
| 12. 00 цаг. Буузтай шөл. | |
| ясны шөл | 200 гр |
| бууз: мах | 50 гр |
| гурил | 100 гр |
| байцаа | 25 гр |
| лууван | 25 гр |
| сонгино | 10 гр |
| 15. 00 цаг. | |
| Алим | 100 гр (эсвэл компот) |
| 17. 00 цаг. | |
| пүнтүүз | 200 гр |
| цөцгийн тос | 30 гр |
| сонгино | 10 гр |
| байцаа | 25 гр |
| лууван | 25 гр |
| тараг | 100 гр |

Ашигласан хэвлэл

- | | |
|---|------|
| 1. А. П. Пелещука. Практическая нефрология | 1974 |
| 2. Е.М. Траеев. Основы нефрологии I, II том | 1972 |
| 3. Г. Мамодранова Н. Попова. Болезнь почек | 1973 |

Г. В. АЛФИМОВА, С. ЦЭЦЭГМАА

ЭМИЙН САНГИЙН ЖОРОНД ТОХИОЛДОЖ БҮЙ ЗАРИМ ШИНГЭН ЭМИЙН ХЭЛБЭРТ ХИМИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ТУХАЙ

Анагаах ухааны дээд сургууль

Жилээс жилд эмийн сангийн жоронд фармацологийн өндөр идэвхт хам үйлдэл бүхий шинэ бэлдмэлүүд өргөн нэвтэрч байгаа билээ.

Түүнчлэн сүүлийн жилүүдэд олон найрлага бүхий эмийн хэлбэрийн эмийн сангийн жоронд эзлэх хувийн жин байнга өссөөр байгаа юм. Тэдгээрийн дотор дараахь найрлага бүхий эмийн хэлбэр ихээхэн тохиолдож байна. Үүнд:

Эмийн хэлбэр № 1: Калийн хлорид 0,6

Кальцийн хлорид 0,2

Глюкоза 25,0

Тарилгын ус 500,0 хүртэл

Эмийн хэлбэр № 2: Дицайны уусмал 0,15%—100,0

Новокайн 4,0

Эдгээр эмийн хэлбэрүүдийн чанарын ба тооны тодорхойлолтыг дараахь байдлаар хийж болох юм.

ЭМИЙН ХЭЛБЭР № 1

1. Таних урвал:

а) 4—5 дусал шинжилж буй уусмал дээр 2—3 дусал сулруулсан цууны хүчил, 1—2 дусал 5%-ийн натрийн кобальтинитритийн уусмал хийхэд шар өнгийн талст тундас үүснэ. (калий) [1]

б) 3—4 дусал шинжилж буй уусмал дээр 0,5 мл сулруулсан цууны хүчил, 3—4 дусал 4%-ийн аммонийн оксалатын уусмал хийхэд цагаан тундас үүснэ. (кальций) [1, 2]

в) шинжилж буй уусмалын 2—3 дусал дээр 1—2 дусал азотын хүчил, 2—3 дусал 2%-ийн мөнгөний нитратын уусмал хийхэд аммиакийн уусмалд уусдаг цагаан тундас үүснэ. (хлорид ион) [1, 2]

г) 0,5 мл шинжилж буй уусмал дээр 1—2 мл фелингийн урвалж хийж халаахад улаан өнгийн тундас үүснэ. (глюкоза) [1]

II. Тооны тодорхойлолт:

1. Кальцийн хлорид: 10 мл шинжилж буй эмийн хэлбэрээс авч 3 мл аммиакийн буфер хийж 0,01 мол трилон Б-ийн уусмалаар хөх ягаан өнгө үүстэл титрлэнэ (индикатор харавтар-хөх).

1 мл 0,01 мол трилон Б-ийн уусмал 0,00219 г кальцийн хлоридтай тэнцэнэ.

2. Калийн хлорид: Шинжилж буй уусмалын 5 мл дээр 2 мл сулруулсан цууны хүчил, 5 мл 0,1 н. мөнгөний нитратын уусмал, 6—8 дусал темөр аммонийн цөр хийж 0,1 н. аммонийн роданидын уусмалаар сулавтар ягаан өнгө үүстэл титрлэнэ.

1 мл 0,1 н. мөнгөний нитратын уусмал 0,00745 г калийн хлоридтай тэнцүү.

Калийн хлоридын хэмжээг дараахь томьёогоор бодож олно.

$$X = \frac{Y_1 K_1 - Y_2 K_2 - \frac{Y_3 \cdot K_2}{10} \cdot T \cdot P}{a}$$

Үүнд:

X—калийн хлоридын хэмжээ, г

Y₁—0,1 н. мөнгөний нитратын уусмалын хэмжээ, мл

K₁—0,1 н. Мөнгөний нитратын уусмалын засварын коэффициент

Y₂—0,1 н. аммонийн роданидын уусмалын хэмжээ, мл

K₂—0,1 н. аммонийн роданидын уусмалын засварын коэффициент

Y₃—0,01 мол трилон Б-ийн уусмалын хэмжээ, мл

K₃—0,01 мол трилон Б-ийн уусмалын засварын коэффициент

P—шинжилж буй уусмалын ерөнхий хэмжээ, мл

a—шинжилэхээр авсан уусмалын ерөнхий хэмжээ, мл

3. Глюкозын тодорхойлолт:

1 мл шинжилж буй уусмал дээр 8 мл 0,1 н. иодын уусмал, 1 мл 10%-ийн идэмхий натрийн уусмал хийж харанхуй газарт тавьсны дараа 2—3 мл сулруулсан давсны хүчил нэмж, ялгаран гарч буй иодыг 0,1 н. натрийн тиосульфатын уусмалаар цардуул индикатор хийж титрлээнэ. Хяналтын туршилт зэрэгцуулэн хийнэ.

1 мл 0,1 н. иодын уусмал 0,0099 г глюкозтай тэнцэнэ.

ЭМИЙН ХЭЛБЭР № 2

I. Таних урвал:

а) 0,5 мл шинжилж буй эмийн хэлбэр дээр тус бүр 3 дусал сулруулсан цууны хүчил ба 0,1 мол натрийн нитритийн уусмал хийж сэргээрнэ. Холимгийг 3 мл шинэ бэлтгэсэн В-нафтолын уусмал руу хийхэд цагаан тундас үүснэ. (новокайн) [1, 2]

б) Шинжилж буй эмийн хэлбэрийн 0,5 мл дээр 2—3 дусал 25%-ийн аммонийн роданидын уусмал хийхэд цагаан өнгийн тундас үүснэ. (дикаин) [1, 2]

II. Тооны тодорхойлолт:

Новокайн ба дикаин гидрохлоридуудын нийлбэрээр тодорхойлох:

Шинжилж буй уусмалаас 3 мл авч дээр нь 8—10 дусал калийн хроматын уусмал хийгээд 0,1 н. мөнгөний нитратын уусмалаар улаан шаргал өнгө үүстэл титрлэнэ.

1 мл 0,1 н. мөнгөний нитратын уусмал 0,02738 г новокайн ба дикаин гидрохлоридуудын нийлбэртэй тэнцүү.

Тооцог дараахь томьёогоор бодож олно:

$$X = \frac{Y \cdot K \cdot T \cdot P}{a}$$

X—новокайн ба дикаин гидрохлоридуудын нийлбэрийн хэмжээ, г
Y—0,1 н. мөнгөний нитратын уусмалын хэмжээ, мл

K—0,1 н. мөнгөний нитратын уусмалын засварын коэффициент

P—шинжилж буй уусмалын ерөнхий хэмжээ, мл

a—шинжилэхээр авсан уусмалын хэмжээ, мл

Эмийн сангийн нөхцөлд энэ аргуудаар дээрх эмийн хэлбэрт чанарын ба тооны шинжилгээ хийх бүрэн бололцоотой юм.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Государственная фармакопея СССР X издания. М. 1968, 334, 382, 478.
2. М. Н. Бушкова, Г. А. Вайсман и др. Анализ лекарств в условиях аптеки, Киев, 1975, с. с. 145, 167, 245.

ГЯЛТАНГИЙН ГАДУУРХИ КЕСАР ЗУСЛЭГ ХИЙХ АРГАЧЛАЛ

УЛСЫН НЭГДСЭН ТУСГАЙ ЭМНЭЛЭГ

Хэвлийгээр хийдэг кесар зүслэг нь эх барихын практикт чухал байр эзэлнэ. Гадаадын хэвлэлд бичсэнээр хэвлийн гялтанг нээж хийх кесар зүслэг нь дунджаар 16—17% тохиолдож сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай байна. Кесар зүслэгийн улмаас эхийн эндэгдэл 0,21—3,9%, мэс заслын дараах хүндрэл 5—42%, нярайн эндэгдэл 1,9—11,8% байна. Эдгээр хүндрэл нь мэс засал оройтох, ураг гэмтэх, төрлөгийн зэм халдвартлах зэрэг шалтгаанаас үүснэ. Хэвлийн гялтанг нээж хийсэн кесар зүслэгийн дараа антибистик хэрэглэсээр байхад ч халдварт авч даамжирх тохиолдол цөөнгүй гардаг учир халдвараас хамгаалах арга хэмжээг эртийн эрэлхийлсэн боловч төдийлөн ур дунд хүрээгүй байна.

Эрдэмтэд хэвлийн гялтанг нээхгүйгээр гялтангийн гадуурхи кесар зүслэг хийж байсан боловч цус алдах, ураг давсаг гэмтэх зэрэгээс болж уул мэс заслыг хийхээ больсон байна. Энэ нь тэр үед мэс заслын арга барил техник дутагдалтай байсантай холбоотой байж болох юм гэж бичиж байна.

1972 оноос БНБАУ-д Е. Н. Морозов 1976 оноос ЗХУ-д Е. А. Чернуха нар хэвлийн гялтангийн гадуурхи кесар зүслэгийг умайн доод хэсгээр амжилттай хийж байна.

Манай улсад 1980 оны сүүлчээс эхлэн энэхүү мэс заслыг Улаанбаатар хотын 3-р амаржих газар амжилттай хийж байгаа нь эх барихын практикт чухал ач холбогдолтой юм.

Гялтангийн гадуурхи кесар зүслэг гэдэг нь хэвлийн гялтан хальсыг цоолохгүйгээр ураг авах мэс заслыг хэлнэ. Уул мэс заслыг ургийг төрөх замаар гаргах боломжгүй үед төрсний дараа аливаа халдвар цааш дамжихааргүй нөхцөлд хийнэ.

Хэвлийн гялтангийн гадуурхи кесар зүслэгийг хэвлийн гялтанг нээж хийх кесар зүслэгийн нэгэн адил ерөнхий заалт нөхцөлийг харгалзан хийнэ. Харин умайн урагдсан, ихэс түрүүлсэн, ихэс ховхорч кувелерийн умай болсон, умай дайврын хавдартай, үрийн хоолойг боох шаардлагатай умайн доод хэсгийн судас хэт өргөссөн, ургийн толгой аарцгийн доод хэсэгт баттай суусан зэрэг тохиолдолд уг мэс засал хийхийг хориглоно. Уг мэс заслыг төлөвлөгөөт байдлаар хийхийн өмнө урд орой нь хөнгөн чанаарын хоол шөл, цагаан будаа, чихэртэй цай нойрсуулах тайвшруулах эм тус тус өгнө. Мэс заслыг яаралтай хийх шаардлага гарвал хodoодыг угааж, цэвэрлэн бургуй тавихын хамт шээсийг заавал бургуйгаар авна. Мэс заслыг ерөнхий мэдээ алдуулалтаар хийнэ. Е. Н. Морозов мэс ажилбарын явцыг 4 үе болгон хуваасан байна.

1-р үе. Хэвлийн ханыг гялтан хальс хүртэл нээх

Төрөх эхийг мэс заслийн байдалд Трендленбургийн байрлалд байлган мэс засалч эхийн зүүн талд зогсоно. Умдаг хэвлийн нугаалаасны дагуу Пфенненштилийн аргаар 15—16 см орчим хөндлөн зүслэгийг шулуун булчин хүртэл хийнэ. Булчинг гол шугамаар хүрц мөхөн аргаар салган баруун талын шулуун булчинг гялтангийн дээрх ёөхлөгөөс хуулан баруун тийш толинын тусламжаар туслагч татаж өгнө.

2-р үе. Гялтан хальсыг зайлцуулан, умайн доод хэсгийг ил гаргах

Энэ нь хэвлэйн гадуурхи кесар зүслэгийн хамгийн хариуцлагатай, мэс заслын үргэлжийн хувьд нилээд түвэгтэй үе юм. Давсагны баруун дээд талаар гялтангийн өөхлөгийн хамт зүүн тийш нь хуулах үед гялтан хальсны битүү нугалаас, мөн бор хүрэн өнгөтэй умайн доод хэсэг гэрэлтэн харагдана. Энэхүү битүү нугалаасыг гаргахын тулд мөхөн аргаар баруун зах хүртэл гялтанг хуулах шаардлагатай. Үүний үр дунд дээд талаараа гялтан хальсны битүү нугалаас, дотор талаараа давсагны ёрослын баруун дээд хэсэг, гадна талдаа умайн баруун хажуугаар хүрээлэгдсэн гурвалжин үснэ. Мэс засалч долосвор ба дунд хуруугаа давсаг умайн холбсоны чигт давсагны ёрослын доогуур оруулан гялтангийн битүү нугалаасыг гогцоодж умайн зүүн хажуу хүртэл хуулна. Ингэж хуулах үед гялтангийн битүү нугалаасыг толиж зүүн тийш нь болгоход умайн доод хэсэг ил харагдана.

3-р үе. Умайн доод хэсэгт зүслэг хийж, ураг авах

Хүүхэд хүлээн авах бэлтгэлийг хөнгөн дараа, гялтангийн бүтэн эсэхийг шалган цсурсон бол сёод умайн досод хэсэгт 2—3 см хөндлөн зүслэгийг усны хальс хүртэл болгоомжтой хийж, хсёр гэрийн долосвор хуруугаар хсёр тийш нь ургийн толгой багтахаар тэлж нээгээд усны хальсыг цоолно. Ураг гарахын өмнө мэс заслын шархыг чөлөөтэй болгохоос гадна дэвсаг гэмтэх, цус алдахаас нь урьдчилан сэргийлэх ач холбогдолтой. Ургийг авах үед Трендленбургийн байдлыг бөрчлөн орыг тэгшилсэн байвал зохино. Ураг толгойгоороо бол толгойноос нь, өгзгөөрөө бол цавынгас нь, хөл өгзгөөрөө бол хөл өгзгөөс нь татаж гаргана. Умайн досод хэсэгт зүссэн хөндлөн зүслэг нь ургийн толгойн их хэсгийн орчим таарсан бол ураг тун амархан гарна. Хэрэв ургийн толгойноос доогуур чигтэй зүсэгдсэн бол мэс засалч долосвор дунд хурууны тусламжтайгаар ургийн толгойг доошлиулах буюу эх брихын хавчуурын дэмжлэгээр ургийн толгойг гаргаж авна. Хүүхдийг авсны дараа умайн булчинд юмуу судсанд умай агашаах тария хийж, улмаар умайн зүслэгийн 2 үзүүрийн төгсгөл хэсэгт өлөн утсаар бариул хийж дээш татахад цус гаралт багасна. Дараа нь мэс засалч ихсийг шууд гараар авах, эсвэл хүйнээс нь аажим татаж гаргасны дараа умайн хөндийг гараар буюу том хусуураар шалгана.

4-р үе. Умайн шархыг оёж, хэвлэлийн хөндийг хаах

Умайн шархыг 2 шатлан оёно.

1-р шат умайн булчинг дотор талаас нь гадагш, гаднаас нь дотогш нэвт хатгаж өлөн утасны зангилаа умайн хөндийд бийхаар зангидаш шархыг битуулнэ.

2-р шат умайн булчинг оёсон эхний 1-р шатны оёдол далдлагдааар „П“ маягийн сёдлыг өлөн утсаар 2—3 удаа оёно. Дараа нь мэс заслын талбайн цус гаралтыг шалгаж цэвэрлээд гялтан хальс цоорсон эсэхийг дахин үзэж, гялтангийн битүү нугалаасыг байранд нь эргүүлэн тавиад хэвлэлийн ханыг үечлэн хаана. Боолт хааж шээсийг бургуйгаар авч үзнэ.

Мэс заслын үед цус алдвал цус сэлбэх ба умайн булчингийн агшилтыг сайжруулах зорилгоор агщаах чанарын эмийг хэрэглэнэ. Судалгаанаас үзэхэд ураг авах хүртэл мэс заслын үргэлжлэх хугацаа 10 минут, нийт 50 минут үргэлжилнэ.

Хэвлийн гялтангийн гадуурхи кесар зүслэгийн үед давсаг гэмтэх нь 1%, гялтан хальс цоорох нь 16,1% тохиолдоно. Мэс заслын үед гялтан хальсны битүү нугалаас буюу зах нь гүнд, давсаг нь хэт нимгэн байх зэрэг анатомын өөрчлөлт гарч болдог. Үүний зэрэгцээ булчин сулруулах эмийн тунг багадуулах, мэс заслын арга барил техник дутагдах зэргээс шалтгаалж давсаг гэмтэх, цус алдах, ургийн толгой багтаж гарахгүй бүтэх зэрэг хүндрэл тохиолдож болно. Ийм үед хэвлийн гялтанг нээж хийх кесар зүслэгээр мэс заслыг үргэлжлүүлж болно. Мэс заслын дараах эхний өдөр хэвлийн шархан дээр хүйтэн жин тавьж, өвдөлтийг намдаах эм хэрэглэхийн зэрэгцээ халдвар орсон буюу сэжигтэй гэж үзвэл антибиотик хэрэглэнэ. Шаардлагатай үед биеийн ерөнхий байдлыг засах эм шингэн хэрэглэж болно. Уушгинь цочмог үрэвслээс урьдчилан сэргийлж бумба гич тавих, амьсгалын дасгал хийх хэрэгтэй. Мэс засал хийлгэсэн эх гол төлөв өөрөө бие засах боловч энэ талаар байнга анхаарих нь зүйтэй. Заримдаа 5—6 цаг болоод шээсийг бургуйгаар авах шаардлага гарч болно.

Мэс заслын дараах 2 дахь өдөр гэдэсний саажилтаас урьдчилан сэргийлж саажилтын эсрэг эмчилгээ хийж, 3 дахь өдрөөс цэвэрлэгээ бургуйг өдөрт 2 удаа тавина.

Төрсөн эхийг эмэгтэйчүүдийн бус амин чухал эрхтэний хүнд өвчингүй үед мэс заслын дараа 6 цаг болгоод босгохыг зөвшөөрөх ба 6—8 цаг болгоод шингэн юм уулгаж, шингэн хоол өгч болно.

Мэс заслын дараах 8—9 дэх хоног дээр эмэгтэйчүүдэд зөвлөлгөө өгөх газрын хяналтанд гэрт нь гаргаж болно.

Төрөх газраас гэрт нь гаргах үед эх барихын дотуур үзлэг хийх бөгөөд хэрэв хэвийн байвал үмай нь хатуу хөндүүргүй хөдөлгөөнтэй 12—13 долоо хоногийн жирэмсэнтэй адил хэмжээтэй байна. Энэ үед гол төлөв баруун цавь орчим өөхлөг нь хатуурсан мэдрэмтгийг байна.

Хэвлийн гялтангийн гадуурхи кесар зүслэгийг хийх арга барил, нь харьцангуй түвэгтэй юм. Гэвч гадаадын хэвлэлийн мэдээ болон бидний клиникийн ажиглалтаас үзэхэд уг мэс заслын үед ургийн зунгаг ус, гаднын биет халдварт хэвлийн хөндийд орохгүй, гялтан хальсны цочмог үрэвсэл гарахгүй, умай нь сайн агшдаг, мэс заслын үргэлжлэх хугацаа, цус алдалт, гялтан хальсны цочролтоос болж үүсэх өвдөлт бага, шархны эдгэрэлт сайн, хэрэв шарх орчим идээлж буглаа үүсвэл идээр нь гадагш гардаг зэрэг сайн талтай болох нь харагдлаа. Уул мэс заслыг төрөх салбар амаржих газрын алинд ч нэвтрүүлэх боломжтой юм. Хэвлийн гялтангийн гадуурхи кесар зүслэг хийсэн эмэгтэйчүүдэд мэс заслаас шалтгаалсан өөрчлөлт одоогоор илрээгүй байна.

ТУРШЛАГА СОЛИЛЦЬЁ

Л. Н. ГИРЛЯ, Ш. ЖИГЖИДСҮРЭН, П. БАНЗРАГЧ, Х. РАГЧААСҮРЭН БЕТА РЕЦЕПТОР СААТУУЛАХ ЭМИЙГ ЗҮРХ СУДЛАЛЫН ПРАКТИКТ ХЭРЭГЛЭХ НЬ

УЛСЫН КЛИНИКИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

Орчин үед эмнэл зүйн практикт бета саатуулах үйлчилгээтэй индерал, обзидан, тразикор, анаприлин, вискен гэх мэт эмийг өргөнөөр хэрэглэх боллоо. 1964 онд даралт бууруулах эм гэж нээгдсэн индералаас уламжлан дээрх эмүүдийг практикт нэвтрүүлжээ.

Эдгээр эмийн бэлдмэлийг хэрэглэхээс арай өмнөхөн зүрхний булчинд адрен идэвхт системийн бета-рецептор байдгийг олж тогтоосон байна.

Бета-рецептор нь симпатик мэдрэлийн систем, катехоламины (адреналин, норадернали) нөлөөнд хариу урвал өгснөөр зүрхний нэг минутад агших тоо нэмэгдэж, давтамж нь олширч, булчингийн хүчилтөрөгчийн хангамжийг ихэсгэн, автомат ажиллагааг идэвхжүүлж, булчингийн сэрэх чадварыг дээшлүүлэн, зүрхний ажиллагааг хурдас гана. Бета саатуулах үйлчилгээтэй эмийн бэлдмэл нь зүрхний булчин дахь адрен идэвхт системийн бета-рецепторийн мэдрэг чанарыг багасгаснаар зүрхний агшилтын хүч, булчингийн хүчилтөрөгчийн хангамж буурч, нэг минутад агших тоог цөөрүүлж, автомат ажиллагаа болоод сэрэх чадварыг бууруулж, рениний идэвхжилийг сааруулан улмаар зах хязгаарын цусны эргэлтийн эсэргүүцлийг багасгана. Мөн зүрхний хэм алдагдлын эсрэг онцгой үйлчилгээг үзүүлдэг.

Зүрхний цусны тасалдал бах, хэм алдагдал даралт ихсэлт зэрэг эмгэг процессын үед судас тэлэх, даралт бууруулах эмийг хэрэглээд үр дүн өгөхгүй байгаа тохиолдолд бета-адрен саатуулах үйлчилгээтэй эмүүдийг эмчилгээнд хавсарган хэрэглэж болно.

Бета рецептор саагуулах бүлгийн эмийг хэрэглэснээс зарим нэг гаж нөлөө, тухайлбал зүрхний агших чадвар буурч, зүрхний доторхи ба тосгуур ховдлын сэрэл дамжуулалт удаашран, зүрхний цохилт цөөрч уушгины гуурсан хоолойн агчилт болж цусны даралт багасч болно. Иймээс энэ бүлгийн эмийг хэрэглэхдээ бүхнийг харгалзан үзэх шаардлагатай.

Улсын клиникийн төв эмнэлгийн зүрх-судасны тасагт 1981 онд зүрхний цусны тасалдал, бахтай 29 хүнд, цусны даралт ихсэх өвчний 1-р үе шатны 21 хүнд, мөн өвчний 2-р үе шатны 10 хүнд буюу нийт 60 өвчтөнд энэ бүлгийн эмийг хэрэглэв. Судалгаанд ихэвчлэн 30—40 наасны 26 залуу хүн, 41—55-тай дунд эргэм наасны 24 хүмүүсийг хамрав.

Өвчний үе шат, цусны эргэлтийн дутагдал, эсрэг заалтыг харгалзан бета саатуулагч бүлгийн эмээс тразикорыг эмчилгээнд голчлон хэрэглэв. Цусны эргэлтийн дутагдлын (ЦЭД) II-ын B, III үе шатанд тразикорыг хэрэглээгүй бөгөөд цусны эргэлтийн дутагдлын I ба II-ын A үед зүрхний гликозид, шээс хөөх эм, калийн давс, C. В бүлгийн витаминуудтай хавсарган хэрэглэв.

Эмийн тунг 40 мг-аар эхэлж, хоногт 60—120 мг хуртэл ихэсгэн эмчилгээг явуулав. Зүрхний цусны тасалдал, бах өвчнийг эмчлэхэд тразикорыг интенсаин интенкордин, коронтин, мөн никотины хүчил, сайдин, мисклерон, атероид, липамид зэрэг судас хатууралтын эсрэг эмийн бэлдмэлтэй хамт хэрэглэв.

Цусны даралт ихсэх өвчний үед тразикорыг дангаар нь хэрэглэхэд даралт бага зэрэг буурдаг боловч адельфен, допегит, раунатин зэрэг даралт бууруулах эмийг хамт хэрэглэхэд даралт хурдан бууж, өвчтөнд сайн тохирч байна.

Тразикорыг удаан хугацаагаар хэрэглэхэд 18 өвчтөнд гаж нөлөө гарснаас 10-т нь зүрхний цохилт цөөрч 7-д нь тосгуур ховдлын сэргээл дамжуулалт удааширсан ба нэг нвчтөнд тосгуур ховдлын сэргээл дамжуулалтын saatlyн 1-р үеийн хориг ажиглагдсан болно. Мөн 45 өвчтөнд хэрэглэхэд даралт бууруулахаасаа, судас тэлэх үйлчилгээг илүү узүүлж байлаа.

Бета-рецептор саатуулах үйлчилгээтэй эмийн бэлдмэл нь цусны даралт ихсэх өвчний эхний үе шат, зүрхний бахыг эмчлэхэд илүү үр дүнтэй болох нь бидний судалгаанаас харагдлаа.

Энэ булгийн эмээр эмчлэхэд ихэнх өвчтөнд зүрхний өвдөлт зүрхний бахын хурц хөдлөлийн үе дэх өвдөлт нэн их удалгүй дарагдаж, зүрхний цохилт олширч, агшилтын ээлж алдагдал арилсан бөгөөд даралт бууруулах бусад эмтэй хамт хэрэглэхэд даралт хурдан буурч байв.

Эмнэл зүйн эдгээр шинж тэмдгийн зэрэгцээ олонх өвчтөнд зүрхний цахилгаан бичлэгээр титмийн судасны цусны эргэлт сайжирч, Т шүдний вольтаж өгсөн хоёр үелсэн ба уруугаа харсан Т шүд арилж байсан зэрэг сайжралын динамик өөрчлөлт ажиглагдав.

ЭМНЭЛГИЙН ХЭВЛЭЛИЙН НЭГДСЭН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

- Ж. Раднаабазар (Эрхлэгч, доцент)
Л. Буджслв (Анагаах ухааны дэд эрдэмтэн)
Б. Гоош (Анагаах ухааны дэд эрдэмтэн)
Ж. Дашдаваа (Анагаах ухааны дэд эрдэмтэн)
Б. Дэмбэрэл (Анагаах ухааны дэд эрдэмтэн)
Г. Дашизвэг (Анагаах ухааны дэд эрдэмтэн)
Ч. Долгор (Анагаах ухааны дэд эрдэмтэн, профессор)
Ж. Купул (Анагаах ухааны дэд эрдэмтэн)
Э. Лувсандалгва (Анагаах ухааны дэд эрдэмтэн)
А. Ламжав (Эм зүйн ухааны дэд эрдэмтэн)
Л. Хүрэлбаатар (Хариуцлагатай нарийн бичгийн дарга)
П. Нямдаваа (Анагаах ухааны дэд эрдэмтэн)
Б. Рагчаа (Анагаах ухааны доктор, профессор)
Г. Цагаанхүү (Анагаах ухааны дэд эрдэмтэн)
Б. Шижирбаатср (Анагаах ухааны дэд эрдэмтэн)
Н. Шурх

Техник редактор А. Бямбажав Хянаагч Д. Болд

Өрөлтөнд 1983 оны 4-р сарын 1-нд орж, 2996 ш хэвлэв. Цаасны хэмжээ 70x108 1/16. Хэвлэлийн хуудас 4,0 х.н.х 5.6. А—89662 Зах № С—109

Д. Сүхбаатарын нэрэмжит Улсын Хэвлэлийн Комбинатад хэвлэв. Д. Сүхбаатарын талбай—6

Эх орны тайлбарийн шинэ эм

АЛОТАГАТ ТОСОН ТҮРХЭЦ

Химиин найрлага нь зуун настын био идэвхт хуурай экстракт, тарвага, тахайн тос зэрэг бодис агуулсан байдаг.

Алотагат нь цайвардуу шаргал өнгөтэй, сөврөмөц үнэртэй өтгөн тос юм.

Энэхүү тосыг цацраг тuyaаны эмчилгээний үед үүсэх гэмтлээс сэргийлэх зорилгоор хэрэглэнэ. Хэрэглэхдээ евчтөний биеийг тuyaаар шарсан хэсэгт нимгэн түрхэнэ. Шарлага эмчилгээ дууссанаас хойш 7—10 хоног үргэлжлүүлэн түрхэх шаардлагатай. Мен цацраг тuyaанаас гэмтсэн арьсыг эмчлэх зорилгоор хэрэглэнэ. Хэрэглэхдээ биеийн арьсны гэмтсэн хэсгийг уг тос шингээсэн марлиар ороож, боолтыг 2—3 өдөрт нэг удаа солино. Эмчилгээг 14—20 хоног үргэлжлүүлнэ.

Харин хорт хавдрын ил шарханд түрхэж болохгүй.

Тосыг бараан өнгийн шилэнд хийж сайн таглаад нарны гэрлээс хамгаалж сэргүүн газар хадгална.

ЧИГАТУССИН

Чигатуссин нь хар хүрэн өнгийн өтгөвтер шингэн. Өвөрмөц тансаг үнэртэй, чихэрлэгт амттай. Химиин найрлага нь чихэр сэвс, танганы ханд, аммоны бромид, сахарын шүүс зэрэг бодис агуулна. Хүүхдийн хөхүүлэг ханиад, архаг бронхит, шөнийн ханиад намдаах үйлчилгээтэй.

Хүүхдэд цайны халбагаар өдөрт 3—4 удаа 7—12 өдөр, архагшсан ханиадын үед 14—21 өдөр үргэлжлүүлэн ууна. Насанд хүрэгсэд хоолны халбагаар өдөрт 4 удаа ууна.

Нарны гэрлийн шууд тусгалаас хамгаалсан ердийн нөхцөлд хадгална.